МОНГОЛ УЛС
**ДАРХАН-УУЛ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГА**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059, Утас: 7037-7121,
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2024.12.13 № 1-10/798

танай ______________-ны № ____________________ т

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
ЯАМАНД

"Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт...57...хуудастай

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

4524101362

ZD-2024 toot-1

Хавсралт-1

## "ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| № | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв /сая.төг/ | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая,төг/ | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | Нийт хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Он | Түвшин | | | | | |
| | | | | | | | | | | **1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ** | | |
| 1 | 1.1. Эх хэл, түүх, өв соёлоо тээгч, хотын иргэн болгон төлөвшүүлж, хүүхэд, залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлнэ | 1.1.1 Үндэсний түүх, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | 2021-2025 | 2.4 | Түүх, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | 2020 | Илгээлтийн эзэд" төсөл хэрэгжүүлсэн. | Зөөвөрлөх болон тээвэрлэх боломжгүй уран баримлуудыг сэргээн засварласан байна. | | 2021 онд Дархан-Уул аймгийн түүх соёлыг сурталчлах зорилгоор "Илгээлтийн эзэд" төсөлд шаардлагатай бүтээл, баримтат өв 30-аад нэр төрлийн үзмэрийг бүртгэн авч, 2022 онд Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн 3,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Музейн үзүүллэгийн танхимд байрщдаг 14 уран баримлын сэргээн засварлалт хийж гүйцэтгэсэн. Музейн урд байрлах "Сарлаг унасан бүрээчин хүү" баримлыг Дарханы Зураач Урчуудын Эвлэлтэй хамтран сэргээн засварлав. Сэргээн засварлалт хийгдсэнээр үзмэрийн эх төрх, бүрэн бүтэн байдлыг хадгалан үлдээх, удаан хугацаанд хамгаалах нөхцөл бүрдсэн үзэгчдэд танилцуулахад илүү давуу талтай болсон.<br>ИТХ-ын 8 дахь удаагийн бүрэн эрхийн ээлжит бус 13 дугаар Хуралдаанаар Хонгор сумын нутаг Говил уулын орчмын 20 га талбайг Орон нутгийн хамгаалалтад авсан. Судалгааны баг малтлагын ажлаар 11 бунхант булш, 3 жирийн иргэний булш, 1 тахилгын байгууламжийг илрүүлсэн юм. 2023 онд дээрх судалгааны баг 3 сарын хугацаатай дахин малтлага хийхэд аймгийн орон нутгийн төсвийн 70.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Музейн үзүүллэгийн танхимд байрщдаг 14 уран баримлын сэргээн засварлалт хийгдэж, түүх соёлын дурсгалт үл хөдлөх газрыг орон нутгийн хамгаалалтад авсан.<br>Орхон суманд орших аймгийн хамгаалалттай үл хөдлөх 5 дурсгалт газрыг 2 малчин иргэнд, Хонгор сумын нутаг дэвсгэрт орших 23 үл хөдлөх дурсгалт газрыг 3 байгаль хамгаалагчид тус тус гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулж, сумын газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастрын зурганд тэмдэглэгээ хийлгэлээ.<br>**2024 онд:**<br>-Аймгийн Музейн сан хөмрөгт байгаа авдар, хул аяга, морин хуур зэрэг 3 үзмэрийг<br>СӨҮТ-д сэргээн засварлуулж сан хөмрөгт хүлээн авсан.<br>-Шарын гол сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт орших "Буган чулуун хөшөө" дурсгалыг Хайрхан багийн иргэн Д.Мядагсүрэн, "Найрамдал өндөрлөг" хөшөөг "Цэгц туургатан" ХХК-д эзэмшүүлж гэрээгээр хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулав.<br>-Дархан сумын 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох "Найрамдал" өндөрлөг, "Лимбэчин хүү", "Эх үрсийн элбэрэл", "Буга" баримал хөшөөг Дархан хотын соёл, амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-т гэрээгээр эзэмшүүлж, АЗДТГ, СУАЖЗГ хамтран 3 талт гэрээг байгуулав. Цаашид "Лимбэчин хүү", "Эх үрсийн элбэрэл" хөшөөний гадна өнгө төрхийг сэргээн засварлах 8.7 сая төгрөгийн төсвийг орон нутгийн 2025 оны төсөвт суулгуулахаар санал хүргүүлсэн.<br>-"Ачаа ачигч", "Мөнх найрамдлын тууль", "Мөнх найрамдал", "Давхарын өртөө", "Их нүүдэл", "Үйлдвэрийн Дархан" зэрэг 6 уран зургийг сэргээн засварлуулахаар соёлын өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу СӨҮТ-д актаар хүлээлгэн өгөөд байна.<br>- Хонгор сумын нутагт орших Богочийн хөтөл, Тракторын хөшөө, Чингисийн тулга, Атрын 20 жилийн хөшөө, Атрын 10 жилийн ойн хөшөө нийт 5 ширхэг Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд шинээр бүртгэв. Бүртгэлд 3 хөшөө дурсгал, 1 үйлдвэрлэлийн ул мөрийн дурсгал, хиргисүүрийг тус тус тусгай маягтын дагуу бүрдүүлэн ажиллаж, гэрэл зургаар баримтжууллаа.<br>- Аймгийн нутагт орших нурж унах эрсдэлд орсон 2, унаган газраас зөөгдсөн 2, | 100% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төв суурин газар, бүтээн байгуулалтад өртөж эх төрх нь алдагдсан 3, Улсын болон хөдөө орон нутгийн замд өртсөн 4, бичиж балласан, сийлж сүйтгэсэн 1, хадаг бөс даавуугаар ороосон, сүү тосны бохирдолд орсон 1 зэрэг ТСҮХД-ын мэдээллийг бэлтгэж СӨҮТ-д хүргүүлэв.<br>- Соёлын өвийн үндэсний төвөөс Дархан таван нуур ХХК-ийн ойролцоо Хүннүгийн үеийн булш байна гэсэн мэдээллийн дагуу Музей, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран тус газарт очиж 4 ширхэг 7*7 харьцах хэмжээтэй булшийг бүртгэн баримтжуулав. Соёлын Өвийн Үндэсний Төвд сэргээн засварлах шаардлагатай үзмэрийн судалгааг гаргаж, 35 дэсийн 38 ширхэг уран зураг засварлуулах хүсэлт хүргүүлсэн.<br>Үр дүн: 2024 онд Сэргээн засварлуулахаар илгээсэн 3 үзмэрийг хүлээн авч сан хөмрөгтөө хадгалсан. Сан хөмрөгт хадгалагдаж байсан 6 уран зургийг СӨҮТ-д илгээсэн. Эрсдэлд орсон аюултай түвшинд хүрсэн яаралтай хамгаалах шаардлагатай түүх соёлын үл хөдлөх 13 дурсгалын жагсаалтыг гарган СӨҮТ-д хүргүүлэв. Түүх соёлын 6 дурсгалт газрыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулав. | | |
| 2 | | 1.1.2 Эх хэл, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | 2021-2025 | - | Хадгалалт хамгаалалтыг сайжруулна. | 2020 | 7 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | "Оюунлаг Дарханчууд" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ | 27.8 | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 61 дүгээр тогтоолоор "Оюунлаг Дарханчууд-II" дэд хөтөлбөрийг 5 зорилт, 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, 2021 онд хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнд нийт 5000 гаруй иргэд хамрагдан, хөтөлбөрийн хүрээнд 3.3 сая төгрөгийг ОНТ-өөс зарцуулсан сан.<br>Хөтөлбөрийн хүрээнд 2022 онд зохион байгуулсан 6 төрлийн арга хэмжээ нийт 6800 гаруй хүнд хүрч, ОНТ-өөс 23,6 сая төгрөгийг зарцуулсан.<br>2023 онд "Оюунлаг Дарханчууд II" дэд хөтөлбөрийн I зорилтын хүрээнд 12, II зорилт-5, III зорилт-4, IV зорилт 8, V-3 нийт 5 зорилтын хүрээнд 34 үйл ажиллагаа зохион байгуулж, 8000 гаруй хүн хамрагдсан. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна. Хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймгийн төрийн байгууллагын хүний нөөц, архив, бичиг хэргийн ажилтнууд нийт 105 хүнд албан хэргийг монгол бичгээр хөтлөх сургалт зохион байгуулсан.<br>ЕБ-ын 25 сургуульд сэтгэн бодох 9 төрлийн чадварын дугуйланд 2230 сурагч, Биеийн тамирын 20 гаруй секцэд 2617 сурагчид хамрагдаж байна. ЕБ-ын 25 сургуульд бага ангийн сурагчдад шатрын дугуйлан хичээллүүлж, 960 сурагч хичээллэж, спортын мастер 1 төрөн гарлаа.<br>Хүүхдийг хөгжүүлэх клуб, дугуйланг дэмжин CALL FOR YOU хөтөлбөрийг 3 жил дараалан зохион байгуулж, нийт 75 хүүхэд хамрагдсан. Үйл ажиллагаанд ОНТ-ийн 17.0 сай төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>- 5-н зорилтын хүрээнд 34 үйл ажиллагааг зохион байгуулж, 4000 гаруй хүн хамрагдсан. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 98%-тай. "Оюунлаг Дархан", "Эх хэлний өдөр", "Угийн бичгээ хөтлөх вэ" хөтөлбөрүүдийн хүрээнд 64 арга хэмжээнд танхимаар 7196, цахимаар 16832 иргэнийг хамрууллаа.<br>- "Босоо заяатай монгол", "Буган чулуун хөшөө", "Аавын гутал" зэрэг3 хөшөөний орчин тойрныг цэвэрлэж, анхан шатны сэргээн засварлалт хийсэн.<br>- 2023 онд 10 өвлөн уламжлагчийг бүртгэл судалгаанд шинээр бүртгэн, 12 өвлөн уламжлагчийг ЗГХА СУГ-тай хамтран улсын үзлэг, судалгаанд хамруулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.<br>- "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцож шилдэг 5 аймгийн нэгээр шалгарсан.<br>Музейн 4 танхимд үзмэрийн ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, 358 дэсийн 518 гэрэл зургийг цахимд шилжүүлэн цахим архив үүсгэн, МУСГЗ, нэрт зураач Н.Цүлтэмийн "Уулзалт" уран зургийг судалж түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэр дэвшүүлсэн.<br>Нийт 88,2 сая төгрөгийн дэмжлэгийг ОНТ-өөс зарцуулсан байна.<br>**2024 онд** аймгийн хэмжээнд 90 өвлөн уламжлагч www.ich.mongoluv.mn улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байдаг ба үүнээс МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг зэрэг өвийг өвлөсөн Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумын харьяат 29 өвлөн уламжлагчид батламж гардуулав.<br>-ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд "Бий биелгээний шавь сургалтын танхим"-ын нээлтэд 12 СББӨ-ийг өвлөн уламжлагч болон Бий биелээчдийг хамруулав.<br>-"Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд 2024.05.29-нөөс 2024.06.04-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдах Хотон бий биелгээний шавь сургалтын бэлтгэл ажлыг хангаж, ЕБС-ийн бага, дунд, ахлах бүлгийн 11 сурагчдыг хамруулав.<br>- Дархан-Уул аймгийн хувь хүн, сүм хийдэд хадгалагдаж буй соёлын баримтат өвийг улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хамруулж бүртгэлжүүлэв. | 100% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Бүртгэлд: Зурмал зураг, Танка зураг, Ном судар, Гэрэл зураг, Ил захидал, Марк, Судар бичиг, Баримт бичиг, Мэргэний гуулин зоос зэрэг нийт 50 баримтат өвийг бүртгэл судалгаанд хамруулсан.<br>- Хараагийн Дара эх ламын Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж буй 53 дэсийн 61 ширхэг эд өлгийн зүйлсийг (цаасан хэлбэрээр) хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор бүртгэн баримтжуулсан. Үүнд: Шашны холбогдолтой үзмэр 47, урлаг уран сайхны холбогдолтой үзмэр 6-г тус тус бүртгэн баримтжуулж, тус хийдэд бүртгэлийн жагсаалт, ажлын тайланг хүлээлгэн өгч Хараагийн Дарь эх ламын Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж буй соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хэрхэн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх талаар<br>арга зүйн сургалтыг зохион байгуулав.<br>- "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Залуучууд театрын болон соёлын биет бус өвийн 30 өвлөн уламжлагч 17 удаагийн отгын тоглолт, их тайзны 1 удаагийн тоглолтод оролцож үндэсний өв уламжлалаа сурталчилсан байна. Тус фестивальд оролцоход Аймгийн ЗДТГ-ын газраас 28.0 сая төгрөгийг, ЗГХА- Соёл, урлагийн газраас 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.<br>**Эх хэлний чиглэлээр:** "Цогт хунтайжийн хадны бичээс"-ийн 400 жилийн ойг тохиолдуулан манай ХНО-оос ЕБС-ийн сурагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах, бийрийн бичлэгийг сурах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, бийрийн эрдмийн гайхамшгийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор VI-IX ангийн сурагчдын дунд бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулсан.<br>- "Хос бичигтэн" арга хэмжээний хүрээнд үндэсний бичиг үсгээ сурч эзэмшин түгээн дэлгэрүүлэх олон талт сургалт, үзэсгэлэн, нөлөөллийн 12 арга хэмжээнд 1092 иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулж, дэмжиж ажилласан. Монгол бичгийн цахим болон танхимын 6 сургалтад 123 хүнийг хамруулсан байна.<br>- "Хос бичигтэн-2025" эрдэм шинжилгээний хуралд ЕБС-ийн 32 багшийг хамруулсан.<br>- Соёл, урлагийн газар болон харьяа байгууллагууд нийт 62 албан бичгийг хос бичгээр үйлдэж Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн судалгаанд соёлын байгууллагын 116 албан хаагч, Монгол бичгийн танхимын шалгалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.<br>- Харьяа номын сангуудтай хамтран үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд "Бийрэн бичлэг", "Уран уншлага"-ын сургалт, уралдааныг 8 удаа зохион байгуулж 79 иргэнийг хамруулсан.<br>- Сурагчдын бийрэн бичлэгийн бүтээл болон 54 боть номоор үзэсгэлэн дэлгэж 62 сурагчийг хамруулав.<br>- Үндэсний бичгийн "Түргэн уншлага", "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэг, "Эх хэлээ эрхэмлье" сайхан бичгийн уралдаанд нийт 460 иргэнийг хамруулсан.<br>- Соёлын байгууллагууд "Хүмүн бичиг" сонинг улирал бүр захиалж өглөөний уншлага хийж хэвшсэн.<br>- "Үндэсний бичгийн хурдан уншигч" уралдаанд 12 албан хаагч хамрагдсан.<br>- Иргэдийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор цахимд 3 удаа нийтлэл оруулж 385 хүнд хүргэсэн.<br>**Үр дүн: Харьяа соёлын 6 байгууллага "Эх хэлний өдөр"-ийг тохиолдуулан нийт 8 арга хэмжээ зохион байгуулж 312 хүнийг хамруулсан. Үүнд: Төв номын сан 1 үйл ажиллагаанд 32 хүн, Хүүхдийн номын ордон 2 үйл ажилгаанд 128 хүн, Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвүүд 5 үйл ажиллагаанд 152 хүнийг тус тус хамруулсан байна.**<br>**Эх хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах чиглэлээр 38 удаагийн үйл ажиллагаанд 2631 хүн хамрагдсан байна.**<br>**Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч 29 иргэнийг алдаршуулан батламж гардуулсан. Нийт иргэн, сүм хийдэд байгаа 50 баримтат өвийг бүртгэл судалгаанд хамруулсан.** | | |
| 3 | | 1.1.3 Хүүхэд, залуучуудад эв нэгдлийг эрхэмлэсэн, эх оронч үзлийг төлөвшүүлнэ. | 2021-2025 | -<br>- | Хүүхэд, өсвөр үеийнхэнд хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 2020 | Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд 500 хүүхэд хамруулсан | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх онуудаас 40%-иар нэмэгдүүлнэ. | | Хүүхэд, залуучуудад эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг 2021 онд 3 төрлийн арга хэмжээнд 1150, 2022 онд 9 төрлийн арга хэмжээнд 10,561 хүүхэд залуучууд хамрагдсан нь хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оноос 60%-иар нэмэгдсэн байна.<br>- Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй алтан ургийн 37 их хаадын хөрөг үзмэрүүдэд түшиглэн **"Монголын Их Хаад"** боловсролын хөтөлбөрийг боловсруулж, Монгол бахархлын өдрөөр 5 сургуулийн сургуулийн 240 сурагчдад үзүүлсэн.<br>- **"Мөнх оршихуй-III"** бийрийн бичлэгийн уралдааныг зохион байгуулж багш, сурагчдын 42 бүтээлээр үзэсгэлэн гаргав. | 100% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | - "ДУА-ийн Хөгжлийн Бэрхшээлтэй Эцэг Эхчүүдийн Холбоо"-той хамтран 7 гэр бүлийн хүүхдүүдэд "Мандала" боловсролын хөтөлбөр, ээж нарт нь СББӨ-ийг өвлөн уламжлагч С.Одонцоо бий биелгээ зааж өв соёлоо түгээв.<br>- БТСГ-ын дэргэдэх Эцэг Эхийн Зөвлөлтэй хамтран тус байгууллагын албан хаагчдын 25 хүүхдэд "**Дархан-Миний хот"** Дархан хотын түүх, соёлын дурсгалтай танилцах аяллыг зохион байгуулав.<br>- Цэргийн штабтай хамтран аймгийн Засаг даргын нэрэмжит **"Бид эх орны ирээдүй"** хөтөлбөрийн хүрээнд эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулж эхний 10 байранд орсон сурагчдыг шагнав. ЕБС-ийн 70 гаруй багш, сурагчид оролцов.<br>- Соёл, урлагийн газар, БШУГ хамтран **Хүүхдийн гар урлалын бүтээлийн үзэсгэлэн** зохион байгуулав. /300 хүн хамрагдсан/<br>- **Жаран нэгэн сурагчийн бийрийн бичвэр**ийн үзүүлэх тоглолтыг зохион байгуулж Дархан хотын сүлд дуу "Хамгийн сайхан хот"-ын үгийг өөр өөрийн өнгө аясаар сэтгэмжлэн бичүүллээ. Мөн үеэр багш, сурагчдад бийрэн бичлэгийн хэрэглэгдэхүүн хүлээлгэн өгөв. - **"Шидэт модны үр"** хүүхдийн жүжиг нийт 30 удаа тоглогдож 9419 хүүхэд багачуудад үйлчиллээ. АЗД-ын захирамжаар 21.347.0 төгрөг Үлдэгдэл санхүүжилт орлогоос санхүүжсэн нийт төсөвт өртөг 37.893.800 төгрөг.<br>- **"Үлгэрийн ертөнц"** хүүхдийн контент 1 удаа зохион байгуулагдаж 500 хүүхэд хамрагдлаа. **"Өглөөний нар"** тайзны бүтээлийг 2 удаа тоглосон байна.<br>Хүүхэд, залуучуудад эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажилд 2021 онд 1150, 2022 онд 10,561 хүүхэд залуучууд хамрагдсан нь хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд өмнөх оноос 60%-иар нэмэгдсэн байна. Нийт 2021-2022 онд 11,711 хүүхэд, залуучууд хамрагдсан байна.<br>**2023 онд:** Аймгийн Музей нийт 13 боловсролын хөтөлбөрийг 204 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 11,781 хүүхдийг хамруулсан байна.<br>- Төв номын сан 3 боловсролын хөтөлбөрийг 55 удаа зохион байгуулж 1014 сурагч,<br>- Хүүхдийн номын ордон 3 боловсролын хөтөлбөрийг 23 удаа зохион байгуулж 1006 хүүхдийг тус тус хамруулсан.<br>- Эх оронч үзлийг төлөвшүүлэх нь уриан дор "Бид эх орны ирээдүй" өдөрлөгийг зохион байгуулж энэ хүрээнд нийт 10 арга хэмжээнд 500 гаруй сурагчийг, JCI Их Хүрээ салбараас санаачлан хэрэгжүүлсэн "MIND UPDATE" төслийн лекцэд 500 гаруй сурагч, Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран "Өв соёлоо өвлөн уламжилъя" Зүүороох хатгамлын сургалтад 20 сурагч, "Угсаатан бий" төслийн бий биелгээний сургалтад 29 хүүхэд, 2 хүүхдэд хурдан морины цол дуудах эрдэмд сургасан.<br>- "Соёлын өв" улсын эчнээ уралдааны II шатны шалгаруулалтыг 2023.05.12-ны өдөр аймгийн СУГ зохион байгуулж ЕБС-ийн XI, XII ангийн 6 сурагчийн эссэ бүтээлийг шалгаруулж III шатанд явуулснаас 2 хүүхдийн эссэ бүтээл шалгарч 3 дугаар байр эзэллээ.<br>"Соёлын эрхийн бичиг"-ийн хүрээнд соёлын 8 байгууллагын 18 хөтөлбөрт 1374 сурагчийг хамруулсан.<br>Хүүхэд, залуучуудад эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажилд 2021 онд 1150, 2022 онд 10,561, 2023 онд 16232 хүүхэд залуучууд хамрагдсан нь хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд өмнөх оноос 50%-иар нэмэгдсэн байна. Нийт 2021-2023 онд 27943 хүүхэд, залуучууд хамрагдсан байна.<br>**2024 онд:** Залуучууд театр, сумдын Соёлын төвийн дэргэд 18 дугуйлан хичээллэж 269 суралцагч хүүхдүүд хамрагдан хичээллэж байна.<br>➢ Шарын гол сумын Соёлын төвөөс зохион байгуулсан Шагайн харвааны тэмцээнд 24, чавх харвааны тэмцээнд 12, "Ерөөлтэй хүүхэд" тэмцээнд 297 хүүхэд тус тус оролцсон.<br>➢ Соёлын байгууллагууд хамтран 2024.05.08-12-ны хугацаанд "Эх оронч Дарханы ирээдүй" өдөрлөгийг 5 өдөр зохион байгуулж урлагийн тоглолт, лекц илтгэлээс гадна сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 555 боть номоор гаргаж, ахлах ангийн 123 сурагчдын дунд "АХА" тэмцээн, боловсролын хөтөлбөр зэрэг нийт 6 арга хэмжээнд 435 хүүхдийг оролцууллаа.<br>➢ Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын бүтээлч орон зайг бүрдүүлэх зорилгоор "Үгийн бичиг", "Даам тоглож сурцгаая" танхим, кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох орчин бүрдүүлсэн.<br>➢ "Хаврын номын баяр"-ын хүрээнд зарласан "Номын сайн нөхөр" улсын уралдаанд ЕБС-ийн сургуулийн 6 анги, уншигчийн материалыг хүргүүлж ажилласан. Уралдаанд "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон "Улсын Тэргүүний шилдэг уншигч хамт олон"-оор | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | шалгарч 2024.05.28-ны өдөр УБ хотноо "35 дахь Номын баяр"-ын нээлтийн үеэр УИХ-ын дарга Г.Занданшатараас шагналаа гардан авсан. Мөн аймгийн Засаг даргаас тус анги, хамт олныг "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" шагнаж урамшууллаа.<br>➢ Орон нутгийн судлаач, зохиолчдыг дэмжих чиглэлээр Төв номын сан, Хүүхдийн номын ордноос "Зохиолч уншигчдын уулзалт"-ыг *16* удаа зохион байгуулж 1560 гаруй сурагч, иргэдийг хамруулсан. Суманд 2 удаа зохион байгуулсан.<br>➢ "Зулзага" хүүхдийн зусланд амрагч хүүхдүүдэд соёлын өв, нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах зорилгоор соёлын 5 байгууллагын 13 соёлын боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж **1680** хүүхдийг хамруулсан.<br>➢ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр соёлын байгууллагууд 19 хөтөлбөрийг зохион байгуулж нийт 5000 гаруй хүүхэд, иргэдэд хүргэлээ.<br>➢ "Угийн бичгээ хөтөлцгөөе" сургалтыг нийт 22 удаа зохион байгуулж, 1367 хүүхэд,<br>➢ "Номтой аялал" арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 164 хүүхэд,<br>➢ "Номтой өдөр" арга хэмжээг 2 удаа зохион байгуулж СӨББ, ЕБС-ийн 214 сурагч<br>➢ "Эх хэлний дархлаа" үндэсний бичгийн уралдаанд 12 сурагч,<br>➢ "Уран жиргээ-2024" уралдаанд 84 сурагчдыг тус тус хамруулсан байна.<br>Үр дүн: 2024 онд Хүүхэд, залуучуудад эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээний хүрээнд 38 төрлийн боловсролын хөтөлбөрийг 586 удаа зохион байгуулж 17,858 хүүхдийг хамруулж, соёлын олон талт үйл ажиллагаанд 11,009 хүүхэд залуучуудыг хамруулсан байна.<br>Нийт соёлын үйл ажиллагаанд 28,867 хүүхэд, залуучуудыг хамруулснаар өмнөх оноос 55%-иар нэмэгдсэн байна. | | |
| 4 | | 1.1.4 Үндэсний соёлын онцлогийг харуулсан шинэлэг уран бүтээлүүдтэй болно. | 2021-2025 | 127.0 | Шинэлэг уран бүтээлийн тоо | 2020 | 1 | 4 | 127.0 | Найрамдлын хотын түүх, үе үеийн бүтээн байгуулалтыг шигтгэж өгсөн, ДАРХАНЫ гэсэн БРЭНД бүтээл "ДОМОГ АМИЛСАН НУТАГ" түүхэн дуулалт шинэ жүжгийг тайзнаа амилуулсан. Ийнхүү энэ бүтээл туурвилыг дэмжин Соёлын яам, соёл урлагийг дэмжих сангаас 27,0 сая, аймаг орон нутгаас 80,0 сая төгрөгөөр урамшуулсан.<br>Дархан хотын 60 жилийн ойд зориулан гаргасан "Хамгийн сайхан хот" теле кино концертыг шинээр тавьсан. Энэ концертыг Соёлын яамнаас 20.0 сая төгрөгөөр дэмжин урамшуулсан.<br>-**"Жаргалтай жарны дуулал"** концертыг 4 удаа тоглож нийт 3000 гаруй ард иргэдэд үйлчиллээ<br>- "Гүрэн" хамтлагийн **"Язгуур Монгол"** тайлан тоглолт 2 удаа тоглогдож 820 үзэгчдэд соёлын биет бус өв, язгуур соёлыг хүргэсэн.<br>-**"Мэндийн цэнхэр хадаг"** ардын зан заншил, СББӨ, язгуур урлагийн концертыг нэг удаа тоглож 588 үзэгч үзсэн.<br>-**"Нар наадсан монгол өргөө", "Адуу залуус 2"** уран бүтээлээр урын сангаа баяжуулсан. 2 удаа тоглогдож 1500 хүнд үйлчилсэн.<br>- Хонгор сумын Соёлын төв **"Цагаан сар"** теле концерт зохион байгуулсан. Нийт 6 уран бүтээл шинээр туурвиж, иргэдэд хүргэсэн.<br>**2023 онд** 1.Орхон сумын СББӨ-ийн 3 үеийн өвлөн уламжлагчид болон Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчдын хамтарсан "ЗАЛГАМЖ" тоглолтыг сумын 300 иргэнд толилуулсан.<br>2."Угсаатан бий" төслийн сургалтад хамрагдсан Залуучууд театрын 2 бүжигчний бий биелгээг клипжүүлэн МҮОНРТ -ээр цацуулж, олон нийтийн хүртээл болгосон.<br>3.Орхон сумын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн "Язгуур" хамтлаг "Наадан биелэе"-ээр урын сангаа нэмсэн.<br>4."Хөх тэнгэрийн орон" уран бүтээлийн тоглолтыг шинээр найруулан тавьж, 60 уран бүтээлч оролцон 2 удаа тоглогдож 1182 үзэгч үзсэн. Залуучууд театраас 7.0 сая, АЗДТГ-аас 53,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>5. Дархан магтаал, Золгох ерөөлийн дуунуудыг шинэчлэн бүтээсэн уран бүтээлийн зардалд ОНТ-өөс 1.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>6."Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Дархан-Уул аймгийн онцлог бүхий олон ястны язгуур урлагийн "Олон үндэстний дуулал" тоглолтыг 16 удаа тоглож 16,708 гаруй ард иргэдэд толилууллаа. Нийт 6 шинэ уран бүтээл туурвиж, 18190 хүнд хүргэсэн.<br>**2024 онд: Залуучууд театр нь** 53 урлагийн тоглолтыг 14,119 үзэгчдэд хүргэснээс өөрийн 3 шинэ уран бүтээлийг туурвиж, 1 уран бүтээлийг сэргээн тавьсан. Үүнд:<br>➢ Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 818 жил, | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жил, Дархан хот байгуулагдсаны 63 жилийн ойн баяр наадамд зориулсан "Өнөд өвлөгдөх аялгуу" хүндэтгэлийн концерт 2 удаа тоглогдож 1182 хүнд хүргэсэн. Нийт 32,668,200 сая<br>➢ Самуил Яковлевич Маршакийн зохиол, МУСТА Н.Баярцэнгэлийн найруулга Залуучууд театрын шинэ уран бүтээл " МУУРЫН БАЙШИН хүүхдийн драмын жүжигийг 23 удаа тоглож, 6800 хүүхдэд хүргэлээ. Улсын төсвөөс 40,0 сая<br>➢ Залуучууд театрын гоцлол бүжигчин МУСТА Бямбажавын Ариунжаргалын "ТЭНГЭРИЙН БҮЖИГ" уран бүтээлийн тоглолтыг 1 удаа тоглож 500 үзэгчдэд хүргэсэн.<br>➢ Залуучууд театрын гоцлол дуучин Д.Бибиш /СТА/-ийн "Дархан хүү" уран бүтээлийн тоглолтыг 2 удаа тоглож 1200 хүнд хүргэсэн.<br>➢ Залуучууд театр "Ардын дууны түрлэг" шинэ уран бүтээлийн контентыг DBS телевиз болон өөрийн цахим сайтад байршуулан нийт 3100 гаруй ард иргэдийн хандалтыг авсан байна.<br>**Орхон сумын соёлын төв:** 11 урлагийн тоглолтыг 1813 үзэгчдэд хүргэсэн байна. Үүнд: Үндэсний соёлын онцлогийг харуулсан шинэ уран бүтээл<br>➢ "Сэтгэлийн хэлхээ" концерт<br>➢ "Өв соёлоо дээдэлье" концерт<br>**Хонгор сумын соёлын төв:** 6 урлагийн тоглолтыг 577 үзэгчдэд хүргэсэн байна.Үүнд: Үндэсний соёлын онцлогийг харуулсан шинэ уран бүтээл<br>➢ "Сар шинийн хүндэтгэлийн тоглолт" шинэ уран бүтээлийг 105 хүнд толилуулсан.<br>**Шарын гол сумын соёлын төв:** 5 урлагийн тоглолтыг 24,670 үзэгчдэд хүргэсэн байна. Үүнээс: Үндэсний соёлын онцлогийг харуулсан шинэ уран бүтээл<br>➢ Сар шинийн баяраар "Тал нутгийн залуус", "Наргиант бий", "Тойрон бүжиг" бүжгийг шинээр тоглож 670 үзэгчдэд толилуулсан.<br>➢ "Наурыз"-ын баярын урлагийн тоглолтыг зохион байгуулж 1000 гаруй иргэдэд хүргэсэн.<br>"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Дархан-Уул аймаг 3 өдрийн турш ардын язгуур урлагийн отгын тоглолт, үзүүлбэрийг 17 удаа,"Олон үндэстний дуулал" их тайзны тоглолтыг 1 удаа тоглож 4691 хүнд толилуулсан байна.<br>Үр дүн: 2024 онд 75 урлагийн тоглолт тоглож үүнээс үндэсний соёлын онцлогийг харуулсан 9 шинэ уран бүтээлийг туурвин давхардсан тоогоор 45,870 үзэгчдэд хүргэсэн байна. | | |
| | **Зорилт:2 *Үндэсний Монгол хэл бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.*** | | | | | | | | | | | |
| 5 | 1.2. Үндэсний Монгол хэл бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ. | 1.2.1 Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлнэ. | 2021-2025 | - | Бүтээлч ажлын тоо, хамрагдалтын тоо | 2020 | 10 үйл ажиллагаа 35000 | 15 үйл ажиллагаа 40000 | - | МХУЗ-ын багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилээр боловсруулж, 2021-2024 онд нийт 44 удаа танхимаар, 3 удаа цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 4200 гаруй багш буюу МХУЗ-ын мэргэжлийн багш нар 100% хамрагдсан байна.<br>Монгол хэл бичгийн боловсролыг сурагчдад чанартай хүргэх "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" хэрэгжилтийн хүрээнд 2021-2024 онуудад 81 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүллээ. Үүнд: Аймгаараа "Хос бичигтэн" болох "Цахим орчинд монгол бичгээр бичицгээе" аян өрнүүлж, "Үндэсний бичиг үсгийн баяр", "Үндэсний бичиг-манай хамт олны өв соёл" , "Алтан үсгийн баяр", "Зүрхэнд мөнх эх орон" зэрэг тогтмол зохион байгуулдаг 14 төрлийн бүтээлч ажилд давхардсан тоогоор 6200 гаруй багш, 44628 суралцагч, 600 гаруй ажиллагсад хамрагдсан бол үндэсний бичгийн тайлант уншлагад ЕБС-ийн 6800 суралцагч, 350 гаруй иргэд, төрийн албан хаагч хамрагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилт төлөвлөлтийн дагуу үргэлжилж байна.<br>"Алтан үсгийн баяр" үндэсний бичгийн олимпиад өдөрлөгийг 22 жил тасралтгүй зохион байгуулж, 2021-2024 онд нийт 3460 сурагч, 196 багш, 123 иргэн хамрагдсан байна. "Үндэсний бичиг манай хамт олны өв соёл" уралдааны 4 жил дараалан зохион байгуулж, 2024 онд өргөжүүлэн төвийн бүсийн хэмжээнд зохион байгууллаа. Нийт 3 аймгийн 47 байгууллага хос бичигтэн хамт олон боллоо. "Цахимд монгол бичгээр бичье" аяныг 2021-2024 онд зохион байгуулж, ЕБС-ийн ахлах ангийн 840 гаруй сурагч бүтээлээ цахим орчинд түгээсэн.<br>Боловсролын байгууллагуудын удирдах албан хаагчид удирдлагын академийн төрийн албаны сургуулийн анхан, дунд, ахисан шатны цахим сургалтад хамрагдаж, 61 албан хаагч үнэмлэх авсан байна.<br>2023-2024 оны хичээлийн жилд Монгол хэл бичгийн шалгалтын дүнг ахиулахын тулд 6 удаагийн сорил, сургалт, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэхэд давхардсан тоогоор 5461 сурагч хамрагдсан байна. 12 дугаар ангийн сурагчдын хэл бичгийн чадварыг ахиулахыг зорьж ажилласнаар Монгол хэл бичгийн шалгалтад нийт 1127 сурагч шалгагдсанаас 1034 сурагч буюу 91,7% нь амжилттай шалгагдаж, 93 сурагч буюу 8,3% нь 400-аас бага оноо авч босго | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | онооr давж чадаагүй байна. Өмнөх оны дүнтэй харьцуулахад амжилттай шалгагдсан сурагчийн хувь 89.2-оос 91.7 болж 2.5 хувиар ахисан байна.<br>Үр дүн: 2021-2024 онд 81 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 27292 хүнийг хамруулсан. | | |
| 6 | | 1.2.2 Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ. | 2021-2025 | - | Монгол хэл, бичгийн хэрэглээний түвшин,% | 2020 | Албан хаагчдын 5% хувь нь Монгол бичиг хэрэглэж байна. | Монгол бичиг хэрэглэж буй албан хаагчдын тоог 40%-д хүргэнэ. | - | Монгол бичиг хэрэглэж буй албан хаагч, иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Насан туршийн боловсрол төвийн 15 багш сургагч багшаар бэлтгэж хөтөлбөр боловсруулж, төрийн 4 байгууллагын 140 албан хаагч /НДХэлтэс, Татварын хэлтэс, Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар/ сургалтад хамрагдсан.<br>ЕБС-ийн 1166, СӨББ-ын 326 багш, нийт 1492 багш, ажилтнаас 24 удаагийн сургалтад 538 багш хамрагдаж, үндэсний бичгийн анхан шатны сургалтад сууж чадваржсан. Үндэсний бичгийн чадварын түвшин тогтоох судалгааны дүнгээр 251 багш монгол бичгийн хэрэглээний дунд түвшний чадвартай гэж үнэлэгдсэн.<br>Монгол бичгийн үндэсний бичгийн анхан шатны сургалтад 136 байгууллагын 8000 хүн хамрагдсан. Дархан-Уул аймгийн төрийн болон төрийн бус өмчийн 26 сургууль, 100 байгууллагын бичиг хэргийн ажилтнууд нийт 126 хүнд албан хэргийг монгол бичгээр хөтлөх анхан шатны сургалт танхимаар зохион байгууллаа.<br>Дархан-Уул аймгийн төрийн өмчийн 15 сургууль, 26 цэцэрлэг, төрийн болон хувийн хэвшлийн нийт 36 байгууллага гадна болон өрөө тасалгааны хаягийг монгол бичгээр бичиж хаягжуулсан. 2021-2024 онд Аймгийн 42 байгууллага "Хос бичигтэн хамт олон" хамт болсон байна.<br>ЕБ-ын 24 сургууль, 40 цэцэрлэгийн 220 албан хаагч цахим болон танхимаар Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас,түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах сургалтад хамрагдаж, албан бланкийг монгол бичгээр бичих загвараа боловсруулсан байна. МХУЗ-ын 57 багшийг чадваржуулж, энэ үйл ажиллагаанд хамтран ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг сорих судалгаанд Дархан-Уул аймгийн нийт 4666 албан хаагчаас 3768 албан хаагч буюу 81.6% нь судалгаанд хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 53.8 хувь нь үндэсний бичгийг хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан байна. Мөн үндэсний бичиг мэддэг эсэх гэсэн асуултад маш сайн буюу сайн мэднэ гэсэн хариултыг 16,9 %, мэднэ гэсэн хариултыг 63,8% хариулсан 19,1% нь мэдэхгүй гэж хариулсан байна.<br>Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 80.5% монгол бичгийн унших бичих чадвартай, 53.8% төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөхөд бэлэн байна гэж үзэж байна.<br>- Соёл, урлагийн газар болон харьяа байгууллагууд нийт 22 албан бичиг, 8 албан хаагчийн нэрийн хуудас, ажлын үнэмлэх, байгууллагын хаягийг Монгол бичгээр үйлдэж хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Соёлын салбарын 154 албан хаагчдаас захиргааны 70 албан хаагч буюу 45% хувь нь монгол бичгийг хэрэглээндээ хэрэглэж хэвшсэн бөгөөд. Соёлын байгууллагын албан хаагчийн нэрийн хуудас, ажлын үнэмлэх, байгууллагын хаягийг Монгол бичгээр үйлдэж хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Хос бичгээр албан бичгээ хөтөлж байгаа 3 байгууллагын албан бичгийг Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан үзэсгэлэнд оролцуулсан.<br>Үр дүн: Иргэдийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Үндэсний бичгийн хичээлийг цахимаар 8 удаа явуулж, 2574 хүнд хүргэсэн. | 100% | 100 % |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлэн, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулна. | 2.1.1 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах, илрүүлэх ажлыг сайжруулна. | 2021-2025 | - | Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах, илрүүлэлт,% | 2020 | Артерийн гипертензи 98.5% Чихрийн шижин 94.5% Хөх 90.5% Умайн хүзүү 66.1%Элэгний эрт илрүүлэг 93.7%Сүрьеэ өвчний 10000 хүн амд ноогдох өвчлөлийн промилль- 11.0‰ | Артерийн гипертензи 99.0% Чихрийн шижин 98% Хөх 97% Умайн хүзүү 90% Элэгний эрт илрүүлэг 98% Сүрьеэ өвчний 10000 хүн амд ноогдох өвчлөлийн промилль 10.8‰ | - | 2021-2024 оны байдлаар Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт 18 дээш насны 64720 хүн хамрагдахаас 59801 хүн хамрагдаж хамрагдалтын хувь 92.4 байна. Урьд оны мөн үетэй харьцуулахад 8.9‰-иар нэмэгдсэн сайн үзүүлэлтэй байна. Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэг үзлэгт 40 дээш наны 33829 хүн хамрагдахаас хамрагдсан 31089 хүн хамрагдаж 91.9 хувь урьд оны мөн үетэй харьцуулахад 4.3‰-иар буурсан үзүүлэлтэй байна.<br>Элэгний эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 93.3 буюу урьд оноос 0.9% иар буурсан үзүүлэлтэй байна. Хөхний үзлэгийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь 93.3 буюу 3.6%-иор өссөн үзүүлэлтэй байна. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 69.5% урьд оны мөн үеэс 8.6%-иор өссөн сайн үзүүлэлтэй байна.<br>Сүрьеэгийн өвчлөлийн тохиолдол 94 бүртгэгдэж 10 000 хүн амд 8.7% байна. Энэ нь өмнөх оноос 0.1‰–иор өссөн байна.<br>. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн боловсруулсан цахим зөвлөмжийг 87 төрөл орон нутгийн хэвлэл мэдээлэл, цахим сайт 17 сувгаар 61 төрлийн шторк байршуулж, хандсан хүний тоо 142173 байна.<br>Үр дүн: Зонхилон тохиолдох Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад нийт 64327 хүн хамрагдсан | 90% | 70% |
| 8 | | 2.1.2 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээг авах орон нутгийн чадавхыг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 6,732.3 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээг авах орон нутгийн чадавхыг бэхжүүлэх сургалт, тоо | 2020 | 28 удаагийн сургалтанд 147 албан хаагч хамрагдсан. | Сургалтанд Хамрагдах албан хаагчдад сургалт зохион байгуулна. | 6,732.3 | 2021 онд ЭМЯ, ЭМХТ-өөс цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж Ковид-19 халдварт цар тахлын үед шаардлагатай мэргэжилтнүүдийг богино хугацааны сургалтанд бодлого зохицуулалтаар хамруулж бэлтгэж байна. Тухайлбал: Тархвар зүйч, Ковидын шинжилгээ хийх лаборант, ариутгагч тус бүр 2 нийт 3 суманд 18 эмч, ажилтан бэлтгэгдсэн. Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад 1396 эмч, тусгай мэргэжилтэн ажилладагаас ЭМЯ, ЭМГ-ын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Ковидтой холбоотой дотоодын дадлага сургалт, бусад эмч мэргэжилтнүүдийн чадавхижуулах ажлын байрны сургалтуудыг тасралтгүй зохион байгуулсан ба нийт 14 чиглэл, 43 төрлөөр 185 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 2926 хүнийг хамруулсан байна.<br>ДЭМБ, ЭМЯ-ны төслөөр "Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын эсрэг Дархан-Уул аймгийн хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх" ажлын хүрээнд нийт 4 удаагийн сургалтыг явуулж Аймаг, сумын онцгой комиссын гишүүд, ЭМГ, сум, өрх,НЭгдсэн эмнэлэг, Хувийн хэвшлийн эмч, мэргэжилтэн, ЕБС, СӨБ, их дээд сургууль, үйлдвэрийн эмч, эрүүл ахуйч, улаан загалмайн сайн дурын ажилтнууд зэрэг нийт 550 хүн хамрагдаж, ХӨСҮТ, НЭМҮТ, СЭМҮТ, Нийслэлийн түргэн тусламжийн төв, АШУҮИС, ШКТЭ-үүдээс ирж сургалтыг зохион байгуулсан<br>2022 онд Орон нутгийн түвшинд шинэ болон нутагшмал халдварын тохиолдол, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед хариу арга хэмжээг хамтран зохион байгуулах, үр дүнг үнэлэх, дүгнэх, сургамж, туршлагаа хэлэлцэх, хамтарсан хариу арга хэмжээг сайжруулах, халдвараас сэргийлэх хяналтын чиглэлээр мэргэжилтнүүдийг чадавхижуулах зорилгоор ЗӨСҮТ, аймгийн ЭМГ хамтран сургалт зохион байгуулсан. Сургалтанд ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ОБГ, МХГ, Мал эмнэлгийн газар, БОАЖГ, Өрхийн ЭМТ-үүдийн холбогдох мэргэжилтнүүд нийт 50 хүн оролцсон. Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг SARS-CoV-2 вирусийн омикрон BA4, BA5 хувилбараар үүсгэгдсэн халдварын улмаас үүсэх эрсдэл ямар вэ? гэсэн сэдвээр эрсдэлийг тодорхойлж ӨНДӨР эрсдэлтэй үнэлэгдсэн. Үнэлгээний үр дүнд цаашид хэрэгжүүлэх нийт 15 заалт бүхий үйл ажиллагаа, төлөвлөгөөний саналыг АОК-т хүргүүлсэн. Хэлэлцүүлэгт ЭМГ, ОБГ, МХГ, ХХААГ, ТХ, ЦГ, Статистикийн хэлтэс зэрэг 10 байгууллагын 15 мэргэжилтнүүд оролцсон. ХӨСҮТ-өөс эмч, мэргэжилтнүүдэд ТТӨ-ий эрсдэлийн үнэлгээ хийх арга аргачлал сургалтыг зохион байгуулж аймгийн томуугийн 9 тандалтын нэгжийн 5 жилийн томуугийн тоо баримт дээр тулгуурлан судалгаа хийж, PISA үнэлгээний босго үзүүлэлттэй болсон.<br>2023 онд Аймгийн Засаг даргын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гамшгаас хамгаалах стратегийн команд штабын сургууль болон Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт хийгдсэн. Үүнд: Нэгдсэн эмнэлэг хээрийн эмнэлэг дэлгэх, Хонгор сумыг нүүлгэн шилжүүлэх, өгөгдсөн цагийн байдалд ажиллах зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдсан.<br>Үр дүн: Гамшиг , нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, халдварт өвчний дэгдэлтийн үед ажиллах бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэж, чадавхижуулсанаар эрсдэлийн үнэлгээ хийж нөхцөл байдалд тохирсон хариу арга хэмжээ авах чадавх сайжирсан. | 100% | 90% |
| | | 2.1.3 Яаралтай тусламжийн | 2021- | 1,155.6 | Шаардлага хангасан автомашин, тоо | 2020 | 2 | 4 | 1,155.6 | Яаралтай түргэн тусламжийн тасаг 1 машин, Нэгдсэн эмнэлэг автомашин, Орхон сумын эрүүл мэндийн төв 1 нийт 3 автомашинаар парк шинэчлэл хийгдсэн. Түргэн тусламжийн авто машиныг үргэлж бэлэн байдалд байлгахын тулд эвдэрч | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | | чанар, хүртээмж, чадавхыг нэмэгдүүлнэ. | 2025 | | | | | | | гэмтсэн тохиолдолд сэлбэг хэрэгслийг шууд болон тендер зарлаж худалдан авалт хийж үйлчилж байна. 18,097.4 мянган төгрөгийн зардал гарсан.<br>Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлгийн гадна талд 40 автомашины зогсоолыг шинээр хийсэн. Нэгдсэн эмнэлэг БНСУ-ын Кёнги аймгийн буцалтгүй тусламжаар 2 ширхэг түргэн тусламжийн машин, ЭМЯ-аас 1 ш машин хүлээн авч парк шинэчлэл хийсэн байна. Гэрэлтэй ӨЭМТ СЗДТГ-аас prius 30 автомашин хандивласан. 2022 онд нийт 6 автомашинаар парк шинэчлэл хийсэн.<br>2023-2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар яаралтай тусламжийн 2ш авто машины худалдан авах ажилд 326.3 сая төгрөг батлагдсан. УТХО-аар 2024 онд 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Түргэн тусламжийн нэг авто машин, Кольпоскоп 1ком, Гүн хөлдөөгч 1ком, Эд эс усгүйжүүлэх дамжлагын аппарат 1 ком нийлүүлэгдсэн.<br>Үр дүн: 2024 онд Түргэн тусламжийн 1 авто машин, Туулах чадвартай түргэн тусламжийн 1 авто машин нийлүүлэгдсэн. | | |
| 10 | | 2.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалд хяналт тавьж, хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 9.0 | Цахим бүртгэлийн хяналт, тоо | 2020 | Burtgel.mohs.mn цахим бүртгэлтэй болсон. | Эм, эмнэлгийн хэрэгслийн цахим бүртгэлд 95-с доошгүй удаа хяналт тавина | 9.0 | 2021оны 1-р сараас burtgel.mohs.mn эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, дагалдах хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн хангамж нөөцийн мэдээг эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүд давхардсан тоогоор 240 удаа программд орлого зарлага шивж, Эмийн мэргэжилтэн программын орлого зарлагын шивэлтийн байдалд 98 удаа хяналт тавин ажилласан. Мансууруулах сэтгэц нөлөөт эмээр үйлчилж байгаа 3 байгууллага, анхан шатны ЭМБ-ын яаралтай тусламжийн эмийн хэрэглээнд дэмжлэгт хяналтыг 6 удаа хийж 11 төрлийн зөвлөмж өгч ажилласан. 42 эмийн санд Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, 8 төрлийн зөвлөмж өгч ажилласан.<br>Үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын нөөцийн бэлэн байдал хангагдсан | 100% | 100 % |
| 11 | | 2.1.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, ил тод, хариуцлагатай болгоно. | 2021-2025 | - | Иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлнэ. | 2020 | Амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь 89.1%-тай байна. Стационараар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь 88%-тай байна. | Амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь 95%-р хүргэнэ. Стационараар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь 95%-д хүргэнэ. | - | 2021 онд Нэгдсэн эмнэлэг, Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн амбулаторийн 1862, хэвтүүлэн эмчлэх тасагт хэвтэн эмчлүүлж буй 935 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Хэвтүүлэн эмчлэх үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлт 86,7% байгаа нь 2020 оны үзүүлэлтээс 1,3%-аар буурсан. Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 83,4% ба 2020 оноос 5,7%-аар буурсан үзүүлэлттэй байна.<br>2022 онд 4 ЭМБ-ын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 397 иргэнээс сэтгэл ханамжийн үнэлгээг авахад маш сайн 34%, сайн 55%, дунд 8.4% , муу 2.6% үнэлгээтэй байна.<br>9 ЭМБ-ын амбулаториор үйлчлүүлж буй 700 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн үнэлгээ авахад 59.6% нь 2 буюу түүнээс дээш удаа үйлчлүүлсэн, 40.4% нь анх удаа үйлчлүүлсэн байна. Сэтгэл ханамжийн үнэлгээ маш сайн 29%, сайн 48.6%, дунд зэрэг 17% үнэлгээтэй байна.<br>Үр дүн: 2021онд А/578тоот тушаал, эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам шинэчлэгдэн батлагдсанаар үйлчлүүлэгч QR уншуулан шуурхай, нээлттэй ил тод санал хүсэлтийг илгээдэг болсон. | 70% | 70% |
| 12 | | 2.1<br>.6 Бүсийн оношлогоо, эмчилгээний төвтэй болсон байна. | 2021-2025 | - | Оношилгооны төвийн барилгын ажил эхлүүлнэ. | 2020 | Судалгаа, зураг, төсөв хийгдсэн. | Оношилгооны төвийн барилгын ажил эхэлсэн байна. | - | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор орон нутагт "Оношилгоо, эмчилгээний төв" байгуулах саналыг 2021 онд Эрүүл яаманд санал хүргүүлсэн боловч бүсийн хэмжээнд Орхон аймагт байгаа учир дэмжигдээгүй. 2022 онд Дархан-Уул аймагт шинээр эмнэлэг байгуулахад Европын сэргээн босголтын банкны шинжээч аудиторын баг ирж ажилласан<br>Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Дархан-Уул аймгийн хүн ам механикаар 20% өсөж 2024 онд 127.0 мянган хүн амтай байхаар тооцоо гарсан. Иймд орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор Европын сэргээлт босголт банкны санхүүжилтээр Дархан-Уул аймагт шинэ жишиг Нэгдсэн эмнэлэг барих төслийн хүрээнд барилгын нийт талбай 29841м2 хүртэл, хэвтэн эмчлүүлэх орны тоо 250, нийт 33 үндсэн нэгжтэй байх саналыг аймгийн Засаг даргын 2023 оны 1-10/709 дугаар албан бичгээр Европын сэргээлт босголт банканд хүргүүлсэн.<br>Үр дүн: Улаанбаатар, гадаадын орон луу зорчиж эмнэлгийн тусламж үйлчилгээ авах иргэдийн урсгал буурна | 30% | 30% |
| 13 | | 2.1.7 Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, | 2021-2025 | 4,987.1 | Материаллаг баазыг бэхжүүлж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн байдал | 2020 | Материаллаг баазыг бэхжүүлж, 4-н төрлийн орчин үеийн дэвшилтэт техник, технологи | Материаллаг баазыг бэхжүүлж, орчин үеийн 10 дэвшилтэт техник, технолог | 4,987.1 | ЭМЯамны санхүүжилтээр 850,0 сая өртөг бүхий эмнэлгийн зориулалттай хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг ашиглалтад орсон. Нэгдсэн эмнэлэгт молекул биологийн лабораторийг ашиглалтад оруулж ПСР шинжилгээг автоматаар хийдэг болж, 41850 гаруй иргэнд шинжилгээ хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэргээн засах тасагт орчин үеийн стандарт хангасан 11 ширхэг тоног төхөөрөмжөөр хангасан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЭМЯ-аас оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах зорилгоор 64 зүслэгтэй орчин үеийн стандарт хангасан **компьютер томографын аппаратыг** тодосгогчтой | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ. | | | | | нэвтрүүлсэн. | нэвтрүүлнэ. | | зураг авах автомат төхөөрөмжийн хамт суурилуулан үйл ажиллагаанд оруулаа. Зөөврийн 2 рентген аппарат суурилуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ходоодны уян дурангийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан. "Эрүүл мэндийн дэмжих төв"-ийг улсын төсвийн 1850.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн засвар хийж 34 нэр төрлийн 95 ширхэг 796.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч суурилуулан 5 сараас үйл ажиллагаа эхлүүлсэн. Эрт илрүүлэг үзлэгт 18 дээш насны 67307 иргэн хамрагдахаас хамралт 5026 буюу 7.3%. Хавдрын сэжигтэй 29, Хавдрын урьдал 47, хавдар 8 илэрсэнг дээд шатлалын эмнэлэг рүү илгээсэн.<br>Халдварт бус өвчин 1272, Халдварт өвчин 110 илэрсэнг эмчийн хяналтад авсан байна.<br>2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөх ор 1 /ОНХС/, Нүдний офталмоскоп 1 ш, тонометр чихрийн шижингийн нүдний аппарат 1ш, каталик 4, Автоклав аппарат 1ш, Таазны гэрэл 1ш, хагалгааны урологын дурангийн багаж Дезерит ОУБ-аас, Норкозын аппарат 1ш, Хагалгааны гэрэл 2ш, Чихрийн шижингийн резинопатийн тусламжаар компьютер 1ш, Хөлний хүндрэл шалгах 1ш, Глюкогемоглобин анализатор 1ш, зөөврийн кварц 1ш, хагалгааны ор 2ш ирсэн байна. Нийт 12 төрлийн 17 ширхэг 194.361.400 тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>2021-2023 онд 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 64 зүсэлтэй орчин үеийн компьютер томографын аппарат, ходоодны уян дурангийн иж бүрэн тоног төхөөрөмж болон шаардлагатай 86 ш тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.<br>2024 онд УТХО-р 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлэгт 1ш автомашин, 25 нэр төрлийн нэн шаардлагатай тоног төхөөрөмж, Амин холбоо, Нос хот, Гэрэлтэй, МЭДС тоб, Түвшийн холбоо өрхийн эмнэлгүүдэд 35 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн ангиографийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/ 4.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил худалдан авах ажиллагааны газар зохион байгуулагдаж байна.<br>Үр дүн: 2024 онд 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нэн шаардлагатай 61 тоног төхөөрөмж нийлүүлэхээс 60 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. | | |
| 14 | | 2.1.8 Хавдраас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | 2021-2025 | - | Хамрагдсан хүн, тоо | 2020 | Хамрагдсан хүний тоо-4371 | 4450 хүн | - | 2021-2023 онд хорт хавдрын шинэ тохиолдол 756 бүртгэгдсэн. 2023 оны эхний 11 сараар 249 бүртгэгдсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 тохиолдлоор нэмэгдсэн. 2021-2023 онд хорт хавдрын улмаас нас барсан тохиолдол 522 бүртгэгдсэн. 2023 оны эхний 11 сараар 161, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор нэмэгдсэн. Хорт хавдрын шинэ тохиолдол 19.7% эрт үедээ, 80.3% хожуу үедээ оношлогдсон. 1115 иргэн хавдрын хяналтанд байна. Хөдөлмөр зохицуулалт хийгдсэн хүний тоо (2021-2023 онд нийт 198) Нийт хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо (2021-2023 онд нийт 4786) 2021-2023 онд нийт 66 хүнд хими эмчилгээ хийж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн А/360 дугаар тушаалын дагуу "Хавдрын эсрэг" арга хэмжээний төлөвлөгөө 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээний хэрэгжилт 94.6%-тай байна. 2021-2023 оны байдлаар зонхилон тохиолдох хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүн амд чиглэсэн сургалтаар 43571 хүнд сургалт зохион байгуулсан. Эмчийн ярилцлага 13 удаа, үйл ажиллагааны мэдээллийг 47 удаа, эрүүл мэндийн цахим зөвлөгөө ярилцлага 26 удаа тус тус бэлтгэн иргэдэд түгээсэн. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвөөс боловсруулсан 17 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийн 14 сувгаар түгээсэн.<br>Үр дүн: 56411 хүн цахимаар хандалт хийж мэдээлэл авсан. | 100% | 90% |
| Зорилт: 2.2 Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ | | | | | | | | | | | | |
| 15 | | 2.2.1 Ерөнхий боловсролын масс сургалтын чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Нийт судлагдахууний гүйцэтгэлийн дундаж,% | 2019 | 45.3%-с доошгүй | 70%-с доошгүй | - | БСШУС-ын сайдын 2019 оны А/35 дугаар тушаалын дагуу БҮТ-ийн зохион байгуулсан боловсролын чанарын үнэлгээгээр 38,1% гүйцэтгэлтэй шалгагдаж байсан бол 2021 онд БШУ-ны сайдын 2021 оны 5 сарын 21-ний өдрийн А/190, А/240 тушаалуудын дагуу үндэсний хэмжээнд БҮТ-өөс 2021.10.18-21 өдөр "Сургуульд суурилсан үнэлгээ"-ний шалгалтыг зохион байгуулсан ба уг шалгалтад давхардсан тоогоор VI-XII ангийн нийт 98939 сурагч хамрагдаж 45,3 хувийн гүйцэтгэлтэй шалгагдсан нь масс сургалтын чанар өмнөхөөс 7,2% өссөн дүнтэй байна.<br>Суралцагчдын агуулгын хоцрогдлыг тодорхойлж, масс сургалтын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, зайн сургалтын үе дэх бэрхшээлийг илрүүлэх зорилгоор 1–12 дугаар ангийн сурагчдаас түүврийн аргаар зохион байгуулсан оношлох үнэлгээний шалгалтад ЕБ-ын 8 сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын 50 хувь, 9 дүгээр ангийн сурагчид 100 хувь, 12 дугаар анги 50 хувь шалгагдсан ба улсад I байр эзэлсэн амжилт үзүүллээ. ЕБС-ийн багшийн ажлын үр дүн, гүйцэтгэлд тулгуурласан бодит урамшууллыг бий болгох зорилготой | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтад төрийн 15 сургуулийн 14523 сурагч шалгагдаж 901 багш үнэлэгдсэн ба I түвшинд-137 багш буюу 15,2%, II түвшинд-291 багш буюу 32.3%, III түвшинд-473 багш буюу 52,5% үнэлэгдлээ. Аймгийн нийт судлагдахууны гүйцэтгэлийн дундаж 73,7 хувьтай байгаа нь орон нутгуудын дунджаас 2 хувь, улсын дунджаас 1.2 хувиар илүү байна. Дээрх амжилтаараа УЛСАД V эрэмбэлэгдэж байна.<br>2024 онд сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр төрийн өмчийн 8 сургуулийн захирал, сургалтын менежер, Боловсролын гарын ахлах арга зүйч нараас бүрдсэн баг байгуулагдан ажиллаж байна.<br>Үр дүн: Багшийн хөгжил, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын сурлагын амжилт сайжирна. 2024-2025 оны хичээлийн жилд багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үр дүн гарна. | | |
| 16 | | 2.2.2 Цэцэрлэг, сургуулийн материаллаг баазыг нэмэгдүүлж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурах нөхцөлийг сайжруулна. | 2021-2025 | 90.4 | Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж , хүүхэд сурах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020 | 100 ортой цэцэрлэгийн 1 барилга, 18,16-р сургуулийн гадна биеийн тамирын талбайг тохижуулахад 1000.0 сая | СӨББ, ЕБС-ын материаллаг бааз, анги дүүргэлт, сурах орчин нөхцөлийг сайжруулахад зарцуулсан хөрөнгө 1100.0-с сая төгрөг доошгүй | 1189.9 | БШУГазарт БШУЯамнаас 3,2 сая төгрөгийн 2ш, НТБТ-д 24,8 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, техник хэрэгслийг, Сангийн сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар БСУГ-т 17,3 сая төгрөгийн, Од цогцолбор сургуульд 20,0 сая төгрөгийн, 4 дүгээр сургуульд 25,1 сая төгрөгийн, компьютер техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж цахим сургалт явуулах материаллаг орчныг бүрдүүлсэн.<br>СӨБ-ын хамран сургалт 89.6%-тай байна.<br>Аймгийн 4, 5, 7, 10, 12, 13, 15 дугаар цэцэрлэгүүдийн барилгын халаалт, цахилгааны монтажийг сэргээх засварын ажлыг нийт 476,887,451₮ төсөвт өртөгтэйгээр 4 компани гүйцэтгэж, 2022 оны 12 сард бүрэн дуусгалаа<br>ЕБС-ын анги танхим, багш нарын өрөөний тохижилт, тоног төхөөремжийн 640 сая төгрөгийн өртөг бүхий тендэр шалгаруулалт зарлагдаж, Голден ийгл стар ХХК 1829 ширээ, 3656 сандал нийлүүлсэн.<br>2023 онд Хонгор сумын Салхит багт 100 ортой цэцэрлэг УТХО 2,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй баригдаж байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>2021-2023 онд нийт цэцэрлэгийн 1 өргөтгөл, 2 цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орж, СӨБ-ын хүүхдийн хамрагдалт 95%-д хүрсэн.<br>2024 онд Дархан сумын 15 дугаар багт 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга УТХО 12.0 тэрбум төгрөгийн өртөгтэй баригдаж 2024 онд байнгын ашиглалтад оруулсан. Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн өргөтгөл 320 хүүхдийн сургуулийн барилга улсын төсвийн 7.4 тэрбум төгрөгийн өртөгтэйгээр баригдаж байнгын ашиглалтад орсон. Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил 2022-2025 онд баригдаж байгаа бөгөөд ажлын нийт гүйцэтгэл 45%, 2024 онд төлөвлөсөн ажил 100% хэрэгжилттэй байна. Улсын төсвийн 24.8 тэрбум төгрөгөөр 1500 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 2024 онд эхэлсэн бөгөөд ажлын явц нь 8% тай 2026 онд бүрэн ашиглалтад орно. Тус багт 150 ортой цэцэрлэг, Дархан сумын Малчин багт 100 ортой хүүхдийн эрчим хүчний өндөр хэмнэлттэй цэцэрлэгийн барилгын ажлууд 5% гүйцэтгэлтэй 2026 онд бүрэн ашиглалтад орно.<br>2024 онд 1 р сургуулийн урлаг заалны их засварын ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгийн 159.2 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2024 онд ОИЦ сургуулийн гадна тохижилтын ажлыг орон нутгийн төсвийн 98.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2024 онд 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 76.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2024 онд 30 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 68.3 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн бол 22 дугаар цэцэрлэгийн дээвэр засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 189.7 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өглөө.<br>Мөн политехник коллежийн өргөтгөлийн барилгын дээвэр засвар, Од цогцолбор сургуулийн А байр, ОИЦ сургуулийн Б байрны дээвэр засварын ажлыг орон нутгийн төсвийн 800,0 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Өвсний үндэс төслийн хүрээнд Дархан сумын 18-р сургуулийн дээвэр засварын ажилд 370.0 сая төгрөг, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 18-р сургуулийн спорт заалны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил ажил зохион байгуулагдаж байна.<br>Үр дүн: 2024 онд Од цогцолбор сургуулийн А байр, 9-р сургуулийн спорт заалны засварын ажил 100% хэрэгжсэн бол 4 , 18-р сургуулийн спорт заалны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил зохион байгуулагдаж байна. | 100% | 100 % |
| 17 | | 2.2.3 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын | | - | Сургалтанд хамрагдсан багш, тоо | 2020 | 850-с доошгүй | "Чадварлаг багш" төслийг хэрэгжүүлж, 1000-с | -. | Чадварлаг багш" төсөл 3 үе шаттай хэрэгжиж байгаа бөгөөд тайлант хугацаанд үе шат II хэрэгжиж байна. Энэ хүрээнд:<br>2021 онд аймгийн Засаг даргын захирамжаар "Чадварлаг багш" төслийг боловсруулан батлуулсан.<br>2022 онд 1500 гаруй багшийг 3 төрлийн сургалтад хамруулж, төслийн хэрэгжилт | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургуулийн багш нарын мэдлэг, чадвар, заах арга зүйг дээшлүүлнэ | 2021-2025 | | | | | доошгүй багшийг хамруулна. | | 50%-тай байна.<br>2023 онд Залуу багш нарт зөвлөн туслах ажлын хүрээнд МХБ-ийн Зөвлөх, Ментор багш нарын оролцоог нэмэгдүүлж давхардсан тоогоор 1674 багшид арга зүй, мэдлэг чадвар олгох 32 удаагийн сургалт зохион байгуулсан. "Багшийн хөгжлийн явцыг үнэлэх зөвлөл"-ийг МУ-ын зөвлөх зэрэгтэй 53 багшийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>ЭЕШ-д бэлтгэсэн сурагч нь амжилт гаргасан багш нарыг урамшуулж 2021 онд 5 багшид 2,5, 2022 онд 10 багшид 10,0, 2023 онд 23 багшид 20,0, 2024 онд 17 багшид 14,5 сая нийт 47.0 сая төгрөгийг 55 багшид урамшуулал олгосон.<br>ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдыг ЭЕШ-д бэлтгэх давтлагыг 2021 оноос 3 удаа зохион байгуулж, хичээл заасан багшид урамшуулал олгодог.<br>Англи хэлний багш нарыг чадавхжуулах, IELTS шалгалтад бэлтгэхэд 20 багшийг сонгон шалгаруулж, 3 сарын сургалт зохион байгуулан, сургалтын төлбөрт ОНТ-с 10,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.<br>Үндэсний хэмжээнд англи хэлний ментор багш 2, зөвлөх багш 9 нэмэгдсэнээр зөвлөн туслах багийн гишүүдийн тоо нэмэгдэж байна. Мөн "Чадварлаг залуус ирээдүй" ТББ-тай хамтран аймгийн боловсролын салбарт ажиллаж байгаа англи хэлний 152 багш нарыг чадавхжуулах, заах арга зүйг дээшлүүлэх "Beyond program" төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж 20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Үр дүн: 1 дүгээр сургууль Орон нутгийн хөрөнгө оруулалтаар багш ажиллагсад, сурагчдад зориулсан "Чийрэгжүүлэх танхим"-тай болсон. | | |
| 18 | | 2.2.4 Боловсролын байгууллагын багш, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 2021-2025 | - | Боловсролын байгууллагын багш ажилчдын нийгмийн асуудлыг сайжруулна | 2020 | ЕБ-ын 26 сургуулийн багш ажилчдын 94%-ийг, СӨБ-ийн 368 цэцэрлэгийн багш ажилчдын 95%-ийг тус тус эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц шинжилгээнд хамруулсан | Орон сууцны хангамж, амьжиргааны түвшний талаарх судалгаа гарсан байна. | | Боловсролын байгууллагын багш ажилчдын нийгмийн асуудлыг сайжруулах хүрээнд орон сууцны хангамжийн судалгааг гаргасан. Төрийн өмчийн 30 цэцэрлэгийн 888 багш ажилтнаас өөрийн эзэмшлийн байранд 767, бусдын түрээсийн байранд 76, бусдын түрээсгүй байранд 45 багш ажилтан буюу 13,6% нь өөрийн эзэмшлийн байргүй байна.<br>Төрийн өмчийн 17 сургуулийн 1416 багш ажилтнаас өөрийн эзэмшлийн байранд 1075, бусдын түрээсийн байранд 214, бусдын түрээсгүй байранд 127 багш ажилтан буюу 24,0% нь өөрийн эзэмшлийн байргүй байна. Аймгийн Засаг даргын санаачилгаар боловсролын салбарын 10 багш ажилтнуудыг түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулж байна.<br>Аймгийн Засаг даргын санаачилсан "Түр орон сууц хөтөлбөр"-ийг төрийн өмчийн СӨББ, ЕБС-д гэр бүлээрээ ажилладаг залуу багш нарын дунд хэрэгжүүлж, шаардлага хангасан 10 гэр бүлийг 3 жилийн хугацаанд түр орон сууцаар хангасан.<br>Үр дүн: Дархан-Уул аймгийн боловсролын салбарт ажиллаж байгаа 1861 багш, ажилтнаас эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 2024 оны 11 сарын байдлаар хамрагдвал зохих 907 багш ажилтнаас 630 нь шинжилгээнд хамрагдсан. | 70% | 70% |
| 19 | | 2.2.5 Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан, байршлыг оновчтой тогтоож, сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлэн, анги, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэнэ | 2021-2025 | - | Шинээр ашиглалтад орсон сургууль, цэцэрлэг, тоо | 2020 | 100ортой 1 цэцэрлэг ашигтад орж 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж, 480 хүүхдийн сургуулийн барилга баригдаж байна. | 100 ортой 2 цэцэрлэг ашиглалтад оруулж 480 хүүхдийн сургууль, 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга шинээр барьж ашиглалтад оруулна. | 8168,7 сая | 2021 онд Өргөө багт шинээр 100 ортой цэцэрлэг барьж ашиглалтад оруулсан. Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийг өргөтгөлийн ажлыг Улсын төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан. Дархан сумын 4 дүгээр сургуулийн өргөтгөл 480 суудалтай сургуулийн барилга баригдаж ашиглалтад оруулсан.<br>Дархан сумын 7 дугаар цэцэрлэгт "Сонсголгүйн боловсрол" ТББ-ын 26,0 сая төгрөгийн санхүүжилтээр сонсголын бэрхшээлтэй болон аутизмтай хүүхдийг хамруулах "Тэмүүлэл-3" бүлэгтэй болж, тусгай хэрэгцээт бүлгийн тоо нэгээр нэмэгдсэн.<br>2022 онд эхэлсэн Дархан сумын 12-р баг 9-р сургуулийн 320 суудалтай барилгын өргөтгөлийн ажил 100 хувь дууссаж 2024 онд байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөл нь 45мх21м хэмжээтэй 2 давхар 2700м2 талбайтай 2022-2025 онд төлөвлөсөн Барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй, төсөвт өртөг 5.4 тэрбум төгрөг.<br>Хонгор сумын Салхит багт 100 ортой цэцэрлэгийн барилга барих ажлыг 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж байнгын ашиглалтад хүлээн авсан. 2024 онд Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн өргөтгөл 320 хүүхдийн сургуулийн барилга 7.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга баригдсан. 2024-2026 Улсын төсвийн 24.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1500 суудалтай сургуулийн барилга, Орхон суманд 480 суудалтай сургуулийн барилга, төсөвт өртөг 11.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлууд 10-15% гүйцэтгэлтэй баригдаж байна. 2026 онд бүрэн ашиглалтад орно. Дархан сумын 9-р багт ОИЦ сургуулийн өргөтгөл 960 суудалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж байна. Дархан сумын 2, 14, Малчин багт баригдах 3-н цэцэрлэгийн барилга барих гүйцэтгэгч сонгон шалгарч барилга угсралтын ажил | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 2-10% гүйцэтгэлтэй байна. 2026 онд бүрэн ашиглалтад орно.<br>**Үр дүн: 2024 онд эхэлсэн 3-н сургуулийн барилга, 3-н цэцэрлэгийн барилга 2024-2026 онд бүрэн хэрэгжиж ашиглалтад орно. Нийт төсөвт өртөг 68.7 тэрбум төгрөг** | | |
| 20 | | 2.2.6 Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадал, бүтэц, хэв шинжийг өөрчилж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 9,500.0 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2020 | 480 хүүхдийн хүчин чадалтай 4-р сургуулийн барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлсэн. 6-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил дууссан. | 960 хүүхдийн эко сургууль, 100 ортой 3 цэцэрлэг, Спорт заал 2 ашиглалтад оруулна. | 9,500.0 | 960 хүүхдийн эко сургууль:<br>1. Азийн хөгжлийн банкны 12.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 15 дугаар багт 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдан, аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/341 дүгээр захирамжаар 2024 оны Дархан сумын Ерөнхий боловсролын "31 дүгээр сургууль" нэршил олгосон. 2024 оны 09 дүгээр сард хичээлийн нээлт хийж үйл ажиллагаа эхэлсэн.<br>100 ортой цэцэрлэгийн барилга шинээр:<br>1. Дархан сумын Өргөө багт 100 ортой цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орсон,<br>2. Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийг өргөтгөлийн барилга 2021 онд ашиглалтад орсон,<br>3. Хонгор сумын Салхит багт 100 ортой 32 дугаар цэцэрлэг ашиглалтад орсон,<br>Спорт заал шинээр:<br>1. Хонгор сумын Салхит багт 648м$^2$ Спорт заал Улсын төсвийн 986.2сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон,<br>2. Дархан сумын Өргөө багийн нутаг дэвсгэрт 1816.5м2 талбай бүхий 2 давхар Спортын ордон шинээр ашиглалтад орсон.<br>**Үр дүн: 2021-2024 онд 960 хүүхдийн эко сургууль, 100 ортой 3 цэцэрлэг, Спорт заал 2 ашиглалтад орсон.** | 100% | 100 % |
| 21 | | 2.2.7 Цахим, зайн сургалтын платформыг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ. | 2021-2025 | - | Цахимд байршуулсан даалгаврын эзлэх хувь, % | 2020 | 55.0% | 60.0% | 87.5 | Цахим даалгаврын сан бүхий www.edu-test.mn цахим хуудсыг 2019 онд ашиглалтад оруулж, 2021 онд Цахим даалгаврын санд 21000, 2022 онд 11678, 2023 онд 24048 даалгавар оруулсан.<br>2024 оны хичээлийн жилээс шинээр Боловсролын Ерөнхий газрын medle.mn сайт нээгдсэнээр Цахим даалгаврын санг хэрэглэхээ больсон. Тиймээс даалгавар нэмэгдэх боломжгүй болсон.<br>Сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулж УТХО 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр төрийн өмчийн 17 сургуулийн 19 танхим цахим болсон. ЕБС-ийн багш нарыг компьютержуулах хөтөлбөр амжилттай хэрэгжиж, төрийн өмчийн 14 сургуулийн 801 багш буюу нийт багш нарын 90% нь компьютерээр хангагдсан.<br>**Үр дүн: 2024 онд Төрийн өмчийн 17 сургуулийн 19 танхим цахим болсон.** | 100% | 100 % |
| 22 | | **2.2.8 Их дээд, мэргэжлийн сургуулиудын хүрээг тэлж, ажил олгогчдын захиалгад нийцсэн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж, бэлтгэнэ.** | 2021-2025 | 3.0 | Монгол улсын Засгийн газрын 293 дугаар тогтоолын хэрэгжилт,% | 2020 | **тогтоолын 3.5 дахь хэсэгт Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль болгон өөрчилсөн** | **ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль байгуулах** | 3.0 | **Монгол улсын Засгийн газрын 293 дугаар тогтоол болох төрийн өмчийн зарим боловсролын сургалтын байгууллагын талаар авах арга хэмжээний тухай тогтоолын 3.5 дахь хэсэгт Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль болгон өөрчилсөн, уг тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор салбар сургууль байгуулах ХААИС-ийн захирлын** 2022 оны 10 дугаар сарын 20 ний өдрийн А/241 дугаар тушаалын дагуу ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль нь ХААИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн статустайгаар үйл ажиллагаа явуулж байна. **2023-2024 оны хичээлийн жилд 387 оюутан, 2024-2025 оны хичээлийн жилийн байдлаар 18 мэргэжлийн 557 оюутантай хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна.**<br>**ХААИС-ийн хичээлийн байрны засвар 2,8 тэрбум төгрөгийн төсөв өртгөөр хийгдэж улсын комисс ажиллаж 2024 онд байнгын ашиглалтад оруулсан. 2023 онд ШУТИС-ийн дотуур байрны засвар 300 сая төгрөгийн төсөв өртгээр хийгдэж улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. Мөн АШУИС-ийн спорт заал 1,2 тэрбум төгрөгийн өртөгтэй баригдаж байгаа бөгөөд барилгын ажлын явц 100%-тай 2024 онд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан бол тус сургуулийн хичээлийн байрны засварын ажлыг улсын төсвийн 700 сая төгрөгийн өртөгтэй засварлаж 2023 онд байнгын ашиглалтад оруулсан.**<br>**ХААИС болон ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн хамтарсан ажлын хэсэг цаашид сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.**<br>**Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.5.3.Төвийн бүсэд Хөдөө аж ахуйн их сургуулийн нэгдсэн хотхон байгуулна туссан. 2024 онд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Хүнс хөдөө аж ахуйн яам Дархан-Уул аймагт шилжин ажиллаж байна.**<br>**Үр дүн: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөрт туссанаар Хөдөө аж ахуйн их сургууль орон нутагт шилжинэ.** | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Зорилт: 2.3 Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.** | | | | | | | | | | | |
| 23 | 2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжинэ. | 2.3.1 Хүүхдийн авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлэхэд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 22.0 | Хамрагдсан хүүхэд% тоо | 2020 | 1562 | 2000-с доошгүй | 22.0 | Хүүхэд өсвөр үеийнхний амралт чөлөөт цаг, хөгжих, оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, хүүхдийн зөвлөл болон оролцооны байгууллагаар дамжуулж, спорт, урлаг, уралдаан тэмцээн, зөвлөгөөн, уулзалт хэлэлцүүлэг чуулганд 2039 хүүхдийг, амьдрах ухаан, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 1300 хүүхэд, үе тэнгийн сургагч багшаар дамжуулж 12164 хүүхдийг, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг "Найз байя" сургалт нөлөөллийн 5171 хүүхдийг, "Сансарын 7 хоног" хөгжлийн хөтөлбөрт 2053, Unitel HUB төвөөр дамжуулж 4 төрлийн хөтөлбөрт 1420 хүүхэд нийт 26 төрлийн үйл ажиллагаанд 24147 хүүхдийг оролцуулсан.<br>Хүүхдийн зуслангийн багш нарыг чадавхжуулах сургалтад 18 багш, хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 442 насанд хүрэгчийг оролцуулсан.<br>Зорилтод бүлгийн 38 хүүхдийг дугуйлан секцэд хамруулж, Орхон сумын сургуулийн 150 хүүхэд, 1-р сургуулийн 60 хүүхдийг хүүхэд хөгжлийн хөтөлбөрт хамруулсан. Хүүхэд хамгааллын зардлаас 11,4 сая төгрөг зарцуулсан.<br>Улсын төсвөөс 25,1 сая төгрөг зарцуулсан.<br>Үр дүн: Хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 30,261 буюу нийт хүүхдийн 79.4 хувийг хамруулсан. | 100% | 100 % |
| 24 | | 2.3.2 Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлнэ. | 2021-2025 | 22.7 | Зохион байгуулсан нийт арга хэмжээ, хамруулсан хүний тоо, хувь | 2020 | 18 үйл ажиллагаа, 5000 | 20 үйл ажиллагаа, 6000-с доошгүй | 22.7 | Гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг ажиллах Дархан, Орхон, Хонгор, Шарын гол суманд нийт 26 хамтарсан баг үйл ажиллагаа явуулж, энэ онд 270 кейстэй ажиллаж, 258 кейсыг бүрэн шийдвэрлэж хаасан, 12 кейс ажиллагаанд байна. Нийт 270 хүүхдэд, 131 насанд хүрэгчдэд гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрлөөр авч үзвэл: 78 хүүхдэд эрсдэлийн үнэлгээ хийж, сэтгэл зүйн үйлчилгээг 34 удаа, эрх зүйн туслалцаа 49 удаа, холбон зуучлах үйлчилгээг 17 удаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 44 тус тус үзүүлсэн байна.<br>- Шуурхай тусламжийн үйлчилгээ, Гэр бүлийн болон гэр бүлээс тусдаа орчинд, нөхөн сэргээх үйлчилгээг 937 хүүхдэд үзүүлж, хамтарсан багийн кейс шийдвэрлэлтэд 19.9 төгрөгийн санхүүжилт олгосон.<br>- Урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүрээнд сургалт, нөлөөллийн 12 удаагийн арга хэмжээнд 4624 иргэнийг хамруулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ.<br>- Хүүхэд хамгааллын үйлчилгээг эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээнд "Галт шувуу" ТББ хамтран гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчтой ажиллах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх "Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт"-ыг зохион байгуулж, Дархан, Орхон, Хонгор, Шарын сумдын 26 хамтарсан багийн 104 гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.<br>Үр дүн: Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр нийт 26 арга хэмжээ зохион байгуулж, 10948 хүнд хүрч ажилласан. | 100% | 100 % |
| 25 | | 2.3.3 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | 2021-2025 | 47.4 | Хөгжлийн төвийг ашиглалтад орсон эсэх<br>Тийм 1<br>Үгүй 0 | 2020 | "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2021 оны 6 дугаар сард эхлүүлсэн | 1 | 47.4 | "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 13 төслийг дэмжиж 27,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг ХЭДСангаас олгож 19 байнгын ажлын байрыг бий болгосон.<br>- Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээнд 53 ахмадын ирүүлсэн төслөөс 51 ахмад хамрагдаж 14.2 сая төгрөгийн урамшууллыг олгосон. "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэгт 6 иргэнийг хамруулж 21.5 сая төгрөг. 2021 онд 41,2 сая, 2022 онд 21.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2021 оны 6 дугаар сард эхлүүлж, 2022 оны 12 дугаар сард бүрэн ашиглалтад хүлээлгэн өгсөн. Хөгжлийн төв нь 31 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр батлагдаж, 14 боловсон хүчнийг төслийн нэгж болох ХНХЯ-аас төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэл засалч, нийгмийн ажилтан, хөдөлгөөн засалч, технологичийн чиглэлээр мэргэшүүлэн сургаж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хүртээмжтэй орчин бий болгох, стандартын хэрэгжилтийг хангуулахаар "Тэргэнцэртэй иргэдийн холбоо" ТББ-тай хамтран 16 аж ахуй нэгж байгууллагад үнэлгээ хийж, 128 байгууллагад албан бичиг хүргүүлж, 142 аж ахуй нэгж байгууллага хэрэгжилтийг хангасан. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барьж 2023 оны I улиралд бүрэн ашиглалтад оруулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа- | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ны хүрээнд:<br>Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг цахимаар 92 иргэн ирүүлж газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг 3 удаагийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 31 иргэнд 248,000,000 төгрөг олгож 53 байнгын ажлын байр бий болсон -Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 1 ахмад хамрагдан түр ажлын байраар 38,520,000 төгрөгийн урамшуулал авч, Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 1 ахмад ажилаж 1,800,000 төгрөгийн урамшуулал олгожээ.<br>- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг 94 ахмад цахимаар ирүүлж газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг 3 удаагийн сонгон шалгаруулалтад оруулж 50 ахмадад 400,000,000 төгрөг тус тус олгож 50 ажлын байраар хангагдсан.<br>Үр дүн: 135 иргэнийг төсөл арга хэмжээнд хамруулж, байнгын болон түр ажлын байраар хангаж 688.3 сая төгрөг зарцуулсан. | | |
| | **ГУРАВ: АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | | | | | | | | |
| 26 | 3.1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг үндэслэж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | 3.1.1 Мэргэжлийн байгууллагууд тай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | - Мэргэжлийн байгууллагуудта й хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2020 | Аймгийн хэмжээнд 1600 ажлын байр бие болсон. | Аймгийн хэмжээнд 3000 ажлын байр шинээр бие болгоно. | | Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын зээл, тусламж, бүтээн байгуулалт, Засгийн газрын тусгай сангууд, бусад хөтөлбөр, төслийн хүрээнд бий болсон 2100 ажлын байрыг бүртгэж, мэдээлсэн.<br>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил олгогчийн ирүүлсэн захиалгад үндэслэн 1350 иргэнийг тохирох ажлын байранд зуучилж, Хөдөлмөрийн зах зээлийн байнгын ажлын байр 1150, түр ажлын байр 200 бий болсон.<br>Шинэ ажлын байр тоо 5870, ажилд зуучлагдсан иргэний тоо 4563, 16,800.0 мянган төгрөг зарцуулсан.<br>Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, Олон улсын байгууллагын зээл, тусламж, бүтээн байгуулалт, Засгийн газрын тусгай сангууд, бусад хөтөлбөр, төслийн хүрээнд бий болсон 2200 ажлын байрыг бүртгэж, мэдээлсэн.<br>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил олгогчийн ирүүлсэн захиалгад үндэслэн 1400 иргэнийг тохирох ажлын байранд зуучилж, Хөдөлмөрийн зах зээлийн байнгын ажлын байр 822, түр ажлын байр 79, улирлын ажлын байр 43 бий болж өмнөх оныхоос шинэ ажлын байр 125, ажилд зуучилсан 52-оор нэмэгдсэн байна.<br>Үр дүн: Шинээр бүртгэгдсэн 2200 ажлын байранд 1400 иргэнийг зуучилж 6,900,000 төгрөг зарцуулсан. | 100% | 100 % |
| 27 | | 3.1.2 Ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон ажил олгогчдыг бодлогоор дэмжинэ | 2021-2025 | 29.6 | Ажлын байраа хадгалсан ажил олгогч,тоо | 2020 | Ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон 5 ажил олгогчдыг урамшуулсан. | Ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон 15 ажил олгогчдыг бодлогоор дэмжинэ. | 29.6 | Ажил олоход хүндрэлтэй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажилласан "Дархан татах хэсэг", "Нью сувд дент" ХХК-д 10,080,0 мянган төгрөг, Хорих ангиас суллагдсан 1 иргэнийг байнган ажлын байраар хангасан "Дархан татах хэсгийн 1-р анги"-тай гэрээ байгуулж 7,200,0 мянган төгрөг олгосон.<br>-Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Дарханд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо" НҮТББ-тай гэрээ байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон аж ахуй эрхлэгчдэд олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 50 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 174 нэр төрлийн 796 ширхэг бараа бүтээгдэхүүн сурталчлан 49.6 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын цэгт ХЭДСангаас 10,800,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн<br>Зорилтот бүлгийн иргэдийг байнгын ажлын хангасан 16 аж ахуйн нэгж байгууллагад 87,080,0 мянган төгрөг олгосон.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.<br>-"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны хүрээнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлэх, сурталчлан таниулах, борлуулалтын цэгийг ажиллуулах зорилгоор "Дарханд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо" ГҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 3,600,000 төгрөг олгосон.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажиллуулан урамшуулалд хамрагдах хүсэлтийг 1 байгууллага ирүүлж гэрээ хийсэн.<br>Ажил олоход хүндрэлтэй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажиллаж байгаа "Монрок" ХХК, 18 нас хүрээд асрамжийн төвөөс гарсан 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажиллаж байгаа Нарны хүүхдүүд асрамжийн төвтэй гэрээ байгуулж 2024 оны 4 дүгээр улиралд гэрээг дүгнэн урамшуулал олгоно.<br>Үр дүн: Зорилтот бүлгийн 4 иргэн байнгын ажлын байртай болсон.Ажил олгогчийн урамшууллын санхүүжилтийг 2 байгууллагат 30240,0 мян төгрөг олгосон. | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | | 3.1.3 Сургалтын байгууллагууд ажил олгогчдын захиалга, орчин үеийн шаардлага хангасан нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэнэ. | 2021-2025 | - | Аж ахуй эрхлэх, бизнесээ эхлэх, хөгжүүлэх сургалтад өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулна. | 2020 | Аж ахуй эрхлэх, бизнесээ эхлэх, хөгжүүлэх сургалтад өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 150 иргэнийг хамруулсан. | Сургалтын байгууллагууд ажил олгогчдын захиалга, орчин үеийн шаардлага хангасан нарийн мэргэжлийн 500 боловсон хүчин бэлтгэнэ. | - | Ажил олгогчдын эрэлт, ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсролын болон мэргэжлийн сургалт зохион байгуулах эрх бүхий 13 сургалтын байгууллагатай хамтран тогооч 27, үсчин 26, гоо засалч 24, машин механизмын оператор 41, цэцэрлэгч 20, гар урлаач, 8, оёдолчин 35, нярав, бичиг хэргийн ажилтан 30, цахим ур чадвар олгох сургалтад 25, ХАБЭА-н ажилтны мэргэшүүлэх сургалтад 31, нийт 267 иргэнийг сургаж, 47.820.0 мянган төгрөг<br>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 445 дугаар нээлттэй хорих ангийн дэргэдэх оёдол, арьс шир боловсруулах, мужаан, эсгий үйлдвэрлэлд түшиглэн суллагдах 27 иргэн, Дархан хүнс ХК-тай хамтран талх, нарийн боов хийгч дамжлагын ажилтны мэргэжлээр 23 иргэнийг үйлдвэрлэл дээрх сургалтад хамруулж, 18,000,0 мянган төгрөг,<br>- Сургалтад хамрагдсан 61 иргэнд хоол унааны мөнгө 8,967,0 мянган төгрөгийг ХЭДСангаас тус тус зарцуулсан байна.<br>Зорилтот бүлгийн ажилгүй 955 иргэнийг хамруулж 109,287,0 мянган төгрөг зарцуулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/39 тушаал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны А/185 тушаалын дагуу ажилгүй, ажил хайж байгаа, зорилтот бүлгийн хөдөлмөрийн насны иргэдийг мэргэжил олгох дараах сургалтуудад хамруулж байна. Үүнд:<br>Дархан Политехникийн коллежийн оёдлын ангид 14 иргэн 2,520,000 төгрөг, Дарханы Зөвлөх Боломж ТББ-ын дэргэдэх сургалтын төв Няравын ангид 20 иргэн, 2,800,000 төгрөг, ДЖАТ ХХК-ний дэргэдэх "ОЧ" сургалтын төвийн Хүнд машин, механизмын операторын ангид 33 иргэн 9,240,000 төгрөг, Ла Луна ХХК-ний дэргэдэх сургалтын төвийн хүнд машин, механизмын операторын ангид 12 иргэн 3,360,000 төгрөг, Дархан-Уул аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дэргэдэх тогоочийн сургалтад 16 иргэн 2,880,000 төгрөг, "Эрхэмсэг оршихуй" сургалтын төв үсчин гоо сайханч ангид 20 иргэн 3,200,000 төгрөг, нийт 115 иргэнийг сургаж 61 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, 24,000,000 төгрөг зарцуулсан.<br>Үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хаалттай хорих 435 дугаар анги 27 хоригдлыг оёдолчны мэргэжлээр сургаж 9,720,000 төгрөг, "Дархан төмөрлөг" ХХК-ий дэргэдэх сургалтын байгууллага 13 иргэнийг хайлах зуух, цутгах зуух, цувих зуухны оператор мэргэжлээр сургаж 6,961,500 төгрөг, нийт 40 иргэнд мэргэжил олгож 17,325,000 төгрөг зарцуулж 100% ажлын байранд зуучилсан.<br>Үр дүн: 155 иргэнд мэргэжил олгож, 41,325,000 төгрөг зарцуулж 101 иргэнийг ажлын байранд зуучилсан. | 100% | 100 % |
| 29 | | 3.1.4 Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Цахим, зайн ажлын байрыг дэмжиж санхүүгийн дэмжлэг олгоно. | 2020 | 200 ААНБ Иргэн цахим зайн ажлын байрыг дэмжиж санхүүгийн дэмжлэг олгсон. | 600 ААНБ Иргэн цахим зайн ажлын байрыг дэмжиж санхүүгийн дэмжлэг олгоно | 20,2 | -Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем E-JOB платформыг 2022 оны 12 дугаар сараас хэрэглээнд нэвтрүүлж 2023 оны 11 дүгээр сарын байдлаар:<br>Ажил олгогч -130,<br>Ажил хайгч иргэн-3181,<br>Ажлын байрны захиалга-800<br>Ажилд зуучлагдсан-1350<br>Шинэ ажлын байр-2100 бүртгэн ажиллаж байна. Байнгын ажлын байр 1700, түр болон улирлын ажлын байр 400г бүртгэж 8,400,0 мянган төгрөг зарцуулсан<br>-Цахим хөгжил харилцаа холбооны яам, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Европын холбооноос хэрэгжүүлж байгаа "Найрамдал" төслийн баг, "Edarkhan academy" сургалтын төв, "Zochil" онлайн худалдааны платформ, Монгол болон БНСУ-д жижиг бизнес эрхлэгч иргэн Kyoung oh LIM-тэй хамтран цахим худалдаа эрхэлдэг, эрхлэх хүсэлтэй 140 иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын хөдөлмөр эрхлэлт, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Дархан-Уул аймгийн цахим худалдааны шинэ гарцыг тодорхойлох нь" уулзалт арга хэмжээг зохион байгуулж 7,000,0 мянган төгрөг зарцуулсан.<br>- Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны "Финтек"-ээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох арга хэмжээг "Entcredit инвестмент" ББСБ-тай гэрээ байгуулан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 2700 гаруй иргэнд мэдээллийг хүргэж, холбон зуучилснаар 531 иргэн бүртгүүлж, 420 иргэн цахим гэрээ хийж 321 иргэнд 165.400.0 төгрөгийн хүүгүй барьцаагүй зээл олгосон.<br>Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем E-JOB программд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар:<br>Ажил олгогч -211,<br>Ажил хайгч иргэн-1863, | 100% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ажлын байрны захиалга-1849<br>Ажилд зуучлагдсан-944<br>-Шинэ ажлын байр-944 бүртгэн ажиллаж байна. Хөдөлмөрийн зах зээлийн байнгын ажлын байр 822, түр ажлын байр 79, улирлын ажлын байр 43 бий болсон.<br>- Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаагаар 2023 оноос "Финтек"-ээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох арга хэмжээг "Entcredit ин вестмент" ББСБ-тай гэрээ байгуулан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 489 иргэний 298,000,000 сая төгрөгийн зээл авсан. 2024 оны 10 сарын байдлаар 21 иргэний 13,300,000 төгрөгийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэлтэй байна<br>**Үр дүн: 1849 ажлын байранд 1400 иргэн зуучлагдаж, эргэлтийн хөрөнгийн дэмжлэгт 21 иргэн хамрагдаж 13,300,000 төгрөгийн зээл авсан.** | | |
| 30 | 3.2 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 3.2.1 Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж, орон сууцжуулна. | 2021-2025 | 170.0 | Дархан сумын 7, 14, 29, 30 дугаар хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | 2020 | Дахин төлөвлөлт хийх газрын байршлыг тогтоож, аймгийн ИТХ-аар батлуулсан. | Дархан сумын 7, 14, 29, 30 дугаар хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 230,0 | Дархан сумын 12 дугаар баг, 7, 14 дүгээр хороолол, 15 дугаар багт байрлах 29, 30 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Үүнд:<br>- Дархан сумын 13-р багт Залуус-1 хороолол 102га талбайд, 15-р багт Залуус-2 хороололд 23га талбайд хорооллуудыг төлөвлөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Инженер геодези ХХК гүйцэтгэж, аймгийн ИТХ-р хэлэлцүүлэн батлуулсан. 2023.02.10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлуулсан.<br>- Дархан сумын 12-р баг 14-р хорооллын амины орон сууцны хэсгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг "Идиал групп" ХХК гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2024.07.31-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлуулсан.<br>- Дархан сумын 7, 30 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад зарцуулагдах төсөвт өртгийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар хүргүүлсэн.<br>Мөн 2021-2024 ондууд **25** байршилд **1916** айлын нийтийн орон сууц баригдаж байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>**Үр дүн: Дархан сумын 1916 өрх бага өртөгтэй орон сууцаар хангагдах нөхцөл бүрдэж байна. Цаашид 10,000 өрх орон сууцаах хангагдах нөхцөл бүрдэнэ.** | 70% | 90% |
| 31 | | 3.2.2 Хувийн орон сууцыг төвлөрсөн, инженерийн дэд бүтцэд үе шаттайгаар холбоно. | 2021-2025 | - | Хувийн орон сууцыг төвлөрсөн, инженерийн дэд бүтцэд 200 айлыг үе шаттайгаар холбоно. | 2020 | 23, 25, 31 хороолол, 5, 7, 8 дугаар багийн гэр хорооллын шугам ашиглалтад орсон. | 23, 25 дугаар хороололд 25 айл, 5, 7, 8 дугаар багийн гэр хороололд 200 айл холбогдоно. | - | Дархан сумын 9,10 дугаар багт байрлах 23, 25 дугаар хорооллуудад нийт 181 айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдоод байна.<br>Дархан сум 8-р баг, Нарантолгой хэсэгт 56 айл инженерийн шугам сүлжээнд холбогдсон.<br><br>**Үр дүн: 237 өрх инженерийн шугам сүлжээнд холбогдсон.** | 100% | 100 % |
| 32 | | 3.2.3 Цемент, арматур, барилгын ханын болон эрдэс, түүхий эд материалыг орон нутагтаа үйлдвэрлэж, бага өртөгтэй орон сууцаар хангах боломжийг бүрдүүлнэ. | 2021-2025 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бага өртөгтэй орон сууцаар иргэдээ хангах ажлыг бодлогоор дэмжинэ. | 2020 | Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгч 2 үйлдвэрийг 180.0 сая төгрөгөөр дэмжиж ажилласан | 10 үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана. | - | Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 35 ААНБ үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:<br>- Технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр -1,<br>- Ган туйван, бетон бүтээцийн мяндас полимер арматур, катангийн үйлдвэрлэл-4<br>- Бетон зуурмагийн үйлдвэр-6<br>- Чулуу бутлах үйлдвэр -1<br>- Бетон эдлэлийн үйлдвэр -7<br>- Тоосгоны үйлдвэр-1<br>- Цемент, шохой, магни, гөлтгөнө болон холимог барьцалдуулагч материалын үйлдвэр-4<br>- Дүүргэгч материал элс, хайрга, дайрга, галт уулын гаралтай чулуу бутлан ангилах, байгалийн чулуу олборлох боловсруулах үйлдвэр (элс, хайрга олборлож боловсруулах үйлдвэрлэл)-4 эдгээр үйлдвэрүүд нь орон нутагтаа барилгын материал үйлдвэрлэж, бага өртөгтэй орон<br>сууцаар хангах боломжийг бүрдүүлж ажиллаж байна. Мөн 2021-2024 онуудад Барилгын материал үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл шинээр авсан-9, хугацаа сунгуулсан-13, хугацаа дууссан сунгуулах шаардлагатай 9 ААНБ үйл ажиллагаа явуулж байна.<br>2021-2024 онд аймгийн хэмжээнд шинээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон 228 барилга байна. Үүнд:<br>✓ ИШС-76<br>✓ Орон сууц-54 | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ✓ Тохижилт-4<br>✓ Үерийн байгууламж- 5<br>✓ Үйлдвэр-20<br>✓ Үйлчилгээ-41<br>✓ Сургууль-6<br>✓ Эмнэлэг-7<br>✓ Цэцэрлэг-5<br>✓ ШТС-10<br>Үр дүн: 550 хүүхэд СӨБ-д хамрагдах нөхцөл боломж бүрдэж, иргэд бага өртөгтэй орон сууцаар хангагдах, төрийн болон бусад үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүртэх, аюулгүй орчинд амьдрах боломж бүрдэнэ | | |
| 33 | 3.3 Эрүүл, аюулгүй, баталгаат орчныг бий болгоно | 3.3.1 Хүнсний үйлдвэрүүдэд чанарын менежментийн стандартыг нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана. | 2021-2025 | 10.0 | Уулзалт, сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө. "Өег" гурил ХХК –д ISO:9001-ыг стандарт нэвтрүүлнэ. | 2020 | MNS CAC/RCP 1:2003 (HACCP) -2 А А Н Б, MNS ISO 9001:2016, MNSCAC/RCP 1:2003 (HACCP), MNS ISO 22000:2019-1 ААНБ байгуулан нийт менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн байгууллагын 17.6%-ийг эзэлж байна | Хүнсний үйлдвэрүүдэд чанарын менежментийн стандарт HACCP болон ISO:9001-ыг нэвтрүүлэх 2-с доошгүй ААН-д зөвлөн тусална. | 10.0 | 2021-2023 оны Хөтөлбөр хэрэгжих хугацаанд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудад менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 35 аж ахуйн нэгж байгууллагын 100 гаруй чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн, удирдах ажилтнуудыг хамруулан 5 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласны үр дүнд Улаанбаатар гурил ХХК ISO 9001 чанарын менежментийн тогтолцоо, Дархан мах эрдэнэ комбинат ХХК Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн гэрчилгээгээ гардан авлаа. Дархан-Уул аймгийн ХХААГ, Хонгор сумын ЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ, Просерфт ХХК-ийн сургагч багш нар хамтран "Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ыг танилцуулах сургалтыг 2024.08.14-15-ны өдрүүдэд сүү бэлтгэн нийлүүлэгч иргэн, фермер, сүү цуглуулах цэг, сүү боловсруулах үйлдвэр цехийн нийт 28, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс 19, төрийн байгууллагаас 6 хүн хамруулж, зөвлөгөө өгч ажилласан. "Тохирлын гэрчилгээ хэрхэн авах вэ, тохирлын гэрчилгээ олгох" сургалтыг 2024.05.29-30-ны өдрүүдэд Хөгжлийн Шийдэл ТББ, ХХААГ хамтран зохион байгуулж, нийт 15 бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, 2 үйлчилгээний байгууллага хамруулж, зохистой дадал, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо, Чанарын менежментийн стандарт нэвтрүүлэхийн ач холбогдлын талаар мэдлэг олгох ажлыг зохион байгуулсан.<br>Үр дүн: 2024 онд сургалт 2, Улаанбаатар гурил ХХК ISO 9001 чанарын менежментийн тогтолцоо, Дархан мах эрдэнэ комбинат ХХК Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн гэрчилгээ авсан. | 100% | 90%. |
| 34 | | 3.3.2 Агаар, ус, хөрсний бохирдол, дуу чимээг багасгаж, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ | 2021-2025 | 400.0 | Ногоон байгууламжийн ургалт, % | 2020 | Тооллогын дүнгээр 6645 айл өрх, бага оврын 203, том оврын 13 уурын зуух тоологдож ялгарах хаягдлыг 6 үзүүлэлтээр тооцоход 15427.8 тн хаягдлыг гадаад орчинд хаяж байна. Хараа голын усны бохирдлын индекс 0.43 буюу II зэргийн **"ЦЭВЭР"** ангилалд байна. | Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ургалтыг 70-с доошгүй | 400.0 | Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2030 он хүртэл нэг тэрбум мод тарих хөдөлгөөнд нэгдэж "Ногоон Дархан 2032" хөтөлбөрийг батлуулж, 10 жилийн хугацаанд 20.0 сая мод тарих аяныг эхлүүлсэн. "Баян бараат" байршилд мод бут тарих 50 аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг гаргаж, тус байршлын тохижилтын ажлын зураг, төсвийг бэлэн болгосон. "Ногоон Дархан-2032" аймгийн зөвлөгөөнийг /2022.03.29/ холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан "Дарханы Дулааны цахилгаан станц" ТӨХК-10000, "Дархан Дулааны Сүлжээ" ТӨХК-2000, "Дархан Ус суваг" ХК-1600, "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ХК-500 нийт 14100 ширхэг бургас, нарс мод тарьсан. Ногоон Дархан-2032" хөтөлбөрийн хүрээнд 788724 урт/м хашаажуулалт хийж, Шинэ иргэний төгөлд авто зогсоол 2 байршилд, гэрэлтүүлэг 32ш, тохижилтын ажлуудыг хийсэн. Хавар намар 1 тэрбум мод үндэсний хөдөлгөөний 192438 ш мод тарьж, ургалт 75 хувьтай байна. 2023онд 2023 онд шинээр 2 төгөл байгуулагдаж бүх нийтээр мод үндэсний өдрийн хүрээнд 322100 ширхэг мод бут тарьсан. 2024 онд доройтсон ойг нөхөн сэргээх чиглэлээр 50 га талбайд 114724 ширхэг, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, голын татмыг нөхөн сэргээх, авто зам, тариалангийн талбай хамгаалах ойн зурвас байгуулах чиглэлээр 2 га, 41 км хамгаалалтын зурваст 130271 ширхэг, хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 77543 ширхэг, 16000 $м^2$ талбайг зүлэгжүүлж, жимсний болон агро аж ахуйг хөгжүүлэхэд 43500 ширхэг нийт **366038** ширхэг мод бут тарих ажилд 4693 иргэн, 154 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, улс, орон нутгийн төсөв, аж ахуйн нэгжийн нийт 1,5 тэрбум.төгрөг зарцуулсан дүнтэй байна.<br>Үр дүн: Бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна. | 100% | 100 % |
| 35 | | 3.3.3 Хот суурин газрын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, | 2021-2025 | 619.0 | 10км дугуйн болон явган зам шинээр барьж ашиглалтад оруулна. . | 2020 | 25км явган зам, Унадаг дугуйн зам 0.0км | 30км явган зам 10.0 км дугуйн замтай болсон байна | 619.0 | 2021 онд ОНХС-ийн 619,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар дугуйн болон явган хүний 10 км замыг ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2022 онд 1, 2 дугаар багийн тосгоны урд далангаар 2 км, хуучин дарханаас шинэ дарханы төв зам дагуу 3,2 км зам хийгдсэн.<br>2023-2024 онд шинэ хорооллын 16 байрнаас шинэ хорооллын арын зам-DBS уулзвараас– Аюулгүйн тойрог хүртэл 2,8 км, Соёл амралтын Дархан-60 цогцолборт 1,58 км, Мобикомын уулзвараас–онгоцны буудал хүртэл 2,7км, АШУИС-аас ШУТИС хүртэл 0,7км, Дархан сумын 5,6 баг Дархан ЗДТГ-аас Гэгээ | 90% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | дэлгүүр хүртэл 0,85 км, 1,3,5 баг 6 буудлаас МСҮТ-ийн хүртэл 1,1км, 1-8 багийг холбосон 0,8км дугуйн замыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.<br>2024 онд улс орон нутгийн төсвөөр хэрэгжиж ашиглалтанд оруулсан дараах Биг рентал ХХК-ийн гүйцэтгэсэн Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам багц-2 (1,09 км хатуу хучилттай 4 эгнээ авто зам) 1,09 км дугуйн зам, Түвшин гэгээ ХХК -ийн гүйцэтгэсэн "Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам багц-2 (2,8 км хатуу хучилттай 4 эгнээ авто зам, 2 тойрогтой) ажил 2,8 км дугуйн зам, Дархан АЗЗА ТӨҮГ гүйцэтгэсэн Аймгийн төвийн доторх хатуу хучилттай авто зам 2 дахь үе шатны ажил 1,827 км дугуйн зам, Түвшин гэгээ ХХК гүйцэтгэсэн Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам (Дархан-Уул, Дархан сум 1, 2, 3-р баг) багц-1 ажил 2,28 км дугуйн зам, Би ти еү ХХК-ийн гүйцэтгэсэн Дугуйн замын ажил 9,10,11,12-р баг 2,8 км ажлуудад нийт **10,7** км дугуйн замыг ашиглалтад оруулаад байна.<br>Үр дүн: 2021-2024 онд нийт 26.13 км явган болон дугуйн шинээр баригдсан. | | |
| 36 | | 3.3.4 Хүний эрүүл мэнд, амьдрах орчинд учруулж буй ургамал, амьтны сөрөг нөлөөллийг бууруулна. | 2021-2025 | 56.0 | Хүний эрүүл мэнд, амьдрах орчинд учруулж буй ургамал, амьтны сөрөг нөлөөллийг бууруулна. | 2020 | Баавгайнаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, сумдад албан даалгавар хүргүүлсэн. | Хээрийн зэрлэг амьтан Хүрэн баавгайн учруулж болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна. Хориотой ургамлын устгал хийнэ | 56.0 | 2021 онд Хээрийн зэрлэг амьтан суурьшлын бүсэд орж ирсэн тохиолдолд барьж авч, зөөн тээвэрлэх, нутаг шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хонгор сумын 2-р багийн нутаг Мухарын голд зусаж буй малчдын хот руу болон бэлчээрт мал руу хүрэн баавгай дайрсан тохиолдлууд гарсан. Иргэдийн өгсөн мэдээллийн дагуу "Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг" ТББ, Амьтан асралт ХХК-ийн хамтран Хустайн даваа, Могойн голоор зусаж буй нийт 300 гаруй малчдад зөвлөмж, сэрэмжлүүлгийг өгч ажилласан. Шарилжгүй Дархан хөтөлбөрийн хүрээнд 2022 онд орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 640 га талбайд шарилж устгалын ажлыг 3 үе шаттай хийж гүйцэтгэсэн. Хориотой ургамлын устгалын ажилд 20.0 сая төгрөг батлагдсан бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран 2 үе шаттайгаар зохион байгуулж нийт 385 га талбайд устгал хийсэн.<br>Шарилж устгалын ажлыг 640 га талбайд, Хориотой ургамлын устгалыг 385 га талбайд хийж гүйцэтгэсэн.<br>2024 онд Хүрэн баавгай орж ирсэн Хонгор сумын Шивэрт, Булагтай, Хүйтний голын эх орчмоор эргүүл хяналт шалгалтын ажлыг 5 удаа, Чулуут гол орчмоор 1 удаа, Хонгор сумын нутагт өвөлжиж буй цагаан зээрийн сүрэглэлтэд мониторинг ажиглалт 1 удаа, Хонгор сумын Моностой, Орхон сумын Ерөө, Бүрэн толгой, Хөшөөт,зэрэг газруудад экологийн цагдаагийн газартай хамтран 6 удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллаа. Тарваганы эргүүл хяналтаар 3 чиглэлээр ажлын хэсэг байгуулагдаж сарын турш ажилласан. Нийт 15 удаа хяналт шалгалтыг хийсэн.<br>2024 онд Шарилжгүй Дархан" дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 9,10,11,12 дугаар багийн нутаг дэвсгэрийг хамруулан нийт 70.5 га талбайн шарилжийг 8 дугаар сaруудад 14-31-ний өдрүүдэд 3 удаагийн давтамжтайгаар хийж гүйцэтгэсэн<br>Үр дүн: Суурьшлын бүсэд байршиж буй шувуу, могойн дуудлагаар 20 удаа ирснийг аюулгүй газарт зөөж байршуулсан. | 100% | 100 % |
| **3.4** | **Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачлага, ур чадварыг хөгжүүлж, аж ахуй эрхлэлтийг дэмжинэ.** | | | | | | | | | | | |
| | 3.4. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, ур чадварыг хөгжүүлж, аж ахуй эрхлэлтийг дэмжинэ. | 3.4.1 Иргэдэд бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | 2021-2025 | 257.0 | Иргэн, Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд аж ахуй эрхлэхэд нь зориулж санхүүгийн дэмжлэг олгоно. | 2020 | Иргэн, аж ахуй эрхлэгчдэд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 211 иргэнд олгож, үр дүнг тооцсон. | Иргэн, аж ахуй эрхлэгчдэд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 900 иргэнд олгоно. | 257.0 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, хөтөлбөр, төслийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд төсөл хүлээн авах нээлттэй зарыг орон нутгийн хэвлэл 2 телевиз, байгууллагын вэб сайт, фэйсбүүк цахим хуудсуудаар дамжуулан олон нийтэд нээлттэй зарлаж, 402 төсөл хүлээн авсан. ХЭҮЗ-ийн 2022 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэгт 84 иргэний төсөлд 500.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, 169 байнгын ажлын байр бий болсон. Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт 9 төсөлд 45.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, 18 байнгын ажлын байр бий болсон<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 28 иргэний төсөлд 144.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, 44 байнгын ажлын байр бий болсон. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 28 иргэний төсөлд 100.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, 28 байнгын ажлын байр бий болсон. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 56, хүүхэд хамгаалагч төсөлд 2 ахмадыг хамруулж 22.2 сая төгрөг зарцуулсан. Орон нутгийн төсвөөс зорилтот бүлгийн 20 иргэнд 100.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгож, 40 ажлын байр бий болсон.<br>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шалгарсан Старт-ап 1 багт 10.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгож 5 ажлын байр шинээр бий болсон. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах 1 төсөлд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.Аж ахуй эрхлэлтийн төслийн өмнөх ба дараах сургалтад 239 иргэнийг хамруулж 5.0 сая төгрөг зарцуулсан.<br>Профайлингийн үйлчилгээнд төсөл ирүүлсэн 402 иргэнийг бүрэн хамруулж, | 90% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | | | | | | | | | | иргэний хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдал, ур чадварын үнэлгээг хийж, мэдээллийн сан үүсгэсэн.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд: "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны санхүүгийн дэмжлэг, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг, Малжуулах санхүүгийн дэмжлэгт 164 иргэнд 1,132,000,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Өссөн дүнгээр 336 иргэнд 2,063,200,0 мянган төгрөгийн санхүүжилт олгож 589 ажлын байр хадгалагдан үлдсэн байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан удирдамжийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны:<br>-Аж ахуй эрхлэгч иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 117 иргэн,<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны санхүүгийн дэмжлэгт 92 иргэн,<br>-Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 94 иргэн,<br>-Малчдыг малжуулах үйл ажиллагааны малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт 81 иргэн, нийт 384 иргэн онлайнаар хүсэлт ирүүлж ажлын хэсэг 3 удаагийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 187 иргэнд 1,482,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.<br>Үр дүн: 187 иргэнд 1,482.0 сая төгрөг зарцуулсан. | | |
| 38 | | 3.4.2 Бичил болон гарааны бизнес, хоршоо, хуримтлалын бүлгийн ажиллах орчныг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2021-2025 | 25.0 | Ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх төслийн жижиг зээлийг банкаар дамжуулан жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгоно. | 2020 | 17 Бичил болон гарааны бизнес, хоршоо, хуримтлалын бүлэгт зээл олгосон. | 50 Бичил болон гарааны бизнес, хоршоо, хуримтлалын бүлэгт гарааны бизнесийн зээл олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 25.0 | 2021-2023 онд Хөгжлийн шийдэл" ТББ-ын Бест хөтөлбөр, төслийн хүрээнд нийт 9 удаагийн сургалт, уулзалтыг зохион байгуулж, 300 иргэн, аж ахуйн нэгжид мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Захирамжаар 2023 оныг "Бизнесийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан бөгөөд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Хөгжлийн шийдэл ТББ, Дэлхийн зөн ОУБ, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Найрамдал төсөлтэй хамтран танхимын сургалт 15, цахим сургалт 6, зөвлөгөөн 2, салбарын уулзалт 3, үзэсгэлэн 2, туршлага судлах аялал 1 тус тус зохион байгуулж, 1005 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулллаа. Хөгжлийн шийдэл ТББ-ын гарааны бизнесийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт шинэ санаачилга, инноваци бүхий 5 аж ахуйн нэгж 50.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг, Найрамдал төслөөс 7 аж ахуйн нэгж 140.0 мянган еврогийн дэмжлэг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд 9 аж ахуйн нэгж 1.1 тэрбум төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 11 иргэн 232.7 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлд банкаар дамжуулан 18 иргэн, аж ахуйн нэгж 410.0 сая төгрөгийн төсөл хамрагдсан байна.<br>2021-2023 онд 48 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөн, үзэсгэлэн, аяллыг зохион байгуулж 1937 иргэнийг хамруулж, хөнгөлөлттэй зээлд 57 иргэн, аж ахуйн нэгж 2,252.7сая төгрөг, 12 аж ахуйн нэгж ОУБ-ын 540.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгт хамрагдлаа.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан удирдамжийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 187 иргэнд 1,482,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.<br>-Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн залуучуудад чиглэсэн шилдэг "Старт-ап" залуучуудын багийг шалгаруулах арга хэмжээний хүрээнд: "Вест метод" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, нэг шилдэг "Старт-ап" багийг шалгаруулж эргэн төлөгдөх нөхцөлгүй 10,000,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож үйл ажиллагаанд 8,000,0 мянган төгрөг зарцуулсан.<br>Үр дүн: 187 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 1,482.0 сая төгрөг, шилдэг Старт-ап багт 10.0 сая төгрөг тус тус олгосон. | 100% | 100 % |
| 39 | | 3.4.3 Хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжсэн зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 60.0 | Хүү багатай жижиг зээлд хамрагдаж ажлын байртай болсон иргэний тоо | 2020 | Хүү багатай жижиг зээлд хамрагдаж 78 иргэн байнгын ажлын байртай болсон. | Хүү багатай жижиг зээлд иргэдийг хамруулж өссөн дүнгээр 188 байнгын ажлыг байрыг бий болгоно. | 60.0 | Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 18 иргэн, аж ахуй нэгж байгууллагад 410,000,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож Төрийн банканд 62 иргэний 1.772.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээгдэж байна.<br>Төсөл арга хэмжээнд 21 иргэн хамрагдаж 770.0 сая төгрөгийн санхүүжилт авч 90 ажлын байр хадгалагдан үлдсэн байна.<br>Дэлхийн банкнаас олгож буй "Жижиг зээл"-ийг Төр, Хаан банкаар дамжуулан 48 төсөлд 870.6 сая төгрөгийн зээлийг олгож, шинэ ажлын байр 55, хадгалагдсан ажлын байр 63 байна<br>Үр дүн: 48 иргэнд 361.0 сая төгрөгийн жижиг зээл олгож 55 шинэ ажлын байр бий болсон. | 70% | 70% |
| 40 | | 3.4.4 Хөгжлийн бэрхшээлтэй | 2021-2025 | 113.6 | Ажлын байрыг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын | 2020 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг | Ажлын байрыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй | 113.6 | "2021 онд 50 хувь эргэн төлөх нөхцөлтэй Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 66 иргэний ирүүлсэн төслөөс 23 төслийг дэмжиж 60,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 25 байнгын ажлын байр бий болсон.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй 13 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна.<br>-Халамжаас Хөдөлмөрт аймгийн дэд хөтөлбөрийн танилцуулга, ажил мэргэжлийн | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, чадавхи, чадамжийг хөгжүүлэн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | | | байрыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | | дэмжиж 128.0 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. | иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүд ийг хэрэгжүүлж, хоршоо, хуримтлалын бүлгийн ажиллах орчныг сайжруулна. | | чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх ганцаарчилсан болон бүлгийн сургалтад 41 ХБИ-ийг хамруулсан.<br>-Эмэгтэйчүүдэд зориулсан цахим сургалтад 84 эмэгтэй хамрагдсанаас<br>2022 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтад 83 иргэнийг хамруулж, 2,1 сая төгрөгийг зарцуулсан.<br>Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 28 төслийг шалгаруулан 144,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 44 иргэний байнгын ажлын байр бий болсон.<br>2023 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ний хүрээнд: Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 98 иргэний ирүүлсэн төслөөс 27 төслийг шалгаруулан 176.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 42 иргэний байнгын ажлын байр бий болсон.<br>2024 онд Нэмэлт санхүүжилтээр ирсэн 176.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2024 оны А/224 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй болон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд олгохоор сонгон шалгаруулалтыг зарлан, мэдээлэл хүргэж цахим бүртгэлд хамруулан ажиллаж байна.<br>Үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих үйл ажиллагаанд 161 иргэнийг хамруулан 135 байнгын ажлын байр бий болж, ХЭДС-аас 382.1 сая төгрөг зарцуулсан | | |
| 41 | | 3.4.5. Хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа, сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлсэн төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2025 | - | Ажил эрхлэлт,% | 2020 | Төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлсэн байна. | Төгсөгчдийн 60-аас доошгүй хувийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлсэн байна. | - | Их сургууль төгсөгчдийн ажил эрхлэлт 65% байна.<br>1. Их дээд сургууль, Политехник коллежиуд хамтран ажиллагч түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг 40 гаруй чиглэлээр байгуулан хамтран ажиллаж байна.<br>2. ХХҮГ-с зохион байгуулдаг нээлттэй ажлын байрны захиалга, ААНБ-ын ажлын байрны захиалгыг төгсөгчдөд цахим хуудас болон төгсөгчдийн холбоогоор дамжуулан мэдээллийг тогтмол хүргэн ажилд зуучлан ажиллаж байна, Тайлант хугацаанд ажлын байрны захиалга ажил эрхлэлт 90%-тай байна. Уул уурхай Политехник коллежийн хувьд ажил хөдөлмөр эрхлэлт 100%-тай байна.<br>3. Дархан Политехник коллеж нь "Техникийн мэргэжлийн зөвлөл", "Барилгын мэргэжлийн зөвлөл"-үүдтэй хамтран Мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, үр дүнг сайжруулах, Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, ААН, мэргэжлийн холбоодын бүтээмж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын чанар үр дүн, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр "Барилгын мэргэжлийн зөвлөл"-ийг шинээр байгуулан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Цаашид барилгын мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан төгсөгчдийн ур чадварын шалгалт авах, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, ур чадварын уралдаан зохион байгуулах чиглэлээр ажиллана.<br>4. Дархан-Өргөө Политехник коллеж нь энэ хичээлийн жилд Барилгын болон Мэдээллийн технологийн мэргэжлийн зөвлөлтэй, мэргэжлийн багш нар хамтран Барилгын цахилгаанчин, Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан, Бетон арматур гэсэн 3 мэргэжлийн ЧССХ-ийн сайжруулалтыг хичээлийн жилдээ туршин агуулгыг сайжруулан Зам барилгын материалын лаборант мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг баталгаажуулсан. Төрийн болон орон нутгийн өмчит 10 ААНБ-тай "Хамтран ажиллах гэрээ"-г шинээр байгуулав.<br>Үйлдвэрлэлийн дадлага хийх ажил олгогч, сургалтын байгууллага, суралцагч"-ийн гурван талт гэрээг шинэчлэн боловсруулж, 88 ААНБ-тай гэрээ байгуулан мэргэжлийн сургалт олгох 1 жилийн 8 мэргэжлийн 74, Техникийн боловсрол олгох 9 мэргэжлийн 153, нийт 227 оюутан, суралцагчдын төгсөлтийн өмнөх дадлагыг түншлэгч байгууллагуудтай хамтран, үр дүнтэй зохион байгуулсан.<br>5.ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль нь Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-тай 2022 оны 5 дугаар сард хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, Инженер техникийн ажилтнуудыг давтан сургах, сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, сургалтын материаллаг бааз, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг олон талт ажлуудыг тусгасан.<br>6.БШУГазар, НТБТ, ХХҮГазар, ХЗГБХГазар зэрэг мэргэжлийн байгууллагууд хамтран Ажил Мэргэжлийн Чиг Баримжаа олгох зөвлөлийг байгуулан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг "Ур чадварыг хөгжүүлэх (B4S)" глобаль төслийн дэмжлэгтэйгээр GIZ хамтран | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | "Сантехникийн мэргэжлийн зөвлөл" байгуулан Барилгачдын холбоо, АО, ААНБ-ын төлөөллийг оролцуулсан мэргэжлийн зөвлөл байгуулан 10000 еврогийн төсөл хэрэгжүүлэн хамтран ажиллаж байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.<br>-"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны хүрээнд:<br>-Санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар онлайнаар хүсэлт ирүүлсэн 92 иргэний төслийг ажлын хэсэг 3 шатны сонгон шалгаруулалтад оруулж 31 иргэнд 248.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.<br>-Аж ахуй эрхлэлтийн зээлийн өмнөх болон дараах сургалтад 116 иргэнийг хамруулж 2.5 сая төгрөг зарцуулсан.<br>Үр дүн: Хөтөлбөрт 147 иргэнийг хамруулж 250.5 сая төгрөгийг зарцуулсан. | | |
| 42 | | 3.4.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангаж, үйлдвэрлэлийн осолгүй ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр ажил олгогчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ажилтан аюул эрсдэлээс өөрийн болон бусдыг хамгаалах чадвар, дадал төлөвшүүлнэ. | 2020 | ХАБЭА зардал төрийн байгууллагууддад хуулийн дагуу батлагдаж ирэхгүй байгаа тул ХАБЭА ажилтны нормативийн дагуу ажиллуулах, болон сургалтын арга хэмжээнүүд хийгдэж чадахгүй байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үндэсний болон орон нутаг, салбарын түвшинд, аж ахуйн нэгж байгууллагын ажлын байранд шинэлэг, үр нөлөөтэй арга хэлбэрээр тогтмол зохион байгуулж, хууль тогтоомж, стандартыг мөрдүүлж хэвшүүлнэ. | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд 282 аж ахуй нэгж, 1587 иргэнд Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зөвлөгөө мэдээлэл хүргэж 15 нэр төрөл бүхий 2072 гарын авлагыг 5 төрлөөр тарааж 1,134,0 мянган төгрөг зарцуулсан.<br>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүд, байгууллагуудын инженер техникийн ажилчид нийт 52 хүний бүрэлдэхүүнтэй баг "Оюу толгой" ХХК-ны гүний уурхайтай танилцаж, далд уурхайн 1256м гүнд ажиллах нөхцөл болон хүнд машин механизмын ажиллах зарчим, аюулгүйн ажиллагааны нарийн дүрэм журамтай танилцаж, ажлын арга барил, эрсдэлийн үнэлгээг хийх талаарх туршлага судаллаа<br>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлөөс барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, харилцан туршлага солилцох зорилгоор 24 аж ахуйн нэгж, байгууллагын 51 инженер, техникийн ажилчдыг хамруулан, барилга угсралтын талбайд үзүүлэх сургуулилтыг "Лаплас бюлдинг" ХХК-ийн "Шинэлэг апартмент" төслийн талбайд зохион байгуулж 1,356,0 мянган төгрөг зарцууллаа.<br>- 5 байгууллагуудын хөдөлмөрийн гэрээнд зөвлөгөө өгсөн.<br>-Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх журмын дагуу 18 байгууллагаас ирүүлсэн хамтын гэрээ, хэлэлцээрт хяналт хийж, зөвлөгөө өгч 16 гэрээг бүртгэсэн.<br>-Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй, ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөр болох 69,340,0 мянган төгрөгийг 5 байгууллагаас ХЭДСанд төвлөрүүлсэн.<br>-122 аж ахуйн нэгж байгууллагуудад хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг байгуулах албан бичиг хүргүүлж 16 байгууллагын орон тооны бус хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын мэдээллийг бүртгэж, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.<br>Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний газрын дарга, Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагчийн 2024 оны 07/20-01/177-01 тоот үйлдвэрлэлийн осол хурц хордлогоос урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, 2024 оны 44 тоот албан бичгийг 241 ажил олгогч байгууллагуудад хүргүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах, урьдчилан сэргийлэх, ажил олгогчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ажилтан аюул эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаарх мэдээллийг өгөх зорилготой сургалт, хэлэлцүүлгийг ХАБЭА-н салбар, аймгийн ҮЭХолбоо, ХАБЭА-н сургалт, судалгааны "Ойгон нөмрөг" төв, аймгийн ҮЭХ-ны дэргэдэх "Зөв хөтөч" сургалтын төвтэй хамтран зохион байгуулж ажиллалаа.<br>Сургалт, хэлэлцүүлэгт оролцогсдод Үйлдвэрлэлийн ослын тухай, Хөдөлмөрийн гэрээний тухай, Хүн амын зарим бүлгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааны тухай, Хамтын гэрээ, Хамтын хэлэлцээр, Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчилсан гарын авлагыг 2800 ширхэг тараасан байна.<br>"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2024" үйл ажиллагааг Дархан сум, Шарын гол сум, Орхон сум, Хонгор сумдад зохион байгуулж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагууд, ажилтан албан хаагчдад, 653 иргэн, мал бүхий иргэдэд Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль мөн салбарын хууль, дүрэм, журмыг баримтлан ажиллах тухай мэдээлэл, зөвлөгөө өгсөн.<br>Үр дүн: 241 ажил олгогч байгууллага, 653 иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч 2800 гарын авлага тараасан. | 100% | 100% |
| 43 | 3.5. Биеийн тамирыг эрүүл, идэвхтэй | 3.5.1 Иргэдэд нийтийн биеийн тамир, спортын | 2021-2025 | 10.0 | Иргэдэд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг | 2020 | Биеийн тамир спортын 42 арга | Иргэдэд нийтийн биеийн тамир, | 10.0 | Биеийн тамирыг, спортыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, биеийн тамир, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулахад 70 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | 100% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, спортоор хичээллэх ээлтэй орчныг бүрдүүлнэ. | үйлчилгээг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ. | | | үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж ажиллана. | | хэмжээнд 12000 орчим хүн хамрагдаж 48 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажилсан. | спортын үйлчилгээг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж ажиллана. | | Энэ онд уламжлал болон зохион байгуулагддаг цасны баяр, дугуйн баяр, бүх нийтийн марафон, өглөөний алхалт зэрэг биеийн тамирын 49 арга хэмжээг зохион байгуулж 25168 мянган иргэд , спортын улсын чанартай 9 тэмцээнд 2100, бүсийн чанартай 4 тэмцээнд 820, аймгийн чанартай 58 тэмцээнд 12500 хүн хамруулан зохион байгуулж 15420 хүн хамрагдан, нийт **40588** хамрагдсан.<br>Аймгийн нийт хүн амын 24,2 хувь нь биеийн тамир, спортоор тогтмол хичээллэж байна. Нийтийн биеийн тамирт улсын төсвөөс 31,700,000 төгрөг төсөвлөгдсөн<br>2023 онд биеийн тамир, спортын 47 арга хэмжээнд 14200 орчим хүн хамрагдсан.<br>Биеийн тамир, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулахад 45 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд биеийн тамир, спортыг дэмжин хамтран ажиллаж байна..<br>2024 онд Нийтийн Биеийн тамирын 42 арга хэмжээг төр, хувийн хэвшлийн 39 байгууллага зохион байгуулж 21600 мянган иргэд хамрагдсан.<br>Үр дүн: Өнгөрсөн оны мөн үеэс 3568 хүн шинээр нэмэгдсэн. | | |
| 44 | | 3.5.2 Иргэдэд үйлчлэх спортын зориулалттай байр, талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 6,238.5 | Спортын зориулалттай байр, талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2019 | Спорт заал 51, Спортын зориулалттай гадаа талбай 44 байна. | Спорт заал өссөн дүнгээр 56, Спортын зориулалттай гадаа талбай өссөн дүнгээр 48 болно. | 5,538.5 | Иргэдийн санал санаачилгыг дэмжин Хуучин Дарханд Спортын ордныг "Хөшиг-Уул" ХХК-ийн 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 619.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дугуйн болон явган хүний замын ажлыг "Би Ти Өү" ХХК 100% хийж гүйцэтгэсэн,<br>Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр багт байрлах "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнд нийт 8350м2 талбайд олон улсын стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай байгуулагдаж ашиглалтад орууллаа.<br>-Дархан-Уул аймгийн хэмжээнд Албан байгууллага, аж ахуй нэгжийн нийт 18328 м2 талбайтай 52 заал үйл ажиллагаа явуулж байна 1 хүнд ногдох спорт заалны талбай нь 0,17м2 ногдож байна.<br>2200 хүний суудалтай спорт цогцолборын ажил 2024 онд дуусаж улсын комисс ажиллуулж байнгын ашиглалтад оруулсан. Шарын гол сумын төвд хуучин хөл бөмбөгийн талбайг түшиглэн орчин үеийн стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай шинээр байгуулах ажлыг Уран минж хийц ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 78 хувьтай байна. Хонгор сумын Салхит багт 36х18м хэмжээтэй 1 давхар 648м2 талбайтай спорт заалны барилгын ажлыг 986.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан.<br>Аймгийн хэмжээнд спортын 57 заал, Биеийн тамир, спортын зориулалтын задгай 48 талбайд үйл ажиллагаа явуулж байна.<br>Энэ онд дархан сумын 14 дүгээр багт байрлах "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнд 3х3 сагсан бөмбөгийн гурван талбай, 5х5 сагсан бөмбөгийн 6 ширхэг талбайг 641.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан.<br>Үр дүн: 2021-2024 онд нийт 22 төсөл хэрэгжүүлэхээс 19 төсөл арга хэмжээ бүрэн дууссан 3 төсөл арга хэмжээ 2024-2025 онд хэрэгжиж дуусна. | 100% | 100 % |
| 45 | | 3.5.3 Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлнэ. | 2021-2025 | 10.0 | Уралдаан тэмцээний зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | 2020 | 2020 онд залуучуудын өвлийн олимпод биатлон төрлөөр 1 тамирчин амжилттай оролцсон. | Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцож буй тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | 8.0 | **2024 онд** 2023 оны шилдэг холбоогоор шалгарсан Сагсан бөмбөгийн холбоо холбоо, Талбайн теннисний холбоонд тус бүр 10 сая нийт 20 сая төгрөгийг үйл ажиллагаанд зориулан олголоо.<br>2024 онд жүдо бөхийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн Б.Анхзаяад 3.0 сая төгрөг дасгалжуулсан багш Д.Балжиннямд 1.0 сая төгрөг, Чөлөөт бөхийн залуучуудын Ази тивийн аваргаас хүрэл медаль хүртсэн Б.Ганцэцэг 1сая төгрөг, самбо бөхийн Өсвөр үеийн ази тивийн аваргаас хүрэл медаль хүртсэн О.Ариунсайханд 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.<br>Эхний хагас жилд Улс, тив, дэлхийн тэмцээнээс медальт байранд шалгарсан 12спортын төрлийн 127 тамирчинд 29.3 сая төгрөгийн шагнал олгоод байна.<br>Улсын чанартай U18 насны волейболын тэмцээн U17насны сагсан бөмбөгийн тэмцээн, Жигдэн багшийн нэрэмжит, Чөлөөт бөхийн тэмцээн, Боксын өсвөр залуучуудын УАШТ тэмцээн зэрэг 5 арга хэмжээ зохион байгуулж орон нутгийн төсвөөс 65.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.<br>Мөн БТСГ-ын 60 жилийг угтан зохион байгуулсан уралдаан тэмцээний багийн төрлүүдэд 24.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн зохион байгууллаа.<br>Үр дүн: Дэлхийн аварга, ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 1 дасгалжуулагч, 22 тамирчны замын зардалд нийт 29,3 сая төгрөг, шагнал авсан 5 тамирчинд 9,862,300 төгрөг, улсын чанартай тэмцээн уралдаан зохион байгуулахад 65,0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна | 100% | 90% |
| | | | | | | | | | | **Дөрөв.** | | |
| 46 | 4.1. Эдийн засгийн өрсөлдөх | 4.1.1 Хүнд, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийг кластер | 2021-2025 | Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй | Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн | 2020 | Экспортод чиглэсэн үйлдвэрлэлээр 235,0 тэрбум | Салбарын ТББ-тай хамтран сургалт | | **Хүнс:** Сүү боловсруулах 2 үйлдвэр 38 малчинтай гэрээ байгуулж, сүү татан авч боловсруулж байна. Орхон суманд Улаанбаатар хотын хүнсний ногоо боловсруулах 4 үйлдвэр түүхий эд хүлээн авах цэгийг байршуулж, Орхон сумын тариаланчидтай гэрээ байгуулан, түүхий эдийг шууд татан аван боловсруулж байна. Гурилын 3 үйлдвэр Хонгор сумын тариаланчидтай гэрээ байгуулан, | 70% | 50% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | хэлбэрээр хөгжүүлж, импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ. | | зээл 41,200.0 | барилгын материалын үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид хөнгөлттэй зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ. | | төгрөгийн бүтээгдэхүүн гадны зах зээлд нийлүүлсэн<br><br>12 удаагийн сургалтад 523 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. | зохион байгуулж, хүнд, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй зээл 41,200.0 | стандартын шаардлага хангасан улаанбуудайгаар гурил үйлдвэрлэж кластер хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.<br>Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2020 онтой харьцуулбал хүнс ундаа үйлдвэрлэлт 50.0 сая төгрөгөөр буюу 64.8 хувиар өссөн. Хүнсний бүтээгдэхүүний 4 жилийн дундаж үйлдвэрлэлт хүлээгдэж буй гүйцэтгэлээр гурил 31556.94 т, гурилан бүтээгдэхүүн 1201 т, сүү, сүүн бүтээгдэхүүн 146.42 мян.л, махан бүтээгдэхүүн 183.2 т, өндөг 211.7 т байна. Тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулбал хүнсний хангамж 4 жилийн дундаж үзүүлэлтээр мах, махан бүтээгдэхүүнээр 3.1% /нөөцийн мах оруулаагүй/, сүү, сүүн бүтээгдэхүүнээр 1.4%, гурилаар 4.5 дахин их, гурилан бүтээгдэхүүнээр 21.6%-ийг тогтвортой хангасан. Нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 74.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, үүнээс хүнс, ундааны үйлдвэрлэлт 11.5 хувийг, борлуулалт 15.3 хувийг эзэлж байна.<br>**Хөнгөн:** 2022 онд "Дэгжих есөн ган" ХХК үйл ажиллагаагаа өргөжүүлж, орон нутгийн түүхий эдэд түшиглэн хөнгөн блокийн үйлдвэр байгуулан импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Хөнгөн үйлдвэрийн хөгжүүлэхээр үйлдвэрийн районд байрлалтай 186 га газрын асуудлыг шийдвэрлэж, арьс ширний үйлдвэр байгуулах эхлэл тавигдсан. Дархан нэхий ХК-д хаягдал арьс шир боловсруулж, хавтан үйлдвэрлэх технологи нэвтрүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүллээ.<br>**Хүнд:** Дархан төмөрлөгийн үйлдвэр нь менежментийн гэрээгээр ажиллах хугацаанд хүчин чадлын 20 хувийг ашиглаж байсан. Засгийн газрын шийдвэрээр 2022 онд "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болсон. 2021 онд "Монгол Ган цогцолбор I" төслийн хүрээнд жилд 350 мянга тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх ТЭЗҮ-г Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ны жилд 1.0 сая тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэчилсэн ТЭЗҮ-г боловсруулж байна. | | |
| 47 | | 4.1.2 Хөрөнгө оруулалтыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | 2021-2025 | 200.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2020 | Иргэдийн оролцоотой 322.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 100 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 800.0сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 400 төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 68.5 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 200 сая төгрөг батлагдсан бөгөөд 48 төсөл арга хэмжээг 100 хувь амжилттай хэрэгжүүллээ.<br>Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламж "Өвсний үндэс" төслийн хүрээнд Дархан сумын "Энэрэл" сургуулийн барилгын их засварын ажлыг 600.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Дархан сумын 15-р багт 960 хүүхдийн сургуулийн барилгыг Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн 10.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Дархан сумын 5-р баг 15-р сургуулийн барилгын 00 засвар, 12-р сургуулийн 00 засварын ажлыг 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Дархан хотод үйлдвэр үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн нэгдсэн тооллого бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 720.4 сая төгрөгийн дэд бүтэц, нийгмийн чиглэлийн 79 төсөл, арга хэмжээг 100 хувь амжилттай хэрэгжүүллээ.<br>2023 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 1,044.7 сая төгрөгийн гэрээ байгуулж дэд бүтэц, нийгмийн чиглэлийн 71 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 1,315.7 сая төгрөгөөр зарцуулж байна.<br>2024 онд Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,269.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүллээ.<br>Үр дүн: 2024 онд Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 70% | 70% |
| 48 | | 4.1.3 Мал амьтны гаралтай түүхий эдийн бэлтгэл нийлүүлэлтийн сүлжээ, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 300.0 | Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулна. | 2020 | Сургалт, аялалд 2 хоршооны 400 гаруй гишүүд, махны 2 үйлдвэр, хамрагдсан. Мал амьтны гаралтай түүхий эдийн худалдааны төв Хонгор, Шарын гол суманд ажиллаж, нийт 120722 ширхэг арьс шир, ноос | Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхийг сайжруулна | 300.0 | 2024 онд "Мах, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт, зохистой дадал нэвтрүүлэх заавар" танилцуулах сургалтад сүү бэлтгэн нийлүүлэгч, мах, сүү боловсруулах үйлдвэрийн нийт 33 хүнд, үйлдвэрийн аргаар мал төхөөрөх, нийлүүлэх асуудлаар 2 үйлдвэрийн 3 төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан.<br>2024 онд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаанаас "Баян зөгий хоршоо" Улсын "Шилдэг хоршоо", "Мөнхөд үржих зөгий" хоршоо аймгийн "Шилдэг хоршоо"-гоор тус тус шалгарсан. "Дэлхийн зөн" ОУБ-тай хамтран "Хөдөлмөр эрхлэлт хамтын ажиллагаа зөвлөгөөн"-д 80 өрхийн үйлдвэрлэгч оролцож, 5 хоршооны гишүүн 25 иргэн үзэсгэлэн гаргаж, бүтээгдэхүүнээ сурталчиллаа.<br>Хонгор сумын "Шийрийн шугуй" хоршоо, Дархан сумын "Дархан Сэлэнгийн 3 үеийн дундын буян" хоршоод Хөдөө аж ахуйн биржийн итгэмжлэгдсэн агуулахын гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Тахианы 1 аж ахуйн нэгжид 40.0 сая.төг-ийн батлан даалттай зээлд хамруулсан ба 2023 онд ЖДҮХС-ийн зээлд 2 аж ахуйн нэгжид 320.0 сая.төг-ний зээл олгож, өндөг үйлдвэрлэлийг дэмжсэнээр туслах аж ахуйгаас 0.76 тн шувууны мах, 1.5-2.5 сая ширхэг өндөг бэлтгэн нийлүүлж байна. | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 208 тн, 129,1 тн ноолуур бэлтгэсэн. | | | 2024 онд ЖДҮХС-ийн зээлээс мал төхөөрөх үйлдвэр ашиглалтад оруулах "Элбэг аз хур" ХХК-д 300.0 сая.төг, мөн түүхий эд, бэлтгэн нийлүүлэх эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 4 хоршоонд 248.8 сая.төг олголоо. ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 6 хоршоонд 165.9 сая.төг-ийн санхүүжилт олгож, 30 ажлын байр хадгалагдлаа. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 2024 онд шинээр 79 мал аж ахуйн хоршоо байгуулагдаж, 45 хоршоо 3350.0 сая.төг-ийн зээлд хамрагдлаа. Хүнсний хувьсгалын хүрээнд 2023-2024 онд Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд сүү боловсруулах 1, мах боловсруулах 3, мал төхөөрөх 1 үйлдвэр, нийт 5 үйлдвэрт 3.624 тэрбум төг-ийн зээл олгож, дэмжлэг үзүүлсэн.<br>Сүү боловсруулах 6, мал төхөөрөх 2, мах боловсруулах 25, арьс шир боловсруулах 2, ноос, ноолуур 16 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна.<br>2024 онд 4 аж ахуйн нэгж 3 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортлох хүсэлт ирүүлсний дагуу тохирлын үнэлгээг хийж, 97 ширхэг сертификат олголоо. Үүнд:<br>-Таймлэсс ХХК 9383,3 кг эсгийн бүтээгдэхүүнийг Норвеги, БНСУ улс руу,<br>-Дархан меат фүүдс ХХК 1932,3 тонн боловсруулсан болон хэсэглэж ангилсан махыг БНХАУ, Узбекистан улс руу,<br>-Алижан ХХК 14,5 тонн адууны гэдсийг Казахстан улс руу,<br>-Дархан минж ХХК 19641 кг ямаа, хонины арьсыг Итали улс руу тус тус экспортолсон.<br>2021-2024 онд мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлохоор 5 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг тухай бүр үнэлгээ хийж нийт 448 ширхэг сертификат олгосон. Үүнд:<br>-Дархан минж ХХК 74480 ширхэг үхэр, сарлагийн хөх шир болон 19641 кг хонь, ямааны арьс,<br>-Дархан меат фүүдс ХХК 90815.2 тонн боловсруулсан болон хэсэглэж ангилсан мах,<br>-Таймлэсс ХХК 91811 ширхэг эсгий бүтээгдэхүүн болон 9383,3 кг эсгийн бүтээгдэхүүн,<br>-Алижан ХХК 25,8 тонн адууны дайвар бүтээгдэхүүн,<br>-Нэхий таннери ХХК 119,7 кг А сортын хонины арьсыг тус тус экспортод гаргасан.<br>Мөн Дархан эрдэнэ мах комбинат ХХК нь малын мах экспортлох хүсэлт гаргаж, бодлогын гэрээ болон дамжин өнгөрөх гэрээгээ байгуулж, бог мал төхөөрөх шугам шинээр ашиглалтад оруулсан.<br>Үр дүн: 2024 онд 4 аж ахуйн нэгж 3 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортлох хүсэлт ирүүлсний дагуу тохирлын үнэлгээг хийж, 97 ширхэг сертификат олгосон. | | |
| 49 | | 4.1.4 Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, дотоодын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 2021-2025 | - | Аялал жуулчлалын үзэсгэлэн, худалдаанд оролцсон, тоо | 2020 | "Дархан цом-2021" Мөсний загасчлалын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг орон нутагт зохион байгуулсан. | Орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, төрлийг нэмэгдүүлэн сурталчилж жуулчдын тоог нэмэгдүүлнэ | 13,0 | 2023 онд Европын Холбооны санхүүжилттэй НАЙРАМДАЛ төслийн хүрээнд НАЙРАМДАЛ төсөл, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар хамтран "Тогтвортой аялал жуулчлал" чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын холбоо, Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, амралт сувилал, бусад холбоодын төлөөлөл, тур оператор, шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд нийт 70 ААНБ, иргэдийг хамруулсан.<br>Орон нутгийн онцлогт нийцүүлэн Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутагт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Тусгай сонирхлын спорт, аялал жуулчлал тэмцээнийг "Дарханы Загасчлалын Холбоо" ТББ-тай хамтран "Дархан цом-2023" мөсний спортын загасчлалын дадлага, сургалтыг "Түшиг Уул" ХХК-ийн хиймэл нуурт зохион байгуулж, дотоодын 24 багийн 72 тамирчин оролцсон<br>"Дрон шоу", "Дрифт шоу" зэрэг орон нутгийн чанартай спортын төрлүүдээр эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг болсон.<br>"Тогтвортой аялал жуулчлал" хөгжүүлэхэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөгийг "ДАРХАН 50" цогцолборт зохион байгуулж, Дугуйн холбоо, Мастер тогоочдын холбоо, Дархан Загасчлалын холбоо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Дархан Аялал жуулчлалын холбоод, Данс дүүрэн ХХК,Sky зочид буудал, Цайны их зам ХХК өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа байршуулах хэрэгсэл болон үзвэр үйлчилгээний байгууллага, эвент арга хэмжээнд хүрэлцэн ирж оролцогчидын тоо 2023 онд дотоодын 150286, гадаадын 3705 нийт 153991 жуулчин ирсэн байна<br>2024 онд Аялал жуучлалын үзэсгэлэн худалдаанд 3 удаа 5 аж ахуй нэгжтэй хамтран оролцож орон нутгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан оролцсон.Орон нутгийн иргэдэд тулгуурлан тусгай сонирхлын аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжин хөгжүүлэхээр нийт 9 арга хэмжээг тогтмол зохион | 90% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгуулаад байна. Нийт арга хэмжээнд 1500 гаруй оролцогч оролцсон. Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудтай ажил хэргийн уулзалт, сургалтыг СХЗХ, ХХААГ,ЭМГ-тай хамтран зохион байгуулж нийт 60 хүн оролцлоо. Мөн аялал жуулчлалын 2 тур оператор компаниудтай хамтран автобустай аяллыг тусгай хөтөлбөр, маршрутын дагуу зохион байгуулж нийт 500 гаруй хүүхэд хамрагдлаа. Мөн Хонгор сумын Хар бэлчир, зулзагын голын 2 малчин айл өрхтэй хамтран Дархан морин аяллын клуб 4 шөнө 5 өдрийн аяллыг зохион байгуулж дотоодын 120, гадаадын 86 жуулчин хүлээн авсан байна.<br>**Үр дүн:** 2024 онд морин аяллыг зохион байгуулж гадаадын 86, дотоодын 120 жуулчин хүлээн авлаа. | | |
| 50 | | 4.1.5 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Салбарын ТББ-тай хамтран сургалт зохион байгуулж, хоршоод болон боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана. | 2020 | Малчдын хоршоо, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 273 иргэн, хөнгөлөлттэй зээлд 2 үйлдвэр хамрагдаж, хүчин чадлыг нэмэгдүүлж, SECIM II төслөөр 2 махны үйлдвэр 98.5 сая, сүү боловсруулах 2 цехд 52.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Салбарын ТББ-тай хамтран сургалт зохион байгуулж, хоршоод болон боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана | 16575.3 сая | **Уулзалт, сургалт:** Малчид, фермер эрхлэгч, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, махны салбарынхан-/малчин, ченж, үйлдвэр, худалдаа/-тай ХХААГ-ын дарга үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсээр тогтвортой хангах асуудлаар уулзалтыг тус тус шат дараатай хийж, дэвшүүлсэн санал хүсэлтийг ХХААХҮЯ-д уламжиллаа. ЖДҮГ, ХХААГ, Хөгжлийн шийдэл ТББ-ын Бест хөтөлбөртэй "Төрийн худалдан авалтын сургалт, хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл", "Зээлжих боломжийг нэмэгдүүлэх нь", "Ажлын байрыг дэмжих зээл", "Зээлийн батлан даалтад аж ахуй нэгжийг хамруулах нь", "Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт хууль тогтоомж, хөнгөлөлттэй зээлийн танилцуулга", "Малчдын хоршоо - Үндэсний үйлдвэрт түүхий бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт", "Хөдөө аж ахуй болон хүнсний салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт", "Хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл, төсөл хөтөлбөрийн танилцуулга", "Жижиг, дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх нь" танхим, цахим 6 сургалт, "Хөдөө аж ахуйн салбарын санхүүгийн шинэ гарц, шийдэл" зөвлөгөөн, Бодлогын шийдэл ТББ-тай "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт", мөн Японы Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгөөр Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл" /МОН 91:92/-ийн хүрээнд төсөлд хамрагдсан 70 өрх болон Газар шим өгөөж хоршоо, Орхон хөрс хоршооны гишүүдэд "Хүлэмжний хүнсний ногоо ургуулах технологи сургалт", "Хоршооны ахисан шатны сургалт", "Компос бордооны хэрэглээ үйлдвэрлэл", "Ургамал хамгааллын сургалт", "Усалгаатай тариалан", "Хүнсний ногоо хадгалалт", "Амьдрах ухаан", "Хамгаалагдсан хөрсний аж ахуй" зэрэг цахим, танхим, талбайн хосолсон сургалтууд, Найрамдал төсөлтэй хамтран "Уур амьсгалын нөхцөлд тохирсон ухаалаг газар тариалан ба агропренершип чадавхижуулах" онол туршлага хосолсон сургалт, Монгол ногоо төсөлтэй "Төмс, хүнсний ногооны боловсруулалт, хэрэглээг нэмэгдүүлэх" зэрэг танхимын 34 сургалт, "Оёдлын салбарын 20000 кластр зөвлөгөөн", Дэлхийн зөн ОУБ-тай "Хөдөлмөр эрхлэлт хамтын ажиллагаа зөвлөгөөн", Германы хамтын ажиллагааны нийгэмлэг орон нутагт хэрэгжих төслийн уулзалт болон салбарын уулзалт, нийт 2400 хүнд, 2024 онд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий арга хэмжээнд нийт 800 гаруй иргэн, аж ахуйн нэгж, "Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх" сэдэвт сургалтад нийт 58 сүү бэлтгэн нийлүүлэгч, сүү боловсруулах болон талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрийн ажилтнуудад зохион байгуулсан. Мөн Сүүний урамшуулалд малчдыг хамруулах зорилгоор сүү боловсруулах 2022-2023 онд 2 үйлдвэр 58 малчин, 2023-2024 онд 1 үйлдвэр 27, 2024-2025 онд 2 үйлдвэр 38 малчинд сургалтаар зөвлөгөө өгч ажиллав.<br>**Дэмжлэг:** "Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй зээл"-д 566 иргэн, 132 аж ахуйн нэгж 41.16 тэрбум төгрөг, Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд 188 иргэн, аж ахуйн нэгжид 66.8 тэрбум төгрөгийн 5-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олголоо.<br>ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд 2022-2024 онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 хоршоо, 15 аж ахуй нэгж нийт 3.75 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.<br>Хөгжлийн шийдэл ТББ, Найрамдал төсөлтэй хамтран хөдөө аж ахуй болон хүнсний салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг 3 сарын хугацаанд чадавхжуулах 7 удаагийн танхим, 3 удаагийн цахим сургалтад 115 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан "Найрамдал" төсөлд хүлэмжийн аж ахуй эрхлэгч 1 аж ахуйн нэгжид 20.0 мянган еврогийн дэмжлэг, Хөгжлийн шийдэл ТББ-ын Бест хөтөлбөрт Найрамдал мөөг хоршоо, Одод бест милк ХХК тус тус 10.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.<br>Европын холбооны 12 төлөөлөгч нарт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | боловсруулах 28 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилснаар 4 аж ахуйн нэгж Турк улсад туршлага судаллаа.<br>2024 онд арьс шир боловсруулах Дархан минж ХХК, бялуун бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Жүр үр ХХК-ийг "Хүнсний хувьсгал"-ын цахимаар сурталчилж, ургамлын гаралтай хүнс үйлдвэрлэгч 12 аж ахуйн нэгжийн 2023-2024 онд авсан эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн үр дүнд хяналт хийж ажиллалаа.<br>"Шинэ хоршоо" хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд Улаанбаатар хотод 78 малчид, 600 гаруй төлөөлөгч бүхий бүсийн зөвлөлгөөнийг аймагтаа зохион байгуулан 300 гаруй малчдыг хамруулан хөдөлгөөний сурталчлах арга хэмжээнд малчид, Хонгор, Шарын гол сумдад ЗГХЭГ-ын гишүүдтэй хамтран сургалт хийж, 120 малчид, 1196 малчин өрхөд шинэ хоршооны хөдөлгөөний мэдээллийг ажлын хэсгүүд хүргэж ажилласнаар шинээр 79 мал аж ахуйн хоршоо байгуулагдаж, 45 хоршоо 3350.0 сая төгрөгийн зээлд хамрагдлаа. АДРА Германы 1.6 сая еврогийн санхүүжилттэй "Органик хөдөө аж ахуйн түншлэл-2" төсөл "Хоршоодыг чадавхжуулан, органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, органик хүнсний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг бий болгох замаар хоршоодын үйл ажиллагааг сайжруулах"-аар 2023 оны 10 дугаар сараас 2026 оныг дуустал хэрэгжиж буй бөгөөд энэхүү төсөл хэрэгжүүлэх судалгааны ажилд хөдөө аж ахуйн салбарын 30 хоршооны мэдээллийг гарган хүргүүлснээр 10 хоршоо буюу Хонгор сумын 1 Орхон сумын 9 хоршооны гишүүд баталгаажуулалтын тангараг өргөж, хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулах эхлэл тавигдлаа.<br>Суурь онтой харьцуулахад: Арьс шир, ноосон бүтээгдэхүүний үйлдвэр 9-өөр нэмэгдэж 31, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр 6-аар нэмэгдэж 27 хүнсний ногоо боловсруулах үйлдвэр, цех 1-ээр нэмэгдэж 9 болсон. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулалтаар гурил 7530 тн-оор, талх, гурилан бүтээгдэхүүн 186 тн-оор, хиам 74 тн-оор, нэхий дээл 7343 ш-ээр,савхин дээл 856 ш-ээр тус тус өссөн.. Тус салбарт хөнгөний 31, хүнсний боловсруулах 64 аж ахуйн нэгж ээлж байна.<br>Үр дүн: Бүтээгдэхүүний үйлдвэрлэл: арьс, шир боловсруулах, ширэн эдлэл 509.0 сая.төг-өөр, хүнс, үндаа 42812 сая.төг-өөр өссөн ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт 41265 сая.төг-өөр тус тус өссөн | | |
| 51 | | 4.1.6 Худалдаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, цахим үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2021-2025 | - | Махны төрөлжсөн 3 дэлгүүр, гурилан бүтээгдэхүүний 1 үйлдвэр шинээр байгуулагдаж, худалдаа үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулна. | 2020 | Дархан суманд 276, Шарын гол суманд 47, Орхон суманд 12, Хонгорт 25 аж ахуйн нэгж, иргэн хүнсний худалдаа үйлчилгээг иргэдэд хүргэсэн. | Орчин цагийн үйлчилгээний шинэ төрөл болох захиалгат болон хүргэлтийн үйлчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. | 118.0 сая | 2021-2024 онд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран 6 сургалт, 1 хэлэлцүүлэг, 1 уулзалт, 2 хяналт шалгалтаар мэргэжил аргазүйн зөвлөгөө, 12 уралдаан зохион байгуулсан. Үүнд: ХХААГ, СХЗХ, "Хөгжлийн шийдэл" ОУБ-ын "BEST" хөтөлбөр хамтран жижиг дунд бизнес эрхлэгч, хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" хууль, Засгийн газрын 291-р тогтоол, бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын үнэлгээний талаар, "Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, төрийн худалдан авалт", "Салбарын хууль тогтоомж, стандарт, хөнгөлөлттэй зээлийн танилцуулга" сэдвээр тус тус сургалт, мэдээллийг хүргэсэн. Шинээр болон шинэчлэн батлагдсан "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5021-1:2019 стандартыг мэдээлэх, сурталчлах зорилгоор ХЭАХН, МХГ, ХХААГ, СХЗХ, ШӨХТГ-ын орон нутаг дахь улсын байцаагч, мэргэжилтэн нар хамтран "Стандарт, Эрүүл ахуйн зохистой дадал, хүнсний аюулгүй байдал, сав баглаа боодол, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх" сэдвүүдээр Дархан сумын 2 саун, 6 халуун усны газрын 8 ажилтанд, 19 удаагийн танхимын сургалтаар Орхон, Хонгор, Шарын гол сумын хүнсний худалдаа эрхлэгч 31 иргэн, нийт 1050 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, мэдлэг олгосон. Худалдааны салбарын бизнесийн орчин ба санхүүжилтийн боломж" уулзалтад 50 гаруй худалдаа эрхлэгчдийг хамруулж, гарсан санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилсан. "Худалдаа 2022" спортын арга хэмжээг зохион байгуулж, 10 байгууллагын 150 ажилтан хамрагдаж, ур чадвараараа өрсөлдөж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн. Нийтийн хоол үйлдвэрлэл эрхлэгч ресторан, зоогийн газарт "Хоол үйлдвэрлэлд баримталж буй бодлого", "Давсны хэрэглээг бууруулах", "Зориулалтын бус сав баглаа боодол" сэдэвт сургалт, сургууль, цэцэрлэг эмнэлгийн байгууллагын эрхлэгч, эмч, тогооч нарт "Үдийн хоол" хөтөлбөрийн "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдал цаашдын төлөвлөлт" сэдэвт хэлэлцүүлэг, уулзалтыг тус тус зохион байгуулж, гарсан санал хүсэлтийг БШУЯ-д албан бичгээр, Хүүхдийн хоол чуулганд санал хүсэлтийг уламжилсан. Эрсдэлгүй Дархан аян хүрээнд нийтийн зээмшлийн орон сууцны нэгдүгээр давхарт байрлалтай хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангуулахаар мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан. Цэцэрлэг, сургууль, эмнэлгийн байгууллагын "Аварга тогооч шалгаруулах" ажил мэргэжлийн уралдаан 1 удаа зохион байгуулсан. Аймаг, | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | бүсийн болон улсын аварга тогооч шалгаруулах ажил, мэргэжлийн уралдаан болон хоол үйлдвэрлэлийн ажиллагсдын спортын арга хэмжээнд 2022 онд 14 тогооч, 1 нарийн боовчин, 2023 онд 10 төрөлд 21 байгууллага буюу боловсролын 8 байгууллага, 11 аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх хоол үйлдвэрлэлийн 2 байгууллагын тогооч, зөөгч, 2024 онд Орхон аймагт 46 тогооч, зөөгч оролцож, ур чадвараа дээшлүүлсэн.<br>2024.05.16-ны өдөр 3 аж ахуйн нэгж, байгууллагын амралтын газрын үйл ажиллаанд шалгалт хийж, тохирлын үнэлгээ хийж, зөвлөгөө өгч, Тохирлын гэрчилгээ олголоо. Хөгжлийн Шийдэл ТББ, ХХААГ тохирлын үнэлгээнд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээнд “Тохирлын гэрчилгээ олгох” сургалтыг 2024.05.29-30-ны өдрүүдэд нийт 15 бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, 2 үйлчилгээний байгууллагад, 2024.03.14-ны өдөр нөөцийн махны хадгалалтын горим, жин хэмжүүрийн баталгаажилт, сав баглаа боодлын битүүмжлэл, татварын и-баримт олгох сургалтыг 47 хүнсний дэлгүүрт, үйлдвэрт сүү нийлүүлэгч 27 малчинд сүүний хэм, тээвэрлэлтийн горим, сүүний чанарын үзүүлэлтээр сургалт, зөвлөгөөг өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>Худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй судалгаагаар Дархан-Уул аймагт 444 худалдаа, үйлчилгээний байгууллага үйл ажиллагаар эрхлэн явуулж байна. Салбараар авч үзвэл хүнсний дэлгүүр 289, мухлаг 49, минимаркет 38, супермаркет 20, хайпермаркет 2, орчин цагийн ая тухтай дэлгүүр 9, агуулах 17, зах 5, ШТС-ийн дэргэдэх дэлгүүр 2, махны төрөлжсөн дэлгүүр 13 байна. Сумдаар нь ангилбал: Дархан сум 349, Шарын гол сум 53, Орхон сум 13, Хонгор сум 29 худалдаа, үйлчилгээний байгууллага байна. Шинээр Хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн 1 супермаркет, 1 минимаркет байна. Орчин цагийн үйлчилгээний сүлжээ дэлгүүр болох CU, GS25, Ди-24, АМУ молл зэрэг хэрэглэгчдэд үйлчилгээгээ ойртуулсан төрөлжсөн дэлгүүр шинээр нэмэгдсэн. Судалгааны дүнг өмнөх онтой харьцуулахад худалдааны чиглэлийн үйлчилгээний байгууллага 10.8%-иар өссөн байна. Худалдааны гудамд 24 ш асар түрээсийн зардалгүй Найрамдал талбайд байршуулснаар 150 гаруй иргэний түр ажлын байр бий болсон.<br>Үр дүн: Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн стандарт болон хуулийн мэдлэг дээшилж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, стандарт хэрэгжилтийн түвшин 85%-с дээшилж, 88%-д хүрсэн. | | |
| 52 | | 4.1.7 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулах түвшинг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 420.0 | Эвдэрч ээнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээнэ. | 2020 | Уул уурхайн чиглэлээр 18 ААН, 5 бичил уурхай 120 га талбайд олборлох үйл ажиллагаа явуулсан. | Өссөн дүнгээр 140 га-с багагүй талбайд нөхөн сэргээлт хийнэ. | 420.0 | 2021 онд Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуйн нэгж, байгууллага, 5 бичил уурхайн нөхөрлөлүүд нийт 140.5 га талбайд нөхөн сэргээлтийг 1.1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж, дүйцүүлэн хамгааллаар 3 аж ахуйн нэгж, байгууллага, 4 бичил уурхайн нөхөрлөл эвдэрч ээнгүй орхигдсон 18.6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Шарын гол сумын Цагаан хөтөл гэх газар хийгдсэн 3 га газрын техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг актаар хүлээн авсан. 24,8 сая төгрөгөөр Шарын гол сумын Цагаан хөтөл гэх газарт Экомайнинг ассессмент ХХК нь 3 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, 3000 ширхэг улиас, бургас, агч модыг тарьж, хашаажуулан хүлээлгэн өгсөн. Өссөн дүнгээр 146.5 га-д нөхөн сэргээлт хийсэн.<br>2023 онд аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8, бичил уурхайн нөхөрлөл 4, түгээмэл тархац болон шохойн чулуу чиглэлээр 4, нийт 16 аж ахуйн нэгжүүд техникийн 35,84 га, биологийн 6 га, дүйцүүлэн хамгааллаар 40,39 га, нийт 82.23 га талбайд нөхөн сэргээлт хийгдсэн.<br>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 9 аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрлийн талбайд техникийн нөхөн сэргээлтийг 56,71 га, биологийн нөхөн сэргээлтийг 10,5 га талбайд, дүйцүүлэн хамгаалах хүрээнд 6 ААНэгж нь 15.75 га талбайд техникийн, авто замын барилгын ажилд ашигласан карьерын 49.64 га техникийн, орон нутгийн төсөв хөрөнгөөр эвдэрч орхигдсон газарт хийгдсэн 2 га техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгэсэн.<br>Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын карьеруудын нөхөн сэргээлтийн ажлын газар дээр нь шалгаж, судалгаа зураглал хийх ажлын удирдамжийн дагуу хяналт шалгалтаар Хонгор сумд түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос эвдэрсэн 6 карьерт стандарт шаардлагын дагуу техникийн нөхөн сэргээлт хийсэн ажлыг хүлээн авсан.<br>Цаашид техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөх, хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн.<br>Үр дүн: Нийт техникийн нөхөн сэргээлт 339.62 га, биологи нөхөн сэргээлт 10.5 га талбайд хийж гүйцэтгэсэн байна. | 100% | 70% |
| | | 4.1.8 Эдийн засгийн | | | Үйлдвэрлэлийн | | Дулаан, | Дулаан, | | ТК80-ТК94 худаг хүртэлх одоо байгаа 2Ф250мм янданг шинэчилж, ТК93-ТК94 худаг хүртэлх одоо байгаа Ф150мм-ийн голчтой хоолойг Ф200мм болгон | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | | өсөлтийг дэмжсэн үйлдвэрлэлийн бусийн инженерийн дэд бүтцийг өргөжүүлнэ. | 2021-2025 | 27,313.0 | бүсийн төвлөрсөн инженерийн дэд бүтцийг өргөжүүлнэ. | 2020 | цэвэр ус, цахилгааны шугамын гүйцэтгэл 50%, | цэвэр ус, цахилгааны шугамын гүйцэтгэл 100% | 11,190.0 | өргөтгөх, 8ш дулааны худгийг шинэчлэх ажлыг Улсын төсвийн 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Дулаан Дамжуулах сүлжээний ТК.27-ТК.39 худгийн хооронд дулааны магистрал шугамын өргөтгөл, их засварын ажлыг 8.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж 2024 онд байнгын ашиглалтад оруулсан. Ингэснээр Төрийн болон Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Арьс шир боловсруулах үйлдвэрийн дулаан хангамжийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдсэн.<br>**Үр дүн: Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Арьс шир боловсруулах үйлдвэрийн дулаан хангамжийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдсэн.** | 100% | 100 % |
| 54 | | 4.1.9 Бүс орон нутгийн тээвэр, ложистикийн төвтэй болно. | 2021-2025 | 0 | Боловсруулсан төсөв, тооцооны тоо<br>Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл,% | 2020 | Төмөр замын тээвэр ложистикийн төвтэй. | Бүс орон нутгийн тээвэр, ложистикийн төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. | - | Бүс орон нутгийн тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж байна.<br>Орон нутгийн тээвэр логистикийн төвийг Хонгор сумын нутагт барьж байгуулахаар төлөвлөж, орон нутгийн төсвийн 399,2 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар 200 авто машины зогсоолын ажлыг хийж хэрэгжүүлсэн.<br>Орон нутгийн тээвэр логистикийн төвийг байгуулах эхний үе шатны ажлыг эхлүүлж авто зогсоолыг барьж байгуулсан.<br>**Үр дүн: Орон нутгийн тээвэр логистикийн төвийг байгуулах эхний үе шатны ажлыг эхлүүлж авто зогсоолыг барьж байгуулсан.** | 100% | 30% |
| 55 | | 4.1.10 Гадны болон дотоодын эрдэм шинжилгээний байгууллагын шинжилгээ судалгаанд суурилсан, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | ХХААГ болон УГТХ хамтран төлөвлөгөөг боловсруулан батлуулна | 2020 | УГТХ-ийн судалгаанд суурилан "Бордоо" төслийг хэрэгжүүлсэн. | УГТХ-с гаргасан 6-аас доошгүй шинэ нутагшсан сорт, зөвлөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. | - | Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд "Төр, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх"-ээр тусгагдаж энэхүү ажлын хүрээнд УГТХүрээлэнтэй 2021-2025 он хүртэл хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд эрдэм шинжилгээний байгууллагын судалгаанд үндэслэсэн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Энэхүү ажлын хүрээнд 2021-2023 оны газар тариалангийн салбарт баримтлах бодлого, чиглэл, зөвлөмжийг хүргүүлэх таниулах зорилтын хүрээнд УГТХ-тэй хамтран "Тариаланчдын зөвлөгөөн"-ийг зохион байгууллаа. Мөн хөрсний үржил шимийг сайжруулах га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах Дархан "Ризо био шингэн бордоо"-г 80 тонн, Ризобактерийн хуурай бордоо 1000 кг-ыг тус тус үйлдвэрлэж тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нийлүүлээд байна. Үр тариа, төмс, хүнсний ногооны хянан баталгааг УГТХүрээлэнтэй хамтран жил бүр тогтмол зохион байгуулснаар тариалалтыг чанарын шаардлага хангасан үрээр тариалах нөхцөл бүрдсэн байна. Ургамал газар тариалангийн хүрээлэнд тайлант онуудад нийт буудайн 5 сорт, арвайн 3 сорт, буурцагт таримлын 2 сорт, төмсний 3 сорт, хүнсний ногооны 6 нэр төрлийн 8 сорт, хүлэмжийн лоолийн 3 сорт, жимс жимсгэний 3 нэр төрлийн 12 сортын үр үржүүлэг, цуглуулга судалгааны ажил хийгдсэн байна.<br>БНСУ, Найрамдал төсөл хамтран хоолны хог хаягдлаар органик бордоо үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг хэрэгжүүлж, Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн Инчеон Инновацийн Био бордооны лабораторт хүлээлгэн өгч нээлт хийлээ. Үүнээс гадна цахилгаан машины хаягдал батарейг ашиглан цахилгаан нөөцөлж, цахилгаанаар хангах батарейг БНСУ анхдагчаар үйлдвэрлэж, сурталчиллаа. Энэ нь нарны зайн эх үүсвэрээр бол 2 цагт цэнэгээ хураана, цахилгаанаар цэнэглэхэд 1 цагт цэнэгээ хурааж, 2 өдрийн турш 220Вт-д ашиглах боломж бүрдүүлсэн байна.<br>**Үр дүн: 4 жилийн хугацаанд буудайн 5 сорт, арвайн 3 сорт, буурцагт таримлын 2 сорт, төмсний 3 сорт, хүнсний ногооны 6 нэр төрлийн 8 сорт, хүлэмжийн лоолийн 3 сорт, жимс жимсгэний 3 нэр төрлийн 12 сортын үр үржүүлэг, цуглуулга судалгааны ажил хийгдсэн.** | 100% | 100 % |
| 56 | | 4.1.11 Малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийн доройтлыг бууруулах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ. | 2021-2025 | 57.5 | Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйд махны гарц нэмэгдүүлэх үржил, селекцийн ажлыг эрчимжүүлнэ. | 2020 | Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлсэн.<br>Бэлчээрийн огтонтой тэмцэх ажлыг 60 мян.га д явуулсан | Таримал тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн эрчимжсэн мал аж ахуйд нийлүүлнэ. | 57.5 | Тус аймаг нь Монгол улсын тариалангийн бүс нутагт байрладаг газар зүйн боломжит нөхцөл, сүүлийн жилүүдэд Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас бүс нутгийн чиглэлээр явуулж байгаа бодлого зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр ашиг шимтэй мал сүргийг өсгөн үржүүлэхэд таримал тэжээлийн төрөл, талбайн хэмжээг нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байна.Энэ ажлын хүрээнд 2019-2023 онуудад Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол улсад "Тэжээлийн тогтвортой менежмент" төсөл хэрэгжиж, мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах зорилгоор тэжээл үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид тогтвортой хөгжүүлэх, төлөвлөх талаар чиглэгдсэн дүгнэлтүүдийг орон нутгийн төлөөлөлтэй хэлэлцүүлэн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.Тухайлбал 2023 онд "Шимт агро" ХХК-ийн тэжээлийн үйлдвэр байгуулах төсөлд ЖДҮ-ийг дэмжих сангаас 290.0 сая.төг-ийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.Мөн 2023 онд УИХ-ын 36-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯамнаас хөдөө аж ахуйн | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авахад эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олголтод 1 аж ахуйн нэгж хамрагдан 66.0 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.2024 онд төвийн бүсийн малыг төрөлжүүлж, эрчимжүүлэн хөгжүүлэх, эрчимжсэн аж ахуй, малчдын малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шарын гол сумын эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага, фермер, хоршоодод малын тэжээлийн норм жор болон Халгай, Лууль, Шарилж гэх мэт хөл газрын ургамлаар дарш бэлтгэх технологийн сургалтыг зохион байгуулж ажиллаа. Мөн сүүлийн жилүүдэд өндөр ашиг шимтэй Герефорд үүлдрийн 4 бухыг үржилд сайжруулагчаар ашиглаж байгаагаас гадна 2023 онд Хонгор сум Баяд, Керей үүлдрийн хуц, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ухна нийт 60 толгой хээлтүүлэгчийг худалдан авахад 25.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд хээлтүүлэгчийн суурь байгуулан ажиллаж байна. Ноёнхонгорт үйл ажиллагаа явуулж буй "Түмэн Монгол Суффолк" ХХК нь УБ хотын "Тайшир өргөө" ХХК-аас мах-ноосны Бершон, Суффолк, Арманов, Меринос үүлдрийн нийт 348 эр, охин хонь авч сүрэг сэлбэн үржүүлж байна. ХХААХҮЯ-ны харьяа МУСҮТ Монгол улсад нутагшуулсан гойд ашиг шимт малын дуудлага худалдаа зохион байгуулсан бөгөөд Лимузин, Ангус үүлдрийн 5 бухыг гэрээний үндсэн дээр авч үржилд сайжруулагчаар ашиглаж байна. 2021-2022 онд Эрчимжсэн мал ахуй эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн 57.8 сая төгрөгийн хөрөнгөөр 180 тонн буюу 9000 боодол ногоон тэжээлийг бэлтгэн 2022 оны мал төллөлтийн үеэр 148 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчдад олгож дэмжлэг үзүүлсэн.<br>Эрчимжсэн мал ахуй эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын өгсөн үүргийн дагуу, Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төвийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн эрчимжсэн аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг нэгтгэн гаргаж ХХААХҮЯ-д хүргүүлэн ажиллаж байна.<br>"Монгол мал" Үндэсний хөтөлбөрийн 3 дугаар бүлэг 3.2.2.5, 3.2.2.6 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын "Төлөвлөгөө батлах тухай", 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А-729 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А-02 дугаар албан даалгавар, Малын удмын сангийн үндэсний төвийн захирлын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А-10 дугаар тушаалын хүрээнд төвийн бүсийн малыг төрөлжүүлж, эрчимжүүлэн хөгжүүлэх, эрчимжсэн аж ахуйд малчдын малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ХХААХҮЯ-ны харъяа, Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран 500 толгой хонинд шингэн үрээр зохиомол хээлтүүлэг хийлээ. Бод малын хувьд аймгийн хэмжээнд 230 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийж , ХХААХҮЯ-ны харъяа, Малын удмын сангийн үндэсний төвийн мэргэжилтэн, ХХААГ-ын улсын байцаагч нар хээлтүүлэгт хамрагдсан үхэрт хээлийн шалгалтыг хийж байна.<br>Зудын улмаас мал нь хорогдож малгүй болсон, цөөн малтай малчин өрхийг дэмжих, тэднийг малжуулах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт малжуулах төсөл хөтөлбөрт хамрагдахаар нийт 83 малчин өрх хүсэлтээ өгснөөс 48 малчин өрхийг сонгон шалгаруулж санхүүжилтийг олгохоор холбогдох гэрээг хийж байна. Уг төсөл хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн малыг бүртгэл мэдээллийн санд бүртгэх, тухайн малын үүлдэрлэг байдал ашиг шимийн чиглэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч хамтран ажиллаа.Бэлчээрийн хөнөөлт үлийн огтонтой тэмцэх ажлыг зохион байгуулах аймгийн засаг даргын захирамжийн дагуу ажлын хүрээнд огтоно устгалын технологийн ажлын хүрээнд Хонгор сумын бэлчээрийн талбайд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 2024 онд хийсэн бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн тархалт, нягтралын тодотгох судалгаа, дүгнэлтийг хүргүүллээ. Тариалангийн бүс нутагт өндөр ашиг шимтэй мал сүргийг өсгөн үржүүлэхэд таримал тэжээлийн төрөл, талбайн хэмжээг нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2021 онд 942.5 га, 2022 онд 970 га, 2023 онд 850 га, 2024 онд Таримал тэжээлийн чиглэлээр 2 аж ахуйн нэгжид нийт 356 сая төгрөгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн байна."Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | сангийн хөнгөлөлттэй зээлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 хоршоо, 15 аж ахуй нэгж нийт 3750.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 45 хоршоо 3350.0 сая төгрөгийн зээлд хамрагдлаа.<br>**Үр дүн: Аймгийн хэмжээнд 2021 онд 942.5 га, 2022 онд 970 га, 2023 онд 850 га, 2024 онд таримал тэжээлийн чиглэлээр 2 аж ахуйн нэгжид нийт 356 сая төгрөгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн байна."Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 хоршоо, 15 аж ахуй нэгж нийт 3750.0 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 45 хоршоо 3350.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан.** | | |
| 57 | | 4.1.12 Орон нутгийн онцлогт тохирсон туслах аж ахуйг хөгжүүлнэ. | 2021-2025 | 200.0 | Өрхийн аж ахуй эрхлэгч иргэдийг бодлогоор дэмжиж ажиллана. | 2020 | Арвин ашиг шимтэй үүлдрийн гахай, тахианы тоо, толгой, зөгийн бүлийн тоог нэмэгдүүлнэ. | Хүн амын хүнсний хэрэгцээний өндөг, гахайн мах, зөгийн балны хэмжээг нэмэгдүүлнэ | 200.0 | Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 2021-2023 онд аймгийн Засаг даргын захирамжаар хотын төвөөс мал гаргах, туслах аж ахуй гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхлэгчдэд суурьшлын бүс байгуулах фермер, малчдыг дэмжих ажлыг шат дараалтай зохион байгуулж байна. Орхон сумын Ноёнхонгорын 15 га газарт туслах аж ахуй гахай, шувуу, зөгийн аж ахуйг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс дэд бүтэц татахад 190.0 сая.төг, өрөмдмөл худаг гаргахад 26.0 сая.төг зарцуулсан бөгөөд нийт 46 өрхөд газар олгосон. Мөн гахайн байр барихад төмөр замын дэр модыг хямдралтай үнээр олгож дэмжлэг үзүүлсэн байна. Мал, тэжээвэр амьтны 2021 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр 66 өрхөд 1947 гахай, 230 аж ахуйн нэгж, өрхөд 3950 бүл зөгий, 3 фермерт 14795 шувуу тоологдлоо. тахианы аж ахуй, зөгийний аж ахуй чиглэлээр 13 хоршоо, 5 аж ахуй үйл ажиллагаа явуулж, тахианы аж ахуйдад хоногийн настай дэгдээхий авч сүрэг сэлбэх ажил тасралтгүй явагдаж байна. Зөгийн аж ахуй эрхлэгч "Ачлалт алтан зөгий" ХХК-д 30 сая.төг, "Бат ихэр заяа ХХК"-д 26.0 сая төгрөг ХСХ-аас зээл олгож дэмжлэг үзүүллээ. Туслах аж ахуйг хөгжүүлэх бүсэд гахайн-2, шувууны-2, зөгийн-18 аж ахуй үйл ажиллагаа явуулж байна. ЖДҮ-ийг дэмжих орон нутагт хуваарилсан 1.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд Дархан сумын 15-р багийн иргэний "Бөднө" төсөл дэмжигдэн 70 сая, Дархан сумын тахианы Газар агуу ХХК 290 сая, хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаад байна. УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх "Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл"-д зөгийн аж ахуйн чиглэлээр 8 аж ахуйн нэгж, иргэн 391 сая, гахайн 1 өрхийн аж ахуй 52 сая, шувууны 1 аж ахуйн нэгж 1.250,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдаж үйл ажиллагаагаа өргөтгөх боломж бүрдлээ. 2021 оны мал тэжээвэр амьтдын тооллогоор 85 өрхөд 2906 гахай, 3 ААН 225 өрхөд 25921 шувуу үүнээс тахиа 24824, галуу 283, цацагт хяруул 149, нугас 208, бөднө 457, 3 өрхөд 9 туулай, 11 ААНБ 115 өрхөд 2574 бүл зөгий тоологдсон бол 2022 оны мал тэжээвэр амьтдын тооллогоор 95 өрхөд 3704 гахай, 4 ААН 142 өрхөд 32480 шувуу үүнээс тахиа 31061, галуу 286, цацагт хяруул 115, бөднө 1018, 3 өрхөд 24 туулай, 11 ААНБ 122 өрхөд 3179 бүл зөгий тоологдсон байна. 2023 оны мал тэжээвэр амьтдын тооллогоор 69 өрхөд 1892 гахай, 3 ААН 128 өрхөд 36639 шувуу үүнээс тахиа 35212, галуу 107, цацагт хяруул 57, бөднө 1263, 2 өрхөд 16 туулай, 9 ААНБ 142 өрхөд 3690 бүл зөгий тоологдсон байна. Тэжээвэр амьтдын тооллогын 2023 оны дүнг өмнөх онуудтай харьцуулахад гахай тоо буурсан үзүүлэлттэй байгаа бол зөгийн тоо өссөн дүнтэй байна. Туслах аж ахуйгаас жилд дунджаар 0.76 тн шувууны мах, 1.5-2.5 сая ширхэг өндөг, зөгийн бал 47.9тн, 19.0 тн гахайн мах бэлтгэн нийлүүлж байна.<br>2024 оны Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд явагдаж байна.<br>**Үр дүн: УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх "Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл"-д зөгийн аж ахуйн чиглэлээр 8 аж ахуйн нэгж, иргэн 391 сая, гахайн 1 өрхийн аж ахуй 52 сая, шувууны 1 аж ахуйн нэгж 1.250,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдаж үйл ажиллагаагаа өргөтгөх боломж нь бүрдсэн.** | 100% | 100 % |
| 58 | | 4.1.13 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 2021-2025 | 4.0 | Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ. | 2020 | Хүнсний үйлдвэрлэлийн 9,5%, аж үйлдвэрийн 5,5% нь брэнд шилдгээр шалгарсан байна. | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж Брэнд-1 Шилдэг-2 бүтээгдэхүүнийг жил бүр шалгаруулна | 4.0 | 2024 оны аймгийн "Брэнд бүтээгдэхүүн"-ээр "Таймлесс" ХХК-ийн "Баатар эко" эсгий шаахай, "Мах сервис" ХХК-ийн "Гүзээний ороомог", шилдэг хүнсний бүтээгдэхүүнээр "Өег гурил" ХХК-ийн "Бүхэл үрийн гурил", аж үйлдвэрийн шилдэг бүтээгдэхүүнээр "Дархан минж" ХХК-ийн "Үстэй боловсруулсан үхрийн арьс буюу хөм" шалгарлаа. Брэнд, шилдгээр шалгарсан бүтээгдэхүүнд "Дархан брэнд, шилдэг бүтээгдэхүүний лого"-г хэрэглүүлэхээр хэлтсийн дарга Б.Цэвээндорж дээрх аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, лого хэрэглүүлэхээр боллоо.<br>2021-2024 онд аймгийн брэнд бүтээгдэхүүнээр Дархан цасхан сүү ХХК, "Улаанбаатар гурил" ХХК, Хатан ивээл хайрхан" ХХК, Таймлэсс ХХК-ийн, аж үйлдвэрийн шилдэг бүтээгдэхүүнээр Як трейд ХХК, "Хатан ивээл хайрхан" ХХК, "Дархан ширэн урлал" ХХК, Дархан минж ХХК-ийн, хүнсний шилдэг бүтээгдэхүүнээр Мөнх ундрам ХХК, Дархан цасхан сүү ХХК, Говь дүүрэн шим | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ХХК, Өег гурил ХХК-ийн бүтээгдэхүүнүүд тус тус шалгарч, шалгарсан бүтээгдэхүүнд аймгийн Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 232 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтыг үндэслэн "Дархан брэнд, шилдэг бүтээгдэхүүний лого"-г хэрэглүүлэхээр аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс дээрх аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, лого хэрэглүүлэхээр боллоо.<br>**Үр дүн: Өрсөлдөгч байгууллагаас ялгарах, нэр хүндээ өргөх, имидж, нэрийн хуудасны амжилтаа тодорхойлох, хэрэглэгч болон гадаад дотоод зах зээлд танигдах, ирээдүйд олох ашиг орлогын баталгаа нэмэгдэх, зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэх ач холбогдолтой юм.** | | |
| 59 | | 4.1.14 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ. | 2021-2025 | 55,900.0 | ТӨОНӨХБАУХА ТХ-ийн 10.1.3. "орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг хамгийн ихээр ашигласан; 10.1.4. "орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан; -д заасныг тус тус үндэслэн орон нутгийн үйлдвэрлэгчид, орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудад хуулийн дагуу давуу эрх тооцон ажиллах | 2020 | 2020 онд 33.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл, арга хэмжээний худалдан авалт 100 хувийн гүйцэтгэлтэй, 924.9 сая төгрөгийн хэмнэлтэй зохион байгуулсан. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний 20-иос доошгүй хувьд орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан, орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна. | 41,300.0 | 2022 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 152,893.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34, өвсний үндэс төслийн хүрээнд хэрэгжих 615.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 15,895.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1,802.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 2,062.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, БОХНСАХЗ-аар санхүүжигдэх 234.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, нийт 173,502.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс давхардсан тоогоор 206 удаагийн тендер сонгон шалгаруулалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй, 2,304.1 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллалаа Гэрээ байгуулах эрх олгосон 90 төсөл, арга хэмжээний 33 төсөл, арга хэмжээ буюу 37 хувьд орон нутгийн компаниуд шалгарч, 35.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна.<br>2022 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 173,502.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 100 хувийн гүйцэтгэлтэй, 2,303.0 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулсан Гэрээ байгуулах эрх олгосон 90 төсөл, арга хэмжээний 37 хувьд орон нутгийн компаниуд шалгарч, 35.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна.<br>2023 онд Улс болон орон нутгийн төсвийн 17.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 44 төсөл арга хэмжээний худалдан авалтыг давхардсан тоогоор 116 удаагийн тендер сонгон шалгаруулалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй 77.7сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулан ажилласан. Гэрээ байгуулах эрх олгосон 36 төсөл, арга хэмжээний 57 хувь буюу 26 төсөл арга хэмжээнд орон нутгийн компаниуд шалгарсан байна.<br>2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улс, орон нутгийн төсөв, өвсний үндэс хөтөлбөр, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, БОХНСАХЗ-ын эх үүсвэрээр тус тус санхүүжих 168.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 93 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг давхардсан тоогоор 233 удаагийн тендер сонгон шалгаруулалтыг 88 хувийн гүйцэтгэлтэй, 3.8 тэрбум төгрөгийн хэмнэлт, үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулах эрх олгосон 143.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл, арга хэмжээний 46 хувь буюу 28 төсөл, арга хэмжээнд давхардсан тоогоор 40 орон нутгийн компаниуд шалгарч 30.6 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан байна.<br>**Үр дүн: Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээнээс 46 хувь буюу 28 төсөл, арга хэмжээнд давхардсан тоогоор 40 орон нутгийн компаниуд шалгарч 30.6 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан байна.** | 100% | 100 % |
| | | ***Зорилт: 4.2 Шинжлэх ухаан, технологийг аймгийн тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ.*** | | | | | | | | | | |
| 60 | 4.2. Шинжлэх ухаан, технологийг аймгийн тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ | 4.2.1 Бүс, орон нутгийн хөгжлийн онцлогт тохирсон шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаанд зарцуулах төсвийн зардлыг үе шаттай нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Бүс нутгийн онцлогт тохирсон, шинжлэх ухаан, технологи, иноваци шингээсэн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 2020 | Аймгийн ИТХ-аас Үйлдвэрлэл технологийн паркийн 3-р бүсийн зарим хэсгийг шинжлэх ухаан технологийн чиглэлээр хөгжүүлэхээр тогтоол гаргасан. | Судалгаанд үндэслэн бүс нутагт тохирсон үйлдвэрүүдийг байгуулах төсөл, ТЭЗҮ-ийг боловсруулан хөрөнгө оруулагч нарт танилцуулна | 15.4 сая ам доллар | "Дэгжих есөн ган" ХХК үйл ажиллагаагаа өргөжүүлж, орон нутгийн түүхий эдэд түшиглэн хөнгөн блокийн үйлдвэр байгуулан импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Дархан төмөрлөгийн үйлдвэр нь менежментийн гэрээгээр ажиллах хугацаанд хүчин чадлын 20 хувийг ашиглаж байсан. Засгийн газрын шийдвэрээр 2022 онд "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болсон. 2021 онд "Монгол Ган цогцолбор I" төслийн ТЭЗҮ боловсруулагдаж дууссан. Хонгор сумын Төмөртолгойн уурхай, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэйн уурхайг түшиглэн Монгол Ган цогцолбор 1 төслийг хэрэгжүүлэхэд үйлдвэрийн барилгын ажлын өргөтгөлд шаардагдах 24 га газрын асуудлыг шийдвэрлэсэн. Дархан арьс ширний цогцолбор" байгуулах шийдвэр гарч 180 га газрыг олгосон. Төслийн хүрээнд жилд 10 сая ш арьс шир, 10.0 мян.т ноос, 1.0 мян.т ноолуур боловсруулах 13 үйлдвэр, 7500 орчим байнгын ажлын байр бий болох ба нийт 197.5 сая ам долларын хөрөнгө оруулалтаар Лидер Капитал ХХК нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, уур үүсгэгч талбай баригдаж байна. Хонгор Орхон суманд "Загвар хоршоо байгуулах" 2.0 тэрбум төгрөгийн төслийн ТЭЗҮ-г Солонгосын Кёнги аймгийн хамтран ажиллах гэрээнд санал оруулан хүргүүллээ. 2024 онд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран бичил үйлдвэр, үйлчилгээ | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | эрхлэгчдийн уулзалтыг зохион байгуулан ХХААХҮЯ-ны сайдын хөрөнгө оруулалтаар батлагдсан "Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тоног төхөөрөмж", "Шинэ хөдөө төсөл"-ийн хүрээнд 221 иргэн, аж ахуйн нэгжийн 11.0 тэрбум төгрөгийн 460 ширхэг тоног төхөөрөмж авах хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 05-ны өдрийн 01-А/150 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу Шинэ хөдөө төслийг 8 багц 111, Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих төслийг хүнс, хөнгөн, ахуйн үйлчилгээний гэсэн 3 багц 30 салбар 160 төрлөөр эрэмбэлж, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст нийт 159 төрлийн 472 ширхэг тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолт, хурлын тэмдэглэлийг боловсруулан тендер шалгаруулалтад оруулахаар шилжүүллээ.<br>Үр дүн: Шинэ хоршоо, Бичил үйлдвэр үйлчилгээг дэмжих төслийн хүрээнд 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 375 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 90% биелэлтэй. | | |
| 61 | | 4.2.2 Төр, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 105.0 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээс 1 төсөл, Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээс 4 төсөлд нийт 150.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. | 2020 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээс 1 төсөл, Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээс 4 төсөлд нийт 150.0 сая төгрөгийн зээл олгосон. | 8 инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана. | 105.0 | Аймгийн Засаг даргын Захирамжаар 2023 оныг "Бизнесийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан бөгөөд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөгжлийн шийдэл ТББ, Дэлхийн зөн ОУБ, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Найрамдал төсөлтэй хамтран танхимын сургалт 38, цахим сургалт 8, зөвлөгөөн 4, форум 1, салбарын уулзалт 5, үзэсгэлэн 5, туршлага судлах аялал 2 тус тус зохион байгуулж, 2800 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа. Хөгжлийн шийдэл ТББ-ын гарааны бизнесийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт найрамдал шимт мөөг, артизан талх, кейк үйлдвэрлэл, хүлэмж, даршилсан ногоо зэрэг шинэ санаачилга, инноваци бүхий 5 аж ахуйн нэгж 50.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг, Найрамдал төслөөс инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 7 аж ахуйн нэгж 140.0 мянган еврогийн дэмжлэг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлээс Шимт агро холдинг ХХК-д тэжээлийн үйлдвэрлэлийн инноваци нэвтрүүлэх төслөөр 290.0 сая төгрөг, хүнсний мөөг үйлдвэрлэлийн Билгүүн сүмбэр ХХК 40.0 сая төгрөг, Оргил нүдэн ХХК 200.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаа өргөтгөлөө.<br>Үр дүн: Хөгжлийн шийдэл ТББ-ын гарааны бизнесийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт шинэ санаачилга, инноваци бүхий 5 аж ахуйн нэгж 50.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг, Найрамдал төслөөс инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 7 аж ахуйн нэгж 140.0 мянган еврогийн дэмжлэг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлээс тэжээлийн үйлдвэрлэлийн инноваци нэвтрүүлэх төслөөр 290.0 сая төгрөг, хүнсний мөөг үйлдвэрлэлээр 240.0 сая төгрөг, ОХУ-ын венеградны үхрийн нүдний шинэ сортын жимсний тариалан эрхлэгчид 200 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. | 100% | 100 % |
| 62 | | 4.2.3 Үйлдвэрлэлийн салбарт шинжлэх ухаан, үйлдвэрлэлийг хослуулсан бүтээгдэхүүн инновацыг нэвтрүүлнэ. | 2021-2025 | 375.,3 | Үйлдвэрлэлийн салбарт шинжлэх ухаан, үйлдвэрлэлийг хослуулсан бүтээгдэхүүн, инновацийг 8 үйлдвэрт нэвтрүүлнэ. | 2020 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлээс 1 төсөл 100.0 сая, Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээс 4 төсөлд 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон | 8 инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана. | 375.3 | "Хөгжлийн шийдэл ТББ-ын гарааны бизнесийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт нитритгүй зайдас, гидропоник хүлэмж, эко саван, найрамдал шимт мөөг, даршилсан ногоо зэрэг шинэ санаачилга, инноваци бүхий 5 аж ахуйн нэгж 50.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг, Европын холбооны 3.0 сая еврогийн буцалтгүй санхүүжилтээр аймгийн инновац, ногоон хөгжил, энтрепренершип, гарааны бизнесийг дэмжих тусгай хөтөлбөрүүдтэй "Найрамдал төсөл"-ийн гарааны бизнесийг дэмжих төсөлд ус, хог хаягдал, эрчим хүчний дэд бүтэц бий болгох, шинжлэх ухааны мэдлэг олгох кафе, найрамдал мөөг, 4 улирлын хүлэмж, зөгийн бүтээгдэхүүн, ухаалаг зоорь зэрэг 7 аж ахуйн нэгж тус бүр 70.0 сая төгрөгийн сургалт, тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж авлаа.<br>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд ОХУ-ын венеградны үхрийн нүдний шинэ сортын жимсний тариалан эрхлэгч Оргил нүдэн ХХК-нд 200.00сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. "Дархан Минж" ХХК эгзэгтэй цэгт инновац нэвтрүүлж үсний филтер ашиглан "Эко технологи" нутагшуулснаар хүхэрт натри 30%, шохой 70%, давс 42%, хром 25%-иар химийн материалын хэмнэлт хийж эхэлсэн бөгөөд хөдөө аж ахуйг дэмжих 2 тэрбум төгрөгийн зээлд хамрагдлаа. Дархан нэхий ХК нь арьс ширний хаягдал болж байсан өөдсийг боловсруулах шинэ технологи нэвтрүүлж, шахмал хавтан үйлдвэрлэж байна.<br>Үр дүн: Хөгжлийн шийдэл ТББ-ын гарааны бизнесийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт 5 аж ахуйн нэгж 50.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг, "Найрамдал төсөл"-ийн гарааны бизнесийг дэмжих төслөөс 7 аж ахуйн нэгж тус бүр 70.0 сая төгрөгийн сургалт, тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 2 аж ахуй нэгж 2,2 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан | 100% | 100 % |
| 63 | 4.3. Газрын харилцааны төлөвлөлт, | 4.3.1 Аймгийн | | 35.0 | Аймгийн газар зохион байгуулалтын | 2020 | АИТХ-аар батлагдсан. | 2018 онд Улсын газар зохион | 35.0 | 2018 онд Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан 2016-2035 он хүртэлх аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх шаардлага үүссэн. Тодотгол хийхэд шаардагдах | 70% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын аюулгүй тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ | газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгоно. | 2021-2025 | | ерөнхий төлөвлөгөөтэй болсон байна. | | | байгуулалтын төлөвлөгөө батлагдсан. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө 2016 онд батлагдсан. | | хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. 2023 онд Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар 2024 оны төсөвт 450,0 сая.төгрөгийг батлуулсан. Гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдсан.<br>**Үр дүн: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна.** | | |
| 64 | | 4.3.2 Хаягжилтын нэгдсэн системийг орон нутагт нэвтрүүлнэ | 2021-2025 | 135.0 | Хаягжилт нэгдсэн системийг нэвтрүүлнэ. | 2020 | Шарын гол суманд гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулсан | Дархан сумын гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулсан байна | 135.0 | 2021 онд Дархан суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүд өөрсдийн эзэмшил, ашиглалтад байгаа үл хөдлөх эд хөрөнгийн хаяг дугаарыг MNS5283:2014 стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах ажлыг 5 иргэн 23 аж ахуйн нэгж хаяг дугаараа "Бридж хангай" ХХК-аар хийлгүүлэн байршуулаад байна. Хаягийн мэдээллийн системд байршуулах ажил 2022 оны өссөн дүнгээр Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын нийт **11973** нэгж талбар, **994** байшин, **850** гудамж, нэгж талбар болон барилгын **12823** орц гарцын мэдээлэл шалгах, засварлах хянасан төлөвт шилжүүлэх, **74** авто гражийг хаягжуулж мэдээллийн нэгдсэн системд байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Хаягийн мэдээллийн системд байршуулах ажил 2021-2024 онд Хаягийн мэдээллийн системд Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын нийт 13270 нэгж талбар, 1044 байшин, 880 гудамж, нэгж талбар болон барилгын 12823 орц гарцын мэдээллийг байршуулсан.<br>Үр дүн: Орхон сумын 79 гудамж, 1351 хашаа, 138 өвөлжөө хаваржаа, 159 барилга хаягийн мэдээллийн системд байршуулсан. | 100% | 90% |
| 65 | | 4.3.3 Газрын ашиглалт, хяналтыг сайжруулж, мониторингийн системийг хэрэгжүүлнэ. | 2021-2025 | | Нэгж талбарын хувийн хэрэг бүрдүүлэлт хийх. | 2020 | Аймгийн хэмжээнд 19651 нэгж талбар байна. | Газар ашиглалт, хяналтыг сайжруулсан байна. | | "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн цахим системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан Газрын тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтын газар дээр захиалгат хянан баталгааны ажлыг Барилга хот байгуулалтын яамнаас зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна. Аймгийн хэмжээнд 2021 онд 126 иргэн, 23 хуулийн этгээдийн захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлт ирүүлснийг шалгаж байнгын шинжээчээр баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2022 онд https://darkhan.gazar.gov.mn цахим системээр дамжуулан 4565 хүсэлт, нэгж талбарын газар ашиглалтыг хянаад байна. 2 жил дараалан ашиглаагүй 28 иргэн, хуулийн этгээдэд сонсох ажиллагааны хуудсыг хүргүүлсэн. Газрын тухай хуулийн дагуу дараагийн шатны арга хэмжээг авахаар аймгийн Засаг даргад уламжилж /8 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох/ захирамж гараад байна.<br>2021-2024 онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар Газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ дүгнэх журмын 14-р зүйл гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх тухай заалт болон тус журмын гуравдугаар хавсралтын дагуу egazar цахим системийн дагуу нийт 65 газар эзэмшигчийн гэрээ дүгнэсэн байна. | 100% | 70% |
| 66 | 4.4. Хот төлөвлөлтийн хүрээнд шинэ суурьшлын бүсийг байгуулах, дэд бүтцийг сайжруулж, байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ | 4.4.1 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хорооллуудын хэсэгчилсэн төлөвлөлтийг хийнэ. | 2021-2025 | - | Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 7, 14, 29,30 дугаар хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна. | 2020 | Дархан сумын 6-р багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн. | Дархан сумын 7, 14, 29, 30 дугаар хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | - | Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Дархан сумын 7, 30 дугаар хорооллын зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулж батлуулан төсөвт өртгийг тооцоолон гаргасан.<br>29-р хороололд 10.0 мянган айлын Залуус 1,2 хорооллын Дархан сумын 13-р баг 29-р хороололд 102 га, 15-р багт 23 га талбайд Залуус 1, 2 хороолол барихаар төлөвлөж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг 228.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Инженер геодизи" ХХК хийж гүйцэтгэсэн.<br>Дахин төлөвлөлтийн хүрээнд 60 айлын 2 орон сууцыг ОНТХО-р барьж ашиглалтад оруулсан.<br>Үр дүн: 60 айл өрх шинэ орон сууцтай болж амьдрах орчин нөхцөл сайжирсан. 10.0 мянган айл өрх бага өртөгтэй орон сууцаар хангагдах нөхцөл бүрдэнэ. | 90% | 90% |
| 67 | | 4.4.2 Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, авто замын сүлжээ, тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. | 2021-2025 | 1,300.0 | Гэр хорооллын чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2020 | Алслагдсан баг, хорооллын 3-н чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна | Ширэз нуруу, Мангирт, Толгойт чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ | 1,300.0 | Ширээ нуруу , Мангирт, Толгойт, Шинэ-Хуучин Дархан гэсэн 4-н чиглэлд нийтийн тээврийн том оврын 8-н автобус үйлчилгээ үзүүлж байна.<br>2022 онд Алслагдсан баг хорооллын хүүхдүүдэд зориулсан автобусны тусгай үйлчилгээнд парк шинэчлэлтийг хийж 56 хүүхдийн суудалтай сурагчдын 4-н шинэ автобусыг 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч 6-н маршрутад үйлчилгээ үзүүлж байсан. 2024 онд Алслагдсан баг хорооллын хүүхдүүдэд зориулсан автобусны тусгай үйлчилгээнд парк 56 хүүхдийн суудалтай сурагчдын 4-н шинэ автобусыг 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч 2 чиглэлд тээврийн хэрэгслийн насжилт дуусч байсныг парк шинэчлэлт хийж нэмэлт 2 чиглэл гаргаж 8-н чиглэлд үйлчилгээ үзүүлж сурагчдын автобусны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлээд байна. Авто замын шинэчлэлтэй холбогдуулан 2022 онд 15 байршилд 2023 онд 9 байршилд 2024 онд 12 байршилд автобусны буудал шинээр байгуулсан. | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Үр дүн: Алслагдсан баг хорооллын сурагчдад 8 чиглэлд стандартын шаардлагад нийцсэн 8 шинэ сурагчдын автобусаар үйлчилгээ үзүүлж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, нийт 36 автобусны буудлыг шинээр ашиглалтад оруулаад байна. | | |
| | | | | 47,900.0 | Алслагдсан баг, суурин газруудыг авто замын сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | 2020 | Дархан-Шарын гол чиглэлийн 47.7 км авто замаас 18 км авто зам ашиглалтад орсон. | Дархан-Шарын гол чиглэлийн 47.7 км авто замыг хатуу хучилттай болно. | 20,000.0 | Дархан-Шарын гол чиглэлийн 48.8 км хатуу хучилттай авто зам болон 24у/м төмөр бетон гүүрийг 2021-2023 онд ашиглалтад бүрэн оруулсан бол Аргалын гармаас Зулзага чиглэлийн 10.3 км авто замын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй, Зулзагын гүүрнээс Овоо хүртэлх 3.6 км авто замын ажил 80% гүйцэтгэлтэй байна. Зулзагын гол дээрх 18у/м төмөр бетон гүүрийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, 2025 оны II улиралд бүрэн ашиглалтад оруулна. Үр дүн: Амралт суурьшлын бүс хатуу хучилттай авто замын сүлжээнд холбогдоно. | 100% | 90% |
| | | | | 7,800.0 | Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13.1 км авто замын хатуу хучилттай болгоно. | 2020 | Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13.1 км авто замын суурийн ажил хийгдсэн. | Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13.1 км авто замын хатуу хучилттай болгоно. | 2,100.0 | Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13,1 км авто замын ажлын эхний үе шатны 12 ш дугуй хоолой, 2 ш дөрвөлжин хоолой, 13,1 км авто замын далангийн ажлыг 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 дахь үе шатны ажил 13.1 км авто замын суурь хийх, авто замыг хатуу хучилттай болгох ажлыг "Түвшин гэгээ" ХХК нь 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 100 хувь дууссан. Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13,1 км авто замыг хатуу хучилттай болгох ажилд 7.6 тэрбум төгрөг зарцуулаад байна. Үр дүн: Хонгор сумаас Салхит чиглэлийн 13.1 км хатуу хучилттай авто зам баригдаж ашиглалтад орсон. | 100% | 100 % |
| 68 | | 4.4.3 Хотын цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийн инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэн сайжруулна. | 2021-2025 | - | Шинэ суурьшлын бүсийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангана. | 2020 | Шинэ суурьшлын бүсийн айл өрхийн судалгаа гаргасан. | Дархан, Орхон сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан эрчим хүчээр хангана. | - | Дархан-Уул аймагт шинэ суурьшлын бүс болох "Залуус хороолол 1, 2" төслийн дэд бүтцийн ажил Улсын төсвийн 47.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Залуус 1,2-р хорооллын цахилгаан хангамжийг шинээр байгуулах ажлын төсөвт өртөг 37.0 тэрбум төгрөг бөгөөд зураг, төсөв боловсруулагдаж Магадлал хийгдэж хянагдсан. Тус ажлын нийт төсөвт өртөг нь 37.5 тэрбум төгрөг бөгөөд 2023 онд 7.5 тэрбум төгрөгөөр эхний үе шатны ажлыг хэрэгжүүлсэн бол 2 үе шатны ажилд шаардагдах 30.0 тэрбум төгрөг 2024-2025 онд шийдвэрлэгдсэн. Ингэснээр "Дархан хот цахилгаан хангамжийн тойрог схемд холбогдоно.<br>-Залуус-1 хорооллын 3 ширхэг ус дулаан дамжуулах төв барих ажлыг улсын төсвийн 3,1 тэрбум төгрөгөөр "Алтайн үндэс констракшн" ХХК барьж байгаа бөгөөд ажлын явц 20%-тай үргэлжилж байгаа бөгөөд 2026 онд байнгын ашиглалтад оруулна.<br>-"Залуус-1" хорооллын гадна ариутгах татуургын шугамын ажил - 2520м /Дархан-уул Дархан сум/-ыг Ашид бьюлдинг ХХК улсын төсвийн 1,0 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд ажлын явц 5%, 2026 онд байнгын ашиглалтад оруулна.<br>-"Залуус-1" хорооллын дулааны төв шугамаас УДДТөвүүд хүртэлх салбар шугамын ажил - 1803 м-ыг улсын төсвийн 3,4 тэрбум төгрөгөөр Цагаан зуун ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 50%-тай, 2026 онд байнгын ашиглалтад оруулна.<br>- Залуус 2 хорооллын цахилгаан хангамжийн ажил-"Мангирт-Ноёнхонгор" 110КВ-ын Агаарын шугам, Ерөөгийн 110 КВ-ын шугам буулгах, Ерөө шугамын У110-1+5 тулгуур угсрах, 6КВ-ын шугам буулгаж зөөх, "Тосгон-Ноёнхогор" 110КВ-ын шугам, 110/35/10КВ-ын 1х16 МВА чадалтай "Мангирт" дэд станц, 220/110/35 КВ-ын "Дархан" дэд станцын өргөтгөл /Дархан-Уул, Дархан сум/-ийн ажлыг улсын төсвийн 15,9 тэрбум төгрөгөөр Энх-Өглөө ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 70%-тай үргэлжилж байна. 2026 онд байнгын ашиглалтад оруулна.<br>-Залуус 1 хорооллын 8 ширхэг цахилгааны дэд станц, гадна цахилгаан хангамжийн шугамын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/-ыг Азсеть ХХК улсын төсвийн 3,4 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 64%-тай, 2026 онд байнгын ашиглалтад оруулна.<br>-Залуус-1 хорооллын гадна холбооны шугамын ажил Дархан-Уул, Дархан сум-ыг Нанар ХХК улсын төсвийн 1.1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд 2024 онд хийгдэх ажил нь бүрэн дууссан. 2025 онд байнгын ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй.<br>Үр дүн: Залуус 1, 2 хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж батлагдсан. Дэд бүтэц татах 77.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 2025 онд бүрэн дуусна. | 70% | 70% |
| 69 | | 4.4.4 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр цахилгаан, | 2021-2025 | 3200.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цахилгаан, дулааны эх | 2020 | Хөтөл хорооллын 960 айлын гадна цахилгаан хангамж | Хөтөл хорооллын 960 айлын гадна цахилгаан хангамжийн | 3,200.0 | Дархан-Уул аймгаас ЭХИШС талаар баримтлах дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулсан. 2021 оны байдлаар дамжуулах сүлжээний 23164 метр урттай дулаан дамжуулах шугамын 49.2% нь 0-10 жил, 27.7% нь 11-20 жил, 11.8% нь 21-35 жил, 11.4% нь 36 ба түүнээс дээш жил болж шугам хоолойн насжилт 16 жил байна. Дархан-Уул аймгийн Цахилгаан хангамжийн шугам сүлжээ нь анх байгуулагдсанаас хойш 50 гаруй жил ажиллаж байгаа бөгөөд шинэ | 100% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | | | үүсвэрийг нэмэгдүүлнэ. | | хийгдээгүй. | зураг төсөл угсралт бүрэн хийгдэнэ. | | техник технологи нэвтрүүлэх ажил 2010 оноос хийгдэж эхэлсэн.<br>Дархан-Уул аймгийн хэмжээнд 35 кВ-ын 6 дэд станц, 6,(10)/0,4 кВ-ын 216 дэд станц, 0,4-35 кВ-ын 593,8км агаарын шугам, 143,4 км кабель шугамтай.<br>2023 онд: Дархан-Уул аймгийн Хонгор сумын гэр хорооллын 3.4км 0.4 кВ-ын агаарын шугамын шинэчлэлийн ажил, Төвийн 6 кВ-ын 25км агаарын шугамыг төмөр бетон тулгуураар шинэчлэх, Дархан сумын гэр хорооллын 20км 0.4 кВ-ын агаарын шугам шинэчлэх, 5-р баг Хөтөл хороолол 6/0,4 кВ-ын 1 дэд станц шинээр барих ажлыг төлөвлөсөн. 2024 онд: Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 кВ-ын РП-1 хуваарилах байгууламжийг иж бүрэн шинэчлэх, Дархан, Орхон сумын гэр хорооллын 35км 0.4 кВ-ын агаарын шугам шинэлэх Зулзагын чиглэлд 6/0,4 кВ-ын 2 дэд станц, ширээ нуруунд 1 шинээр барих ажлыг төлөвлөсөн. 2025 онд: Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 6 кВ-ын РП-1 хуваарилах байгууламжийг иж бүрэн шинэчлэх, Дархан сумын гэр хорооллын 10км 0.4 кВ-ын агаарын шугам шинэлэх ажлыг төлөвлөсөн.<br>**Үр дүн: 2021-2023 онд Малчин, Энхтал, Ноёнхонгор шинэ суурьшлын бүсэд 2 км агаарын шугам шинээр барьж 56 айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангасан.** | | |
| 70 | | 4.4.5 Хот суурины усан хангамж, ариутгах татуургын инженерийн сүлжээг өргөтгөн шинэчлэж, цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг сайжруулна. | 2021-2025 | 8000.0 | Үндсэн тосгон туслах тосгоны бохир усны шугамын өргөтгөлийн ажлыг хийнэ. | 2020 | Бохир усны шугам хоолойн нэвтрүүлэх чадвар хүрэлцдэггүй 1968 онд хийгдсэн. | - | 8,000.0 | 2021 онд Улсын төсвийн 8.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 6, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт гэр хорооллыг дахин төлөвлөж, инженерийн шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэгчээр "Эс энд Эй трэйд" ХХК шалгарч нийт дулааны 4298 м хос шугам, Бохир усны шугам 3880 м шугам, 11 ус дулаан дамжуулах төвийн барилга, 1 насос станцын төвийн барилга угсралтын ажил хийгдсэн.<br>**Үр дүн: УДДТөв болон насос станцын дулаан механикийн тоног төхөөрөмж суулгах ажил дууссан.** | 100% | 100 % |
| | | | | - | Усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ. | 2016-2020 | Дархан хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажил 45 хувийн гүйцэтгэлтэй байна. | Хоногт 24000м3 бохир усыг хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон байна | . | Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл нь үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.<br>1.А1 багцын гүйцэтгэл 100%-тэй,<br>2. А2 багцын гүйцэтгэл 100%-тай,<br>3. А3 багцын гүйцэтгэл 100%-ийн гүйцэтгэлтэй.<br>Төслийн хэмжээнд нийт гүйцэтгэл 100.0%-тай байна.<br>Пфайфер Эмит түншлэлтэй 2022 оны 06 сард гэрээ цуцалж 2022 оны 10 сарын 26 өдөр Байгууламж ХХК-тай төслийн үлдэгдэл ажлыг хийж дуусгах шинэчилсэн гэрээг 12,926,000,246 төгрөгийн үнийн дүнтэйгээр гэрээ байгуулсан.<br>Нийт бетон цутгалтын **100%** хийгдсэн. Хийц бүтээц арматурчлалын **100%** угсраргдсан. Тоног төхөөрөмж угсралтын **100%** хийгдсэн. Технологийн шугам хоолой угсралтын **100%** хийгдсэн. Буцаан булалт дүүргэлтийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй. Цахилгаан, механик тоног төхөөрөмж худалдан аваж суурилуулах ажил **100%** хэрэгжиж байнгын ашиглалтад хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.<br>**Үр дүн: Дархан төв цэвэрлэх байгууламж бүрэн шинэчлэгдсэн.** | 100% | 100 % |
| 71 | | 4.4.6 Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2021-2025 | - | Төв суурин газрын үерийн ус зайлуулах далан сувгийг засварлах ажлыг үе шаттай гүйцэтгэнэ. | 2021 | Дархан сумын 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 16 дугаар багийн үерийн бетон доторлогоотой далан, байгууламж засварлагаа агүй. | Дархан сумын 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 16 дугаар багийн үерийн бетон доторлогоотой далан, байгууламжийн ажил хийгдсэн. | - | Дархан сумын 9,12 дугаар багийн нутаг дэвсгэр 25, 31 дүгээр хорооллын үерийн хамгаалалтын төв сувгаас хойш 216м урттай, угсармал бетон хавтан доторлогоотой сувгийг ОНТХ-ийн 210.0 сая.төг-өөр гүйцэтгэж эхлээд байна. Дархан сумын 15-р багийн нутаг дэвсгэрт үерийн усны байгууламжийн 3 багц ажил гүйцэтгэж дууссан. Үүнд:<br>• "Багц 1" үерийн усны хамгаалалтын 1608 у/м сувгийн ажлыг 100% гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан.<br>• "Багц 2 үерийн хамгаалалтын төв суваг хүртэл 1817 у/м төмөр бетон хавтан доторлогоотой үерийн ус дамжуулах суваг ажлыг 100% гүйцэтгэж барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан.<br>• "Багц-3" үерийн усны хамгаалалтын ил суваг-360м, далд суваг, гүүр-224м нийт 584м сувгийн ажил 100% гүйцэтгэж барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. • Хонгор сумын 1-р хэсэг / 519.37м/, 3-р хэсэг /395.45м/ нийт 914.82м үерийн суваг, далангийн засварын ажлыг гүйцэтгэж барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.<br>Үерийн усны хамгаалалтын далан суваг Дархан суманд 4009м, Хонгор суманд 914,82м шинээр нэмэгдэж үерийн усны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, найдвартай ажиллагаа хангагдсан.<br>2024 онд Дархан сумын 2,3-р баг, 31-р хорооллын үерийн хамгаалалтын суваг шинэчлэх ажилд 3.2 тэрбум төгрөг батлагдсан. Ажлын зураг төсөв боловсруулагдсан.<br>2024-2025 онд үерийн ус зайлуулах сувгийн засварын ажил /Дархан-уул, | 90% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Дархан сум, 31-р хороолол/-ыг Хангилцаг ХХК улсын төсвийн 1,7 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 40%-тай, 2025 онд байнгын ашиглалтад оруулна.<br>Дархан сумын 1,2,3-р багийн үерийн хамгаалалтын суваг шинэчлэх ажлын төвийн төслийг Салбарын яам, Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Үр дүн: 31-р хорооллын үерийн хамгаалалтын суваг шинэчлэх ажил хийгдэж байна. | | |
| 72 | | 4.4.7 Байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ | 2020 | Дархан сумын 9,10,12 дугаар багийн нутаг дэсвгэр 31 дүгээр хорооллын ИШС-ний ажил хийгдсэн. | 31 дүгээр хороололд амины орон сууцны ногоон барилга байгууламж баригдсан байна. | - | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 31 дүгээр хороололд 23 га талбайд 425 айлын орчин үеийн шийдэл бүхий амины орон сууцны хорооллыг төлөвлөсөн. Тус хорооллын төвлөрсөн цахилгаан, цэвэр ус, бохир ус, хорооллыг тойрсон төмөр хашаа барих ажлыг иргэдийн оролцоотойгоор өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. 2022 оны байдлаар 20 айл амины орон сууц баригдсан байна.<br>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 31-р хорооллын дулаан хангамж татах ажлыг эхлүүлж 2025 онд бүрэн дуусгана.<br>Дархан сумын 13, 15-р багт Залуус 1, 2 төслийн хүрээнд 127 га талбайд орон сууцны хороолол барихаар төлөвлөсөн. Орон нутгийн төсвийн 230,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулагдаж Барилгын хөгжлийн төвөөр хянагдаж баталгаажсан. Улсын төсвийн 47.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар төвлөрсөн дулаан хангамж татах ажил хийгдэж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 30.0 тэрбум төгрөг батлагдсан. Инженерийн шугам сүлжээ, цахилгаан хангамжийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр Ашид бьюлдинг ХХК, Алтайн үндэс констракшн ХХК, Цагаан зуун ХХК, Нанар ХХК, Энх өглөө ХХК, Азсеть ХХК, Хангилцаг ХХК зэрэг компаниуд тендерт шалгаран 2024 онд гэрээ байгуулж ажлаа гүйцэтгэж байгаа бөгөөд 2026 онд бүрэн дуусгаж байнгын ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>Үр дүн: 31-р хорооллын төвлөрсөн дулаан хангамж татах ажлыг Улсын төсвийн 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна. Тус төсөл 2026 онд бүрэн дууcна. | 70% | 50% |
| 73 | | 4.5.1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 6.9 | 125 нэр төрлийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлнэ. | 2020 | "Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулсан үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулж 173 хүнийг хамруулсан. | Тур оператор компаниудтай хамтран ажиллаж гадаад болон дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | 6.9 | 2022 онд Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдэд "Олон улсад мөрдөж байгаа үйлчилгээний стандарт"-г хэрэгжүүлэхийг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Дархан хоттой танилцах "Сити тур" аяллыг зохион байгуулж, нийт 90 гаруй Дархан хотын их дээд сургуулиудад шинээр элсэн суралцаж буй оюутан сурагчид болон шилжин ирсэн иргэдийг хамруулан, Дархан хотын музей, түүхэн дурсгалт газруудаар аялуулсан.<br>Дархан-Уул аймгийн Аялал жуулчлалын нэгдсэн холбоо НҮТББ, Бизнес боломж хөгжлийн гүүр төв НҮТББ, Дархан Музей, "Элит хөгжил" ХХКомпани, Дуут үзэг НҮТББ-д хамтран "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэн, "Зочлох үйлчилгээний стандарттай танилцах аялалд SB зочид буудал, Horizon Darkhan Mountaineering club, Мөнгөн харандаа уран зураач, Гэрэл зургийн студи, "Дархан фитнес клуб", Улсын бүртгэлийн газар зэрэг аж ахуй нэгж байгууллагууд оролцож өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан, иргэдэд танилцуулсан.<br>2023 онд Европын Холбооны санхүүжилттэй НАЙРАМДАЛ төслийн хүрээнд НАЙРАМДАЛ төсөл, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар хамтран "Тогтвортой аялал жуулчлал" чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын холбоо, Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, амралт сувилал, бусад холбоодын төлөөлөл, тур оператор, шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд нийт 70 ААНБ, иргэдийг хамруулсан.<br>Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутагт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Тусгай сонирхлын спорт, аялал жуулчлал тэмцээнийг "Дарханы Загасчлалын Холбоо" ТББ-тай хамтран "Дархан цом-2023" мөсний спортын загасчлалын дадлага, сургалтыг "Түшиг Уул" ХХК-ийн хиймэл нуурт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дотоодын 24 багийн 72 тамирчин оролцсон.<br>2023 онд дотоодын 150286, гадаадын 3705 нийт 153991 жуулчин хүлээн авч байсан бол 2024 оны 3 дугаар улирлын байдлаар аялал жуулчлалын байршуулах хэрэгсэл болон үзвэр үйлчилгээний байгууллага, аяллын компани, эвент арга хэмжээ болон ажил хэргийн уулзалтаар гадаадын 4663, дотоодын 160330 нийт 164993 жуулчин хүлээн аваад байна.<br>Үр дүн: 2024 онд гадаадын 4663, дотоодын 160330 нийт 164993 жуулчин хүлээн аваад байна | 100% | 90% |
| 74 | | 4.5.2 Жуулчдын | 2021-2025 | - | нисэх онгоцны буудал барьж | 2020 | Судалгааны ажил | Газрын асуудлыг | - | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.5. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | урсгал, хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх зорилгоор нисэх онгоцны буудал байгуулж, агаарын шугам нээх ажлыг бодлогоор дэмжинэ. | | | байгуулах ажлын гүйцэтгэл,% | | хийгдсэн. | шийдвэрлэж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нисэх онгоцны буудлыг барьж эхлэх | | 2022 онд тус аймгийн нутаг аялал жуулчлалын урсгал, хөдөлгөөний нэмэгдүүлэх зорилгоор Дархан сумын Малчин багт нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас байгуулахаар төлөвлөж, орон нутгийн төсвөөс 179.5 сая төгрөг батлагдсанч 2023 онд төсвийн тодотголоор хасагдсан. | 30% | 30% |
| 75 | | 4.5.3 Цэнгэг уст нуур, байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн бүс нутгийн аялал, жуулчлалыг хөгжүүлнэ. | 2021-2025 | 8.0 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө-2030" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана | 2020 | Дархан хайрханы тахилга, Өвлийн мөсний загасчлал, Авто ралли, Унадаг дугуй, Явган, Морин аяллууд зохион байгуулагдсан. | Жил бүр спорт аялал жуулчлалыг зохион байгуулна. | 8.0 | 2022 онд Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын нэгдсэн холбоо НҮТББ нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд нэгдсэн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, холбоо, клубуудын хамтын ажиллагааг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулан орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна.<br>Дархан хотын брэнд наадам болгох зорилгоор 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Төвийн бүсийн аялал болох "Дархан-88" уулын дугуйн II наадмыг "Залуучууд театраас Мангирт, Чоно харайхын даваа, Аргалын гарам хүртэлх 90км замтуулах уралдааныг зохион байгуулсан.<br>Тус наадамд нийслэл Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, ОХУ-ын Буриад улсын баг тамирчид, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Эрдэнэт, Өмнөговь аймгуудын нийт 24 багийн 186 гаруй тамирчид оролцлоо.<br>2023 онд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутагт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор тусгай сонирхлын спорт, аялал жуулчлал тэмцээнийг "Дарханы Загасчлалын Холбоо" ТББ-тай хамтран "Дархан цом-2023" мөсний спортын загасчлалын дадлага, сургалтыг 2023 оны 3 сарын 4-5-ны өдрүүдэд "Түшиг Уул" ХХК-ийн хиймэл нуурт зохион байгуулахад 24 багийн 72 тамирчин оролцсон.<br>2024 онд өвлийн аялал жуулчлалыг төрөл хэлбэрүүдийг дэмжин хөгжүүлэх ажлын хүрээнд "Дархан цом" мөсний загасчлалын олон улсын аварга шалгаруулах тэмцээн 11 дэх жилдээ, Хойд бүсийн мөсөн сурын чуулга харваа тэмцээн,Дархан айс дрифтийн уралдааныг нэгтгэн Бурхантын өвлийн наадмыг зохион байгуулж нийт 400 гаруй хүн оролцлоо. Тус наадмыг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/05 дугаар тушаалаар 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Чингис мастер кросс авто ралли уралдаан 24 дэх жилдээ, Дархан тайж хасарын нэрэмжит Төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Дархан-88 уулын замын унадаг дугуйн наадмыг 4 дэх жилдээ, Дрифт сериус уралдааныг 3 дах жилдээ,Дархан хайрханы тахилга, Дархан-50 явган алхалтын фестиваль, Адуучин тэмцээн 2 дах жилдээ тасралтгүй зохион байгуулж нийт 1129 оролцогч оролцсон байна. Мөн аялал жуулчлалын 2 тур оператор компаниудтай хамтран автобустай аяллыг тусгай хөтөлбөр, маршрутын дагуу зохион байгуулж нийт 500 гаруй хүүхэд хамрагдлаа. Мөн Хонгор сумын Хар бэлчир, зулзагын голын 2 малчин айл өрхтэй хамтран Дархан морин аяллын клуб 4 шөнө 5 өдрийн аяллыг зохион байгуулж дотоодын 120, гадаадын 86 жуулчин хүлээн авсан байна. Байт харваа морь уналга сургалтын газар дотоодын болон гадаадын жуулчдад байт харваан үзүүлбэр үзүүлэн монгол ахуй амьдралтай танилцуулан, морин аяллыг зохион байгуулж гадаадын 86, дотоодын 120 жуулчин хүлээн аваад байна.<br>Үр дүн: 2024 онд морин аяллыг зохион байгуулж гадаадын 86, дотоодын 120 жуулчин хүлээн авлаа | 100% | 90% |
| 76 | 4.6. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан, санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ. | 4.6.1 Орон нутгийн төсвийн тогтвортой, бие даасан байдлыг бэхжүүлж, санхүүгийн байгууллагуудын чадавхийг | 2021-2025 | 0.3 | Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан хүлээн авалт, баталгаажуулалтын түвшинг нэмэгдүүлнэ. | 2020 | Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан хүлээн авалт, 90.7 % байна. | Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан хүлээн авалтыг **98.0%-д** | **0.3** | 2021 онд Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тушаах 3447 байгууллагаас 3280 байгууллагын тайланг хүлээн авч хянаж, баталгаажууллаа. Тайлан тушаасан байгууллагын тоо өмнөх оноос 69–өөр нэмэгдэж хүлээн авалтын түвшин 95,2 хувьд хүрсэн байна.<br>2022 онд ААНБ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тушаах 3582 байгууллагаас 3403 байгууллагын тайланг хүлээн авч хянаж, баталгаажууллаа. Алдаатай тайлан ирүүлсэн байгууллагуудын алдааг засуулан хүлээн авлаа. Тайлан хүлээн авалтын төвшин 95.0 хувьд хүргэсэн.<br>Үр дүн: 2022 оноор дуусгавар болж хэрэгжилт бүрэн хангагдсан. | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх замаар санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ. | | | | | | хүргэнэ. | | | | |
| | | | | 5.0 | И-баримт, QR коджуулалтын тусламжтайгаар татварт хамрагдуулалт, татварын өрийн барагдуулалтыг нэмэгдүүлж, санхүүгийн бааз суурийг тэлнэ. | 2020 | 40% | 50-с доошгүй % | 4.5 | Татварын удирдлагын нэгдсэн системд НӨАТУС-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зах худалдааны төвийн хувиараа бизнес эрхлэгч 2420 иргэн, 1171 малчин бүхий иргэн, төмс, хүнсний ногоо, үр тариа тариалагч 204 иргэн, нийт 3795 татвар төлөгчийг QR кодоор цахим төлбөрийн баримтын системд холбож, үйл ажиллагаанд нь зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаж байна.<br>2021 онд шинээр ХХОАТ төлөгч 645 иргэн, 67 хуулийн этгээд бүртгэгдэж, ХХОАТатвар 94.5%, иргэний ҮХЭХАТатвар 106%,<br>2022 онд ХХОАТ төлөгч 209 иргэн, 179 хуулийн этгээд бүртгэгдэж татварын ХХОАТатвар 104.5%, иргэний ҮХЭХАТатвар 116% орлого орж татварын бааз суурь нэмэгдсэн байна.<br>2023 онд шинээр ХХОАТ төлөгч 207 иргэн, 278 хуулийн этгээд бүртгэгдсэн байна.<br>Үр дүн: 2023 оноор дуусгавар болж хэрэгжилт бүрэн хангагдсан. | 100. % | 100 % |
| 77 | | 4.6.2 Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас тогтоодог татвар, төлбөр, хураамжийг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн тогтоож, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар цахим технологид суурилсан сургалт, үйлчилгээтэй эдийн засгийн таатай орчныг бүрдүүлнэ. | 2021-2025 | 0.5 | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох замаар татварын бааз суурийг нэмэгдүүлнэ. | 2011 | АИТХ-ын 2011 оны 21 дүгээр тогтоол/ АТБӨЯХАТ-ын хувь хэмжээ/ тогтоосон. | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтооно | 0.5 | УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан "МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн хамт Төсвийн тухай хуульд өөрчлөлтүүд орсон. Үүнтэй холбоотойгоор авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох төслийг аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 23-ний хуралдаанаар баталсан 34 дүгээр тогтоолын хавсралтад 2023 оны хоёр дугаар сарын хуралдаанаар нэмэлт өөрчлөлтийг хийж оруулан 2023/02/10-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 2021 онд 108,8% , 2022 онд 124,9%-ийн гүйцэтгэлтэй .<br>Үр дүн: 2023 оноор дуусгавар болж хэрэгжилт бүрэн хангагдсан. | 100.0 % | 100 % |
| | **ТАВ. ЗАСАГЛАЛ** | | | | | | | | | | | |
| 78 | 5.1. Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээг нэмэгдүүлж, шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 5.1.1 Төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлэн үйлчилгээний шат дамжлагыг үе шаттайгаар бууруулж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ. | 2021-2025 | 2.5 | Үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | 2020 | 15 байгууллага 143 төрлийн төрийн үйлчилгээ үзүүлсэн. | 163 үйлчилгээг үзүүлнэ. 22020 | 2.5 | 2021 онд И-Монголиа системээр иргэдэд Дархан-Уул аймгийн ЗДТГ, БОАЖГ, ЦГ, ОБГ, ДОНЗТ, ЭМГ, ХХААГ, Дархан сум, АТҮТ, "Дархан-Ус суваг" ХК, "Дархан дулааны сүлжээ" ТӨХК зэрэг 11 байгууллагын 89 төрлийн 210 лавлагааг гаргасан байна.<br>2022 онд СХЗХ Тохирлын үнэлгээ хийлгэх /Иргэн, ААНБ/, ОБГ-Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтын хүсэлт /ААНБ/ 2 байгууллагын 3 үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Мөн НҮНТөв болон Орхон, Хонгор, Шарын гол сумдуудад тус бүр угтах үйлчилгээний ажилтан ажиллаж байгаагаас гадна 38 төрлийн 2038 лавлагаа г гаргасан байна.<br>2023 онд 64 төрлийн 8205 лавлагааг и-монголиа системээр гаргасан байна.<br>2023 онд тус аймагт ТЦҮХ байгуулагдаж үйл ажиллагааны хүрээнд ХУРДАН төвийг байгуулан иргэд олон нийтэд төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулж 39 байгууллагын 440 цахим үйлчилгээ үзүүлсэн. Нийт давхацсан тоогоор 191 төрлийн 10453 лавлагааг и- монголиа системээр гаргасан байна.<br>2024 онд Дархан-Уул аймагт "ХУР" системд суурилсан 6 киоск машин нэвтрүүлж байгаагаас, Дархан өртөө-1 дээр 24/7 төвийг шинээр нээн ажиллуулж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний киоскыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн байранд суурилуулж, мөн Дархан нэгдсэн эмнэлгийн байранд 1 киоск, Дархан Төмөрлөгийн үйлдвэр буюу үйлдвэрийн раойнд, Орхон, Шарын гол сумдад тус тус 1 киоскыг байршуулан хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Нийт 13 цэгт үйлчилгээ үзүүлж байна. И-монгол, и бизнес платформ, төлбөрийн системийг хэлтсийн хэмжээнд нийт 910 иргэнд танилцуулж, зөвлөгөө мэдээллээр ханган Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем ашиглан хүн хуулийн этгээдэд 17862 үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. 2024 оны 05 дүгээр сарын 3-ны өдөр Цахим хэвшье Digital first D-1 аарга хэмжээг 7 талт үйл ажиллагааны хүрээнд амжилттай зохион байгуулан ажилласан бол 09 дүгээр сарын 10-ны Дижитал Дархан цахим аймаг нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, төрийн байгууллага, хувийн хэвшилд нэвтрүүлсэн цахим үйлчилгээний үзэсгэлэнг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа<br>НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон Дархан-уул аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Цахим сургалтын төв, Хөдөлгөөнт цэгийн тохижуулалтын хөрөнгө оруулалтын санамж бичигт гарын үсэг зурах үйл | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ажиллагааг зохион байгууллаа. Мөн түүнчлэн Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн Хурдан клубийн нээлтийг хийж тус нээлтэд клубт элссэн Ерөнхий боловсролын нийт 16 сургуулийн төлөөллүүд болох 150 гаруй суралцагчдыг хамруулан ажилласан байна. Дархан-Уул аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээлэл технологийн ажилчид болон хойд, төвийн бүсийн цахимжилтыг хариуцсан хэлтсийн дарга нарыг оролцуулан ЦАХИМ аймгаас-УХААЛАГ аймаг руу хэрхэн шилжих вэ? хэлэлцүүлгийг зохион байгууллаа.<br>Үр дүн: Иргэдэд үйлчлэх 6 киоск машин байршуулж, 13 хурдан цэгийг байгуулж иргэдэд цахимаар үйлчилгээ үзүүлж байна. 17862 иргэнд төрийн цахим үйлчилгээний системээр үйлчилгээ үзүүлж, 2024 оны 05 дугаар сарын 3-ны өдөр Цахим хэвшье Digital first D-1 аарга хэмжээг 7 талт үйл ажиллагааны хүрээнд амжилттай зохион байгуулан ажилласан бол 09 дүгээр сарын 10-ны Дижитал Дархан цахим аймаг нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, өсвөрийн хурдан клубийг байгуулж 150 сурагчид хамруулллаа. | | |
| 79 | | 5.1.2 Гамшигт үзэгдлээс сэргийлэх, иргэдэд мэдээлэх цахим системийг нэвтрүүлнэ. | 2021-2025 | - | Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | 2020 | - | Цахим систем нэвтрүүлнэ. | - | Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг орон нутагт өргөтгөж, нэгдсэн удирдлагатай болсноор тохиолдож болох гамшгийг хохирол багатай даван туулах зорилгоор Дархан-Уул аймгийн хэмжээнд "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх төсөл"-ийг боловсруулан, Дархан сумын 2021 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төслийн хүрээнд шинээр 3.5 квт-ийн хүчин чадалтай 7 ширхэг дуут дохио ашиглалтад оруулж, удирдлагын төв, нийт 18 ширхэг дуут дохиог Радио болон GSM хосолсон нэгдсэн удирдлагын дэд системд холбох ажлын бүрэн хийж гүйцэтгэсэн. "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх төсөл"-ийн ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 4-ний өдрөөс 09-ны өдрүүдэд Дархан сумын нийт 8 байршилд Радио болон GSM дохио хүлээн авах хосолсон нэгдсэн удирдлагын системийн угсралт, суурилуулалт хийж гүйцэтгэн, хэвийн ажиллагааг шалгаж баталгаажуулсан.<br>2024 онд Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг орон нутагт өргөтгөж, нэгдсэн удирдлагатай болсноор тохиолдож болох гамшгийг хохирол багатай даван туулах зорилгоор Дархан-Уул аймгийн хэмжээнд "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх төсөл"-ийг боловсруулан, Дархан сумын 2022 оны 93.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3.5 квт-ийн хүчин чадалтай 7 ширхэг дуут дохиог шинээр ашиглалтад оруулж, удирдлагын төв, нийт 18 ширхэг дуут дохиог радио болон GSM хосолсон нэгдсэн удирдлагын дэд системд холбох ажлын бүрэн хийж гүйцэтгэсэн.<br>Үр дүн: 7 ширхэг дуут дохион шинээр суурилуулснаар нийт 18 ширхэг дуут тохиог радио болон GSM хосолсон нэгдсэн удирдлагын дэд системд холбосон. | 100% | 90% |
| 80 | | 5.1.3 Байгууллага хооронд мэдээлэл солилцох цахим технологийг хөгжүүлнэ. | 2021 - 2025 | 28.0 | Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны системийн ашиглалтын чанарыг сайжруулна. | 2020 | Able програмд 26 агентлаг, 4 сумын ЗДТГ, 26 баг, цэцэрлэгийг 100 хувь хамруулсан. | 29 байгууллагын програмын ашиглалтыг сайжруулна. | 28.0 | Аймгийн төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем ABLE программ, албаны мэйл хаяг дахь мэдээлэлүүд Үндэсний Дата төвд байршиж байна. ABLE системд нийт 129 байгууллагын 3593 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж, албан бичгийг бичиг хэргийн ажилтан нар хариуцан ажиллаж байна. Дархан-Уул аймгийн бүх төрийн байгууллагуудын ашигладаг ABLE системийг 2023 оноос төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны docx-дээ холбон, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн хэвшсэн. | 100% | 100 % |
| 81 | 5.2. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, шударга, хүртээмжтэй, ил тод хүргэнэ. | 5.2.1 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ. | 2021-2025 | 400.0 | Төрийн зарим чиг үүрэг /хөндлөнгийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх, сургалт явуулах, санал асуулга явуулах гэх мэт/-ийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний санхүүжилт, төг. | 2020 | 300.0 сая | 400.0 сая-с доошгүй | 462.9 | 2021 онд Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөрт 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 73.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол, 2022 онд 31 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 520.4 сая төгрөгийн санхүүжилтийг санхүүжилт олгосон бол 2023 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 1,044.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дэд бүтэц, нийгмийн чиглэлийн 71 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 1,315.7 сая төгрөгөөр зарцуулж байна.<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 115 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 1,909.6 сая төгрөг зарцуулж байна.<br>МУ-ын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаң орон нутагт төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх хүрээнд нийгмийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 6 байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Үүнд:<br>1. МУ-ын Засгийн газрын 2016 оны 234 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаң "Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны аймгийн зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, Хамтран ажиллах гэрээг байгуулан жил бүр аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүүхэд хамгааллын | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | чиглэлээр эцэг эхчүүдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэх, халдварт болон халдварт бус өвчлөл, тариаланчид, малчдад дэмжлэг үзүүлэх зэрэг олон талын арга хэмжээг хамтран зохион байгуулж байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардалд Улаан загалмай ТББ-тай хамтран ажиллах 25 сая төгрөгийг 2024 оны төсөв тусган ажиллаж байна.<br>2. МУ-ын Засгийн газрын 2020 оны 60 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаан аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо НҮТББ-тай хамтран ЗДҮАХ-ийн хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээий 2024 оны төсөв 10 сая төгрөгийг тусган 2024 оны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.<br>3. Аймгийн ахмадын хороотой хамтран ажиллах гэрээг (2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 2024/01)-ний байгуулан ажиллаж байна.<br>4.Аймгийн 15 шүдний хувийн эмнэлэгтэй эрсдэлтэй өрхийн 98 хүүхдийн шүдийг эрүүлжүүлж төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг байгуулав. Аймгийн 16 шүдний хувийн үүдэн эмнэлэгт нийт үзлэгт 18359 хүн, урьдчилан сэргийлэх үзлэгт 971 хүн, амбулаторын үзлэгт 24671 хүн тус тус хамрагдсан байна<br>5. "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ нь сумын хог хаягдлын үйлчилгээ, нийтийн эзэмшлийн гудамж талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг зэрэг ажлуудыг хариуцан ажиллаж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тогтоосон "Хог хаягдлын үйлчилгээний хураамж, нэгжийн үнэ тариф батлах тухай" тогтоолын дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдаар 6,815,550 төгрөгийг төвлөрүүлэн 52,3 хувийн биелэлттэй байна.<br>6. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 5 аж ахуй нэгжийг дэмжин ажиллалаа. Тус төслийг сонгон шалгаруулах ажлыг хэсэгт малчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо, Бизнес боломж хөгжлийн гүүр төв НҮТББ, Гэрэлт амжилтын түлхүүр НҮТББ-ын захирал, Үйлдвэрчний эвлэлийн холоо зэрэг хувийн хэвшил төрийн бус байгууллагуудын оролцоог хангаан ажиллалаа.<br>Үр дүн: 10 хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллаж төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн ажиллаж байна. | | |
| 82 | | 5.2.2 Гадаад орнуудын муж, хотуудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлж, салбар хоорондын харилцааг хөгжүүлнэ. | 2021-2025 | - | Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг гадаадын төсөл хөтөлбөрт хамруулах, байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. | 2020 | Орон нутгийн 39 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлсэн | Орон нутгийн 60 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | - | Гадаад болон олон улсын байгууллагатай шинээр холбоо тогтоох ажлын хүрээнд нийт 8 шинэ хот болон байгууллагатай харилцаа эхлүүлж, үр дүнд "Канад сан"-гийн дэмжлэгтэйгээр "Өсвөр үеийн хөгжлийн төв"-тэй болж, БНСУ-д эмч мэргэжилтнүүдийг сургаж чадавхжуулах боломжтой боллоо.<br>Харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд нийт 14 олон улсын байгууллага, хотуудтай харилцсны үр дүнд нүүрстөрөгчийн зах зээлээс хөрөнгө босгон Зулзагын голын 1000 га талбайд шилмүүст мод тарих, Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр орон нутагт анх удаа 3-р шатлалын нэгдсэн эмнэлгийг тус тус байгуулахаар болж, НҮБ-ын Хүүхдийн Сангаас монгол гэрт амьдардаг 20 айл өрхүүдэд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй гэрийн халаалт, дулаалгын ЧИП багц хандивлав.<br>Шууд болон ах дүү хотуудын уламжлалт, найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлын хүрээнд 5 хоттой хамтын ажиллагаа өрнүүлсэн бөгөөд ОХУ-ын Братск хотын эдийн засгийн форумд оролцож, хамтын ажиллагааны санамж бичгээ шинэчлэн байгууллаа. Мөн Япон улсын Засгийн газрын "Өвсний үндэс-хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын 18-р сургуулийн засвар ажил хийх, Америкийн соёлын төвд и-спортын төв байгуулахаар болсон.<br>Нийт 27 Гадаад арга хэмжээ зохион байгуулж, зарим арга хэмжээнд ГХЯ-аас чиглэл үүрэг авч, тайлагнан ажиллаа.<br>Үр дүн: 2024 онд нийт 6 улсын элчин сайд, 9 олон улсын байгууллага, 8 шууд болон шууд бус харилцаатай хотуудын төлөөллийг хүлээн авч, 4 санамж бичиг байгуулсан мэдээллийг тухай бүр ГХЯ-ны БТГ-т мэдэгдэж зөвлөмж чиглэл авч ажиллалаа | 100% | 90% |
| 83 | | 5.2.3 Төрийн үйлчилгээний чанарын стандарт хэрэгжүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ. | 2021-2025 | - | Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн цахим үйлчилгээ,тоо | 2020 | 89 | 92 | - | Монгол Улсын Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /11-11 төв/-д хандсан нийт 208 өргөдөл байгаагаас шийдвэрлэсэн 194, хугацаа болоогүй 14 өргөдөл байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93 хувьтай.<br>Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэн Н.Батдэлгэрийн гаргасан гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлээгүй нь тогтоогдсон талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах хянан шалгагчаас ирүүлсэн албан шаардлагын дагуу Хонгор сумын Засаг дарга Түмэндэлгэрийн Атархишигт Аймгийн Засаг даргын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн 01-Б/21 дугаар захирамжаар "Сануулах" сахилгын шийтгэл ногдуулж ажилласан.<br>Аймгийн Засаг даргын 2024.10.08-ны өдрийн 1-10/584 дугаар албан бичгээр Засгийн Газрын Хяналт Хэрэгжүүлэх газарт тайланг хүргүүлсэн.<br>Төрийн байгууллагын хүнд суртал, Албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | холбоотой Засгийн газрын 11 11 төв ирүүлж байгаа иргэдийн санал гомдлыг багасгах, орон нутгийн төрийн байгууллагын ёс зүйн дэд хорооны ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулах, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэхдээ харилцаа, хандлагыг чухалчлах тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 3-10/769 дугаартай албан тоотыг төрийн 27 байгууллага, орон нутгийн өмчийн 10 байгууллага, боловсролын 46 байгууллага, эрүүл мэндийн 8 байгууллагад тус тус хүргүүлж чиглэл болголоо.<br>Дархан-Уул аймагт "ХУР" системд суурилсан 6 киоск машин нэвтрүүлж байгаагаас, Дархан өртөө-1 дээр 24/7 төвийг шинээр нээн ажиллуулж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний киоскыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн байранд суурилуулж, мөн Дархан нэгдсэн эмнэлгийн байранд 1 киоск, Дархан Төмөрлөгийн үйлдвэр буюу үйлдвэрийн раойнд, Орхон, Шарын гол сумдад тус тус 1 киоскыг байршуулан хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. Нийт 13 цэгт үйлчилгээ үзүүлж байна. И-монгол, и бизнес платформ, төлбөрийн системийг хэлтсийн хэмжээнд нийт 910 иргэнд танилцуулж, зөвлөгөө мэдээллээр хангаж Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем ашиглан хүн хуулийн этгээдэд 17862 үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. 2024 оны 05 дүгээр сарын 3-ны өдөр Цахим хэвшье Digital first D-1 аарга хэмжээг 7 талт үйл ажиллагааны хүрээнд амжилттай зохион байгуулан ажилласан бол 09 дүгээр сарын 10-ны Дижитал Дархан цахим аймаг нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, төрийн байгууллага, хувийн хэвшилд нэвтрүүлсэн цахим үйлчилгээний үзэсгэлэнг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.<br>Цахим аймаг бодлогын зөвлөмжийн хүрээнд Дархан –Уул аймаг нь 10 системийг нэвтрүүлсэн. Үүнд:<br>1. Өгөгдөл солилцооны нэгдсэн систем<br>Нийт 15 цэс, 944 үйлдэл, 24 API интеграцитай.<br>Системүүдийн мэдээллийн урсгалыг сайжруулж, үйл ажиллагааг уялдуулсан.<br>2. Байгууллагын удирдлагын систем<br>12 цэс бүхий, хүний нөөцийн менежмент, цаг бүртгэл, цахим хурал, гэрээний удирдлагыг багтаасан.<br>Хэрэглэгчдэд портал болон аппликейшнтэй интеграц хийгдсэн.<br>3. Иргэдэд зориулсан портал, аппликейшн<br>19 цэс, 1575 үйлдэлтэй.<br>Иргэдэд зар, мэдээ, эрүүл мэнд, боловсролын мэдээлэл, төлбөр тооцоо, статистик мэдээллийг хүртээмжтэй болгосон.<br>4. Инженерингийн систем<br>20 систем нэгтгэж, нийт 789 үйлдлийг багтаасан.<br>Орон зайн мэдээллийн сантай хослуулан хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлсэн.<br>5. Төлбөр тооцооны нэгдсэн систем<br>QPay ашиглан иргэдийн ус, дулаан, цахилгааны төлбөрийг хялбаршуулсан.<br>Нийт 3 системтэй интеграц хийгдсэн.<br>6. Шуурхай удирдлагын нэгдсэн систем<br>602 үйлдэлтэй бөгөөд онцгой байдал, цагдаа, түргэн тусламжийн GPS мэдээллийг 5-10 сек тутамд шинэчилж, шуурхай удирдлагыг дэмждэг.<br>7. Тээврийн хэрэгслийн нэвтрэлтийн систем<br>Дархан-Сэлэнгийн чиглэлд дугаар таних камер суурилуулж, мэдээллийг бодит цагийн горимоор бүртгэдэг.<br>Одоогоор 23,000+ нэвтрэлтийн мэдээллийг боловсруулсан.<br>8. Хог хаягдлын удирдлагын систем<br>114 хогны саванд сенсор суурилуулж, хог хаягдлыг цаг тухайд нь ачилт хийхэд дэмжлэг үзүүлсэн.<br>9. Орон зайн мэдээллийн сан<br>1240 POI цуглуулан, аялал жуулчлал, үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг системд нэвтрүүлсэн.<br>Энэхүү төсөл нь зөвхөн Дархан-Уул аймгийг жишиг дижитал аймаг болгох төдийгүй, Монгол Улсын бусад орон нутгийн цахим шилжилтийн жишиг загвар болж байна. Системүүдийн мэдээллийн урсгалыг нэгтгэж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлснээр төрийн үйлчилгээ иргэдийн өдөр тутмын амьдралд бодит үр өгөөж үзүүлж байгаа юм.<br>Үр дүн: 10 системийг шинээр нэвтрүүлж төрийн 17 байгууллага ашиглаж байна | | |
| 84 | | 5.3.1 Төрийн | | | | | Нутгийн захиргааны | | - | Төрийн албаны ерөнхий шалгалт: Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий | | |

<table>
<tr>
<td></td>
<td rowspan="2">5.3. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүнг дээшлүүлнэ.</td>
<td>албаны хүний нөөцийн чадавхыг сайжруулж, чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ.</td>
<td>2021-2025</td>
<td>-</td>
<td>Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх зарчмыг хэрэгжүүлнэ.</td>
<td>2020</td>
<td>байгууллага ас ирүүлсэн удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх албан тушаалын 62, туслах албан тушаалын 8 сул орон тооны судалгааг гаргасан.</td>
<td>Төрийн албаны тусгай шалгалтын дүн</td>
<td></td>
<td>шалгалтыг баталсан хуваарийн дагуу 2024 онд 4 удаа зохион байгууллаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 154 иргэн төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн бөгөөд нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо 156 аар нэмэгдсэн байна.
<table>
<tr><th>Д/д</th><th>Шалгалтын төв</th><th>Бүртгүүлсэн иргэдийн тоо</th><th>Шалгалт өгсөн иргэдийн тоо</th><th>Шалгалтад тэнцсэн иргэдийн тоо</th></tr>
<tr><td>1</td><td>2024.03.13</td><td>137</td><td>115</td><td>24/20%</td></tr>
<tr><td>2</td><td>2024.05.22</td><td>100</td><td>77</td><td>38/50%</td></tr>
<tr><td>3</td><td>2024.09.18</td><td>119</td><td>98</td><td>41/42%</td></tr>
<tr><td>4</td><td>2024.11.20</td><td>134</td><td>103</td><td>53/51%</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>490</td><td>393</td><td>156/40%</td></tr>
</table>
Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх сургалтыг 100 гаруй иргэнд 4 удаа зохион байгууллаа.<br>
Төрийн албаны тусгай шалгалт: Төрийн албаны зөвлөлийн Дархан Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс 2024 онд төрийн албаны тусгай шалгалтыг 11 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 292 сул орон тоог нээлттэй зарлаж Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагч болон төрийн албаны нөөцөд байгаа 253 иргэнээс албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагын дагуу сонгон шалгаруулж 72 иргэнийг нэр дэвшүүлж, 85 сул орон тоо нөхсөн байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар удирдах албан тушаалын-1, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн -4, дэс түшмэлийн-22, туслах түшмэлийн-3, нийт 36 сул орон тоо байна. Сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт зарлах захиалгыг Салбар зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 176 дугаар албан бичгээр захилга хүргүүллээ. Салбар зөвлөлөөс 2024 оны төрийн албаны тусгай шалгалтыг 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулна.<br>
Үр дүн: 2024 оны 11 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 292 сул орон тоог нээлттэй зарлаж 72 иргэнийг нэр дэвшүүлж, 85 сул орон тоог нөхсөн байна.</td>
<td>100%</td>
<td>90%</td>
</tr>
<tr>
<td>85</td>
<td>5.3.2 Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна.</td>
<td>2021-2025</td>
<td>-</td>
<td>Салбар зөвлөлийн харьяа 23 Ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангах, Ёс зүйн зөвлөлийн дүрэм боловсруулж, мөрдүүлнэ.</td>
<td>2020</td>
<td>Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлийн харьяа 23 Ёс зүйн зөвлөл, 76 хорооны гишүүд үйл ажиллагаа явуулж байна.</td>
<td>Салбар зөвлөлийн харьяа 23 Ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангах, Ёс зүйн зөвлөлийн дүрэм боловсруулж, мөрдүүлнэ.</td>
<td>-</td>
<td>Улсын Их Хурлын сахилга хариуцлагын байнгын хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төслийг хэлэлцүүлэн, төрийн байгууллагын 400 гаруй албан хаагчдыг оролцуулан сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 оны 05 дугаар сарын 04 ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад дээрх хуулийн төслийг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Салбар зөвлөлөөс шинээр батлагдсан хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд 2023 оны 10 дугаар сард "Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага" сэдэвт сургалтыг 26 төрийн байгууллагын 878 төрийн албан хаагчийг хамрууллаа.<br>
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан төрийн байгууллагын ёс зүйн хорооны ажиллах дүрэм, журам батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж 1200 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа<br>
2024 онд: Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, Найрамдал төслийн 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2024 оны 04 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд "Төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлага, ёс зүй" сэдэвт танхимын сургалтыг төрийн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүн нийт 64 төрийн албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, 16 цагийн 2 кредитийн гэрчилгээ олгов.<br>
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор "Ёс зүйн дэд</td>
<td>100%</td>
<td>70%</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>хорооны ажиллах журам"-ын хүрээнд 44 төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосон. Дархан-Уул аймгийн хэмжээнд 2024 оны эхний хагас жилийн дүнгээр аймгийн хэмжээнд 78 Ёс зүйн дэд хорооны 312 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.<br>Үр дүн: 2024 онд 64 ёс зүйн дэд хорооны гишүүдэд сургалт зохион байгуулж аймгийн хэмжээнд 44 төрийн байгууллагын 78 ёс зүйн дэд хороо байгуулагдаж 312 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td>86</td><td></td><td>5.3.3 Төрийн албан хаагчдыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч хөгжих орчныг бүрдүүлж, нийгмийн асуудлыг сайжруулна.</td><td>2021-2025</td><td>20.0</td><td>Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллага бүр "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ.</td><td>2020</td><td>4 сумын Засаг даргын Тамгын газар, 16 агентлаг, 25 цэцэрлэг, 10 ерөнхий боловсролын сургууль нийт 55 төрийн байгууллага төрийн албан хаагчид</td><td>Төрийн байгууллагууд сургалтын хөтөлбөрийг боловсруулж мөрдөнө.</td><td>20.0</td><td>2024 онд Удирдлагын Академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулдаг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийн чиглүүлэх 10, шинээр томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх багц 9, албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан 15, ахлах түшмэлийн багц 4, эрхэлсэн түшмэлийн багц 4, нийт 42 албан хаагчид хамрагдаж 9 албан хаагч байгууллагын зардлаар, 33 албан хаагч улсын төсвийн санхүүжилтээр суралцсан.<br>Үр дүн: Нийт 42 төрийн албан хаагч албан тушаалын тусгай шаардлага хангах мэргэжүүлэх сургалтад цахимаар хамрагдсан байна.</td><td>100%</td><td>70%</td></tr>
<tr><td>87</td><td></td><td>5.3.4 Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн жинхэнэ албан хаагчдыг шатлан дэвших зарчмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, Төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.</td><td>2021-2025</td><td>-</td><td>Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх зарчмыг хэрэгжүүлнэ.</td><td>2020</td><td>Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх албан тушаалын 62, туслах албан тушаалын 8 сул орон тооны судалгааг гаргасан.</td><td>Төрийн албаны тусгай шалгалтын дүн</td><td>-</td><td>Төрийн албаны ерөнхий шалгалт: Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг баталсан хуваарийн дагуу 2024 онд 4 удаа зохион байгууллаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 154 иргэн төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн бөгөөд нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо 156 аар нэмэгдсэн байна.
<table>
<tr><th>Д/д</th><th>Шалгалтын төв</th><th>Бүртгүүлсэн иргэдийн тоо</th><th>Шалгалт өгсөн иргэдийн тоо</th><th>Шалгалтад тэнцсэн иргэдийн тоо</th></tr>
<tr><td>1</td><td>2024.03.13</td><td>137</td><td>115</td><td>24/20%</td></tr>
<tr><td>2</td><td>2024.05.22</td><td>100</td><td>77</td><td>38/50%</td></tr>
<tr><td>3</td><td>2024.09.18</td><td>119</td><td>98</td><td>41/42%</td></tr>
<tr><td>4</td><td>2024.11.20</td><td>134</td><td>103</td><td>53/51%</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>490</td><td>393</td><td>156/40%</td></tr>
</table>
Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх сургалтыг 100 гаруй иргэнд 4 удаа зохион байгууллаа.<br><br><u>Төрийн албаны тусгай шалгалт:</u> Төрийн албаны зөвлөлийн Дархан Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс 2024 онд төрийн албаны тусгай шалгалтыг 11 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 292 сул орон тоог нээлттэй зарлаж Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагч болон төрийн албаны нөөцөд байгаа 253 иргэнээс албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагын дагуу сонгон шалгаруулж 72 иргэнийг нэр дэвшүүлж, 85 сул орон тоо нөхсөн байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар удирдах албан тушаалын-1, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн -4, дэс түшмэлийн-22, туслах түшмэлийн-3, нийт 36 сул орон тоо байна. Сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт зарлах захиалгыг Салбар зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 176 дугаар албан бичгээр захилга хүргүүллээ. Салбар зөвлөлөөс 2024 оны төрийн албаны тусгай шалгалтыг 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулна<br>Үр дүн: Төрийн албаны тусгай шалгалтыг 11 удаа зохион байгуулж</td><td>100%</td><td>70%</td></tr>
</table>

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | давхардсан тоогоор нийт давхардсан 292 сул орон тоог нээлттэй зарлаж, 72 иргэнийг нэр дэвшүүлж, 85 сул орон тоо нөхсөн байна. | | |
| 88 | 5.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. | 5.4.1 Шударга ёсыг бэхжүүлэх, авилгаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ | 2021-2025 | 3.0 | Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ | 2020 | Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 91.4% байна. | Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 94.4% хүргэнэ | 3.0 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:<br>2021 онд 98.42%-иар,<br>2022 онд 93.5%-иар тус тус үнэлэгдсэн.<br>2023 оныг Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх таван Ш ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд "НЭГДЬЕ" аяныг Дархан-Уул аймагт зохион байгуулж байна. Үүнд: Аймаг, сумын хэмжээнд төв зам дагуу 4 том зарын самбарт аннонс байрлуулж, 100ш зурагт хуудас, 10ш хөлтэй стикерийг багийн төвийн байр, автобусны буудал, томоохон худалдааны төвүүдэд байрлуулж видео шторкыг орон нутгийн телевизээр 3400 удаагийн давтамжтайгаар цацаж, цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүдийг 64300 орчим иргэнд хүрсэн ба хэрэгжилт 100%-ийн үнэлгээтэй байна.<br>"Шүүр ажиллагаа"-ны хүрээнд ЗГХЭГ-ын 2023 оны ХЭГ/595 тоот албан бичгээр ирүүлсэн 11 чиглэлээр хяналт, шалгалт хийж нийт 52 зөрчил илэрсэн. Үүнээс хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон, хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргээ биелүүлээгүй 8 зөрчил илэрснээс 6 зөрчлийг арилгаж 2 зөрчлийг арилгах боломжгүй байна.<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн сүүлийн 3 жилийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 97.3%-н үнэлгээтэй байна<br>Дархан-Уул аймгийн 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж 3 зорилтын 20 арга хэмжээг http://khutulbur.iaac.mn/ цахим санд бүртгэж 2024 оны эхний хагас жилийн үнэлгээгээр 68.67%-иар үнэлэгдээд байна. 2024 оны жилийн эцсийн тайланг үнэлэх хугацаа болоогүй байна.<br>Үр дүн: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн сүүлийн 3 жилийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 97.3%-н үнэлгээтэй байна. 2024 оны жилийн эцсийн тайланг үнэлэх хугацаа болоогүй. | 100% | 90% |
| 89 | | 5.4.2 Төрийн бүх шатанд авилгы эсрэг хөтөлбөр хэрэгжүүлж, төр, иргэдийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ. | 2021-2025 | - | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүртээмж нэмэгдсэн байна | 2020 | 2020 онд 338 хүнд сургалт хийж, радио телевиз, лед дэлгэцээр 48 төрлийн шторк, подкастыг 2880 удаа, цахим хуудаснуудаар 20154 хүнд хүргэсэн. | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүртээмж нэмэгдсэн байна | - | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр<br>2021 онд 4 удаагийн сургалтаар 290 албан хаагчид,<br>2022 онд 10 удаагийн сургалтаар 1035 албан хаагч, иргэдэд, 2023 онд 11 удаагийн сургалтаар 548 албан хаагч, иргэнийг тус тус сургалтад хамруулсан.<br>Сурталчилгаа:<br>2021 онд орон нутгийн 9 хэвлэл мэдээллийн хэрэгслээр тв шторк, инфографик, нийтлэл, теле зохиомж, зурагт хуудас, цахим ном зэргийг нийт 9877 удаагийн давтамжтай цацаж давхардсан тоогоор 960.177 хүнд мэдээлэл өгсөн.<br>2022 онд 2208 албан хаагч, иргэдийг сургалтад хамруулж, 22 шторкийн орон нутгийн телевизээр 110400 давтамжтайгаар, 45 мэдээ, шторкийг 18232 иргэнд түгээсэн.<br>2023 онд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан аян, арга хэмжээний хүрээнд шинээр бэлтгэсэн шторкыг орон нутгийн телевизээр 3400 удаагийн давтамжтайгаар цацаж, цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүд 64300 орчим иргэнд хүрсэн байна.<br>Бусад:<br>Дархан-Уул аймгийн ЗДТГ болон Хонгор сумын ЗДТГ-аас санаачлан "Дэвжээ" тэмцээнийг 2022 онд 7 байгууллага, 2023 онд 8 байгууллагын дунд зохион байгуулсан.<br>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Нэгдсэн Үндэсний байгууллагаас гаргасан "Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье" уриан дор соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулж ЕБС-ийн ахлах ангийн 300 сурагчид, 40 иргэн хамрагдлаа.<br>2021-2023 онд 25 удаагийн сургалтаар 1873 албан хаагчид сургалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, шторкийг орон нутгийн телевиз, цахим сүлжээнд 123,677 удаагийн давтамжтайгаар, цахим сүлжээнд байршуулсан постер, мэдээллийг давхардсан тоогоор 1,042,709 хүн үзсэн хандалттай байна. 1 өдөрлөг, 2 тэмцээн, 3 контент хийж бүтээсэн.<br>2024 онд давхардсан тоогоор нийт 4190 хүнийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан. Үүнд:<br>- 818 Төрийн албан хаагч<br>- 2058 ЕБС-ын сурагч<br>- 529 Оюутан<br>- 785 ААНБ-ын албан хаагчдыг хамруулсан.<br>Арга хэмжээ: Авлигыг үл тэвчих үзэл, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх хандлага, шүгэл үлээх, мэдээлэх соёлыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэх зорилготой 2024 онд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд: | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 1. Подкаст нэвтрүүлэг - Соён гэгээрүүлэх, Урьдчилан сэргийлэх, ажлын ач холбогдлын талаар подкаст нэвтрүүлэг бэлтгэж олон нийтийн сүлжээнд байршуулж 689 хүний хандалттай байна.<br>2. Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан "Үл тэвчье, үл эвлэрье" яруу найргийн наадмыг зохион байгуулж шилдэг 4 байрыг шалгаруулан нийт 1,8 сая төгрөгийн шагнал гардуулсан.<br>3. Товш аппликейшнд Дархан-уул аймгийн төрийн 68 байгууллагын мэдээллийг байршуулж эдгээр байгууллагуудаар үйлчлүүлэхэд тулгардаг асуудал, хүндрэлүүдийг цаг тухай бүр үнэлэх, үйлчилгээг сайжруулах боломж бий болсон.<br>Үр дүн: 2024 онд давхардсан тоогоор нийт 4190 хүнийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан. | | |
| | **6. Зургаа "Ногоон хөгжил"** | | | | | | | | | | |
| 90 | 6.1. Усны нөөц, чанарын хяналтыг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зөв зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлнэ. | 6.1.1 Судалгаанд үндэслэн цэнгэг усны нөөц, голын урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтад авна. | 2021-2025 | 27.8 | Цэнгэг усны нөөц, голын урсац бүрэлдэх эхийг хамгаална. | 2020 | 1 булаг шандын эхийг хашаажуулсан | 4 булаг шандын эхийг тохижуулна. | ОНТ, ААН-ийн хөрөнгөөр<br>27.8 | 2021-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр 1, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4, ТББ-ын санаачилгаар 1 нийт 6 булаг, шандыг 47,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулсан<br>2023 онд Хонгор сумын 2 дугаар багийн нутаг Могойн голын дээд болон доод булгийг Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК-иуд тус тус тохижуулсан.<br>Дархан сумын Малчин багийн нутаг Дархан-2 өртөөний орчимд байрлах Уужим булгийг Монголын эмэгтэйчүүдийн манлайлал сан төслөөс санхүүжүүлэн Дархан сумын ахмадын хорооны эмэгтэй манлайлал ТТБайгуулагаас тохижуулсан.<br>2024 онд Хонгор сумын 2 багийн нутаг Хургадын амны булгийг Монголын эмэгтэйчүүдийн манлайлал сан төслөөс санхүүжүүлэн Дархан сумын ахмадын хорооны эмэгтэй манлайлал Төрийн бус байгуулга, Хар бэлчрийн ар булгийг Дархан дулааны цахилгаан станц ТӨХК нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд дэмжлэг үзүүлж 2 булгийг тохижуулах ажлыг хамтран зохион байгуулж ажилласан.<br>Үр дүн: 2024 онд 2 булаг шандын эхийг хамгаалснаар усны эх үүсвэрийг хамгаалах нөхцөл бүрдсэн. | 100% | 100 % |
| 91 | | 6.1.2 Бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах зорилгоор ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | 57,513.0 | Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг шинэчлэн байнгын ашиглалтад оруулна. | 2020 | Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. | Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийн дахин ашиглалт нэмэгдэнэ. | 39,547.1 | Дархан хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажил ашиглалтад орсноор лагийн иж бүрэн боловсруулалттай, /лагийг усгүйжүүлэх, хатаах/ биологийн 3-р шатны цэвэрлэгээтэй иж бүрэн цэвэрлэх байгууламж болох юм. Дархан сумын Малчин багт байрлах цэвэрлэх байгууламжийн ойролцоо байдаг Хүдэр боловсруулах үйлдвэр нь өөр дээрээ гүний худагтай "Дархан-Ус суваг" ХК-ийн шүүх талбайн картыг ашиглах гэрээтэй. Шаардлага гарсан үед биопрудын талбайн уснаас авч ашиглаж байна. Ашигласан, хэрэглэсэн усаа дахин ашиглахын тулд шүүх талбайн картыг ашиглаж байна.<br>Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл нь үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. 1.А1 багцын гүйцэтгэл 100%-тэй, 2. А2 багцын гүйцэтгэл 100%-тай, 3. А3 багцын гүйцэтгэл 100%-ийн гүйцэтгэлтэй.<br>Төслийн хэмжээнд нийт гүйцэтгэл 100%-тай байна. Пфайфер Эмит түншлэлтэй 2022 оны 06 сард гэрээ цуцалж 2022 оны 10 сарын 26 өдөр Байгууламж ХХК-тай төслийн үлдэгдэл ажлыг хийж дуусгах шинэчилсэн гэрээг 12,926,000,246 төгрөгийн үнийн дүнтэйгээр гэрээ байгуулсан.<br>Үр дүн: Дархан төв цэвэрлэх байгууламж бүрэн шинэчлэгдсэн, Орхон сумын төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажил хийгдсэн. Бичил үйлдвэр үйлчилгээг дэмжих төслийн хүрээнд 5 автомашин угаалгын газарт саарал усыг дахин ашиглах төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдэж байна. | 100% | 90% |
| 92 | 6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаж, нөхөн сэргээнэ. | 6.2.1 Ашиглалтын улмаас эвдэрсэн газруудыг үе шаттай нөхөн сэргээнэ. | 2021-2025 | - | Ашиглалтын улмаас эвдэрсэн 9 га газрыг үе шаттай нөхөн сэргээнэ. | 2020 | Эвдэрсэн 587.2 га талбай байгаагаас эвдэрч эзэнгүй орхигдсон нийт 375.3 га талбай байна. | Эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн ажлыг 80 хувьд хүргэнэ. | 24,8 | 2022 онд Экомайнинг ассесмент ХХК нь орон нутгийн төсвийн 24,8 сая төгрөгөөр техникийн нөхөн сэргээлт хийсэн 3 га талбайдаа биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, 3000 ширхэг улиас, бургас, агч модыг тарьж, хашаажуулан хүлээлгэн өгсөн.<br>Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 20,0 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар уул уурхай болон бусад үйл ажиллагаанаас эвдэрч эзэнгүй орхигдсон 1 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг Шарын гол сумаас ирүүлсэн газрын саналын дагуу техникийн тодорхойлолтыг боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын газраас 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ний өдөр хүртэлх хугацаанд нээлттэй зарласан боловч нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхээр аж ахуйн нэгж байгууллагууд саналаа ирүүлээгүй. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлын төсвийг нэмэгдүүлж<br>2023 онд аймгийн хэмжээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар эвдэрч эзэнгүй орхигдсон 3 га талбайн нөхөн сэргээлтийг 60.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр тендер зарласан боловч оролцогч ирээгүй учир хэрэгжээгүй.<br>2022 онд Аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8, бичил уурхайн нөхөрлөл 4, түгээмэл тархац болон шохойн чулуу | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | чиглэлээр 4, нийт 16 аж ахуйн нэгжүүд техникийн 35,84 га, биологийн 6 га, дүйцүүлэн хамгааллаар 40,39 га, нийт 82,23 га талбайд нөхөн сэргээлт хийгдсэн.<br>2024 онд БОАЖЯамны сайдын Б.Бат-Эрдэнэ дэмжлэгтэйгээр "Оюу толгой ХХК"-тай 2023 оны 12 сард тус аймгийн Хонгор сумын нутагт орших Их ноёны ам, Бага ноёны ам, Хургадын ам, Шарын гол сумын нутагт орших Цагаан хөтөл орчмын 4 байршилд нийт 215.5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх тухай гэрээ байгуулж 2024 онд Хонгор, Шарын гол сумын нутагт 4 байршилд нийт 215,5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдэх ажил гүйцэтгэсэн. Тус нөхөн сэргээлтийн ажлыг "Бугант нандин" ХХК 91,6 га, "Дархан-Транс" ХХК 123,92 га хийж 100 хувийн гүйцэтгэлтэйгээр орон нутагт актаар хүлээлгэн өгч, эвдэрсэн газрын цахим санд оруулсан.Цаашид нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг даргын Тамгын газарт чиглэл хүргүүлсэн.<br>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 9 аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрлийн талбайд техникийн нөхөн сэргээлтийг 56,71 га, биологийн нөхөн сэргээлтийг 10,5 га талбайд, дүйцүүлэн хамгаалах хүрээнд 6 ААНэгж нь 15.75 га талбайд техникийн, авто замын барилгын ажилд ашигласан карьерын 49.64 га техникийн, орон нутгийн төсөв хөрөнгөөр эвдэрч орхигдсон газарт хийгдсэн 2 га техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгэсэн. 2024 онд нийт техникийн нөхөн сэргээлт 339.62 га, биологи нөхөн сэргээлт 10.5 га талбайд хийж гүйцэтгэсэн байна.<br>Үр дүн: 2024 онд техникийн нөхөн сэргээлтийг 339.62 га талбайд хийснээр эвдэрсэн газрын бүртгэлд бүртгэгдсэн талбайн хэмжээ 24,2 хувиар буурсан. | | |
| 93 | | 6.2.2 Байгаль орчны хууль тогтоомж, стандарт хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана. | 2021-2025 | 12.0 | Байгаль орчны хууль тогтоомж, стандарт хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгааллын ажилд иргэдийн оролцоог 5 хувиар нэмэгдүүлнэ. | 2020 | Байгаль орчны хууль тогтоомж, стандарт хэм хэмжээг нийт 53000 иргэдэд сурталчлан мөрдүүлсэн. | Иргэдийн оролцоог 14 хувиар нэмэгдүүлнэ | 12.0 | Аймгийн хэмжээнд нийтийг хамарсан ажил зохион байгуулахаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран ой, хээрийн түймрийн цагийн байдлыг шуурхай мэдээлэх үүрэг бүхий ажил хөдөлмөр эрхлээгүй 31 иргэнтэй түймрийн эргүүлээр ажиллах гэрээ байгуулж ухуулга, сэрэмжлүүлгийг 31 чиглэлд хийж байна. Дархан-Уул аймгийн хэмжээнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх чиглэлээр аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хонгор, Шарын гол сумдын Засаг даргын Тамгын газруудтай хамтран 18 удаагийн нэгдсэн хяналт шалгалтыг явуулж, орон нутгийн төсвөөс 1,4 сая.төгрөгийг зарцуулсан. Жил бүр хавар, намрын улиралд сүүлийн 7 жил хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчилгүй ажилласан 4 нөхөрлөлийн 7 идэвхтэн байгаль хамгаалагчийг шагнаж урамшуулсан. Мөн "Найрамдлын Дархан" тэмдгээр 1 идэвхтэн байгаль хамгаалагчийг шагнаж урамшуулсан. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх чиглэлээр нийт 9,3 сая төгрөгийг зарцуулаад байна.<br>2023 онд 30 иргэнийг түймрийн эргүүлээр ажиллуулж ХХҮГазартай хамтран гүйцэтгэж, түймрийн эргүүлд ажилласан иргэдийг 30,0 сая. төгрөгөөр урамшуулсан.<br>**Нийт** 30 чиглэлд 91 иргэн ойн түймрийн эргүүлээр ажиллаж иргэдийн оролцоог 15 хувьд хүргэсэн.<br>2024 онд Хуурайшилтын улиралд эргүүл, хяналт шалгалт, бэлтгэл бэлэн байдлыг шалгах, урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааг 4 удаа зохион байгуулж, 32 иргэн, ойн санд байгаа 47 айл өрх, 56 ойн нөхөрлөл, 3 аж ахуйн нэгжтэй уулзаж нийт 1035 км газар нутгийг хамруулсан байна. Сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн нийт 3 бүлэг 30 алба хаагч, 3 автомашин, техник хэрэгсэлд бэлэн байдлын үзлэгээр бэлэн байдал 90 хувьтай хангагдсан. "Түймрийн эргүүл-2024" төсөлд 30 иргэн хамрагдаж, цагийн байдлыг шуурхай мэдээлж ажилласан. Хавар, намрын хуурайшилтын улиралд ойд үйл ажиллагаа явуулах үйл ажиллагааг аймгийн Засаг даргын шийдвэрээр түр зогсоон сумын БОХУБ, байгаль хамгаалагч нарт шатахууны түймрийн эргүүлээр ажиллах 1,1 сая.төгрөгийн шатахууны зардлыг олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.<br>Үр дүн: 2024 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээг 4 удаа зохион байгуулж, 35 иргэн ААН, 47 айл өрх, 56 ойн нөхөрлөлийн нийт 1035 км газар нутгийг хамруулснаар ойн хээрийн түймэр гараагүй. | 100% | 100 % |
| 94 | | 6.2.3 Хөрсний үржил, шим чийгийг | 2021-2025 | 47.0 | Навчит болон шилмүүст модны ойжуулалтыг | 2020 | Ойжуулалт 21 га | Үржил шимтэй газрыг | 47.0 | 2022 онд аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн 45,7 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хонгор сумын 2 дугаар багийн нутаг Бухтын нарийн гэх газрын 10 га талбайд 17000 ширхэг шилмүүст модыг тарьцаар ойжуулж, Орхон | 100% | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамгаалж, цөлжилтөөс сэргийлэн ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | | | 132га талбайд хийнэ. | | талбайд хийгдсэн. | хамгаалж ойжуулалтын ажлыг 122 га талбайд хийнэ. | | сумын Овоотын энгэрт 3 га талбайд 1460 ширхэг хайлаас, бургас модоор ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгүүлсэн.<br>Дархан-Шарын гол чиглэлийн 3 дугаар хэсгийн 3,5 км авто замын трасст орсон нарс модыг чөлөөлүүлж, Хонгор сумын 2-р багийн нутаг Хүрэн манжинт гэх газар 1 га талбайд 4540 ширхэг шилмүүст модны тарьцаар ойжуулахаас өнөөдрийн байдлаар 2000 ширхэг шилмүүст модны тарьцыг суулгасан.<br>Аймгийн хэмжээнд 1.2 сая.ширхэг тарьц, суулгац мөчир, 7 нэр төрлийн модлог ургамлын 37 кг үрийн нөөцтэй байна.<br>2023 онд навчит модны суулгацаар хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Орхон сумын Шарын адаг 2 га, Хонгор сумын Цагаан нуур орчмын Хүйтний голд 2 га нийт 4 га талбайд 3200 ширхэг мод тарих ажлыг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын 45,7 сая.төгрөгийн хөрөнгөөр бургас, хайлаас модоор ойн зурвас байгуулсан. Мөн орон нутгийн 52,0 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар 42 га талбайд шилмүүст модны 86,0 мян.ширхэг тарьцаар ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.<br>УТТ хөрөнгөөр байгалийн сэргэн ургалтад дэмжих ажлыг 50 га талбайд ойн мэргэжлийн байгууллагууд шан татаж зурвас гаргах, хөрсний өнгөн хэсгийг хуулж талбар гаргах, хөрсийг сийрүүлэх, уг талбарт нарс, хусны үр суулгаж хөнгөн хөрсөөр хучих аргаар гүйцэтгэсэн.<br>2024 онд доройтсон ойг нөхөн сэргээх чиглэлээр 50 га талбайд 114,7 мянган.ширхэг мод бут, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, тариалангийн талбайн 41 км бүхий талбайг элсний нүүлтээс хамгаалах, 2 га талбайд ойн зурвас байгуулахаар 130,3 мянган ширхэг хайлаас, улиас зэрэг мод, бутыг тарьж ургуулсан. Үр дүн: 2024 онд цөлжилтөөс сэргийлэн ойжуулалт, ойн зурвас байгуулсан талбай хэмжээ 52 га-аар нэмэгдэж, тариалангийн 41 км талбайд ойн зурвас байгуулснаар ойжуулсан талбайн хэмжээ 2102 га-аар нэмэгдсэн. | | % |
| **Зорилт 6.3. *Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлнэ.*** | | | | | | | | | | | | |
| 95 | 6.3. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлнэ. | 6.3.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна. | 2021-2025 | 21.1 | Уур амьсгалын хуурайшилтыг бууруулж, цаг агаарт зориудаар нөлөөлж, агаарын чанар, бохирдлын хэмжээнд тогтмол хяналт тавина. | 2020 | Цаг уурын мэдээ мэдээллийг 1, 5, 7 хоног бүр цахим сайтууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэлээ. | Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналтыг сайжруулж тухай бүр иргэд, олон нийтэд мэдээлэх Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг 15-с доошгүй удаа зохион байгуулна. | 21.1 | "ЦАГ АГААР" аппликеишний АНХААРУУЛГА МЭДЭЭ цэсэд 19 өссөн дүнгээр нийт 52 мэдээг цахимд байршуулж иргэдэд сэрэмжлүүлэг өгөх арга хэмжээг 100% хэрэгжүүлсэн. Олон нийтэд нийт 8994 мэдээллийг багцын мессеж үйлчилгээгээр шуурхай хүргэсэн.<br>1. Дархан, Шарын гол сумдад агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 5-6 мкг/м$^3$, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 19-22 мкг/м$^3$ буюу MNS4585:2016 стандартын нэг удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй байна.<br>Хуучин Дарханд **PM10** тоосонцрын дундаж агууламж 43мкг/м$^3$ буюу бага бохирдолтой, **PM2.5** тоосонцрыг дундаж агууламж 85мкг/м$^3$ байна. MNS4585:2016 стандартын хоногийн дундаж хүлцэх агууламжаас 157 буюу нийт хэмжилтийн 60.6%-д давж бохирдон агаарын чанарын индексийн үнэлгээгээр их бохирдолтой түвшинд байсан. Агаарын чанарын мэдээллийг https://map.purpleair.com/ сайтаар мэдээлсэн.<br>2. 2024 оны 11 сарын байдлаар анхааруулга мэдээ 143, сэрэмжлүүлэг мэдээ 17, урьдчилан сэргийлэх мэдээ 1 нийт 161 мэдээг https://www.darkhan-uul.tsag-agaar.gov.mn/ сайт, /darkhantsaguur.mn фэйсбүүк пэйж хуудас, багцын месеж үйлчилгээгээр 7102 удаа мэдээлсэн.<br>2024 оны зуны улиралд цаг агаарын хуурайшилтай үед 2 удаа цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулж байгалийн жамаар орох хур тунадсыг 6.2мм-ээр нэмэгдүүлж 22.8-45.6мм бороо орсноор хуурайшилтын зэрэг буурч ой хээрийн түймэр гарах эрсдэлийг бууруулсан.<br>Үр дүн: 2024 онд 2 удаа цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулж хур тунадсыг 6.2мм-ээр нэмэгдүүлсэн. | 100% | 100 % |
| 96 | | 6.3.2 Ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | 2021-2025 | - | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Байгаль, орныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжих төсөл, арга хэмжээний худалдан авах | 2020 | БОХНСАХЗ санхүүжих 262.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй, 2.4 сая төгрөгийн хэмнэлттэй, | Байгаль, орныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг | .- | ОНӨГ-ын 2021-2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 382,193.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56, өвсний үндэс төслийн хүрээнд хэрэгжих 615.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 18,691.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,782.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,062.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, БОХНСАХЗ-аар санхүүжигдэх 654.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс давхардсан тоогоор 316 удаагийн тендер сонгон шалгаруулалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй, 2,783.0 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна.<br>2021-2023 онд 409,914.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 567 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 2,783.0 сая төгрөгийн хэмнэлтийг гаргасан. | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаар 100 хувь зохион байгуулна. | | үр ашигтай зохион байгуулсан. | 100 хувь зохион байгуулна | | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 425,9 сая.төгрөгийг батлуулж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын 170,6 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1374 ширхэг шилмүүст модыг худалдан авч, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. 2024 онд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжих 1,346.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 735.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан. Шинээр эхлэх 17 төсөл арга хэмжээнээс 4-н төсөл арга хэмжээг Худалдан авах ажиллагааны газраар дамжуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан.<br>Үр дүн: Уул уурхайн болон бусад үйл ажиллагаанаас эвдэрч эзэнгүй орхигдсон 2га газарт нөхөн сэргээлт хийх, Шилмүүст модны тарьц худалдан авах /Аймгийн хэмжээнд/, Ойн зурвас байгуулах, Биологийн төрөл зүйлийн нэгдсэн судалгаа /Аймгийн хэмжээнд/ гэсэн 4-н төсөл арга хэмжээг ХААГ дамжуулан тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. | | |
| 97 | | 6.3.3. Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог дахин боловсруулах технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. | 2021-2025 | 100.0 | Хог дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулж, хувийн хэвшлийн оролцоотой хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж шиглалтад оруулна. | 2020 | Хог дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг, төсвийн ажлын даалгаврыг боловсруулсан. | Хог дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулагдсан байна. | 655.5 | 2024 онд БОУАӨЯ-ны сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/4005 тоот албан бичиг "Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт" батлах тухай журмын дагуу 11 төрлийн хог хаягдлыг эргүүлэн татуулах, ангилах, тээвэрлэх, эрх бүхий байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Үүнд тус журамд багтсан хуванцар сав суулга, түүхий эд, нийлэг уут түүхий эд, бүх төрлийн зай хураагуур, аккумлятор, шил лонх сав, химийн бодисын сав баглаа боодол зэргийг хариуцагч байгууллагууд эргүүлэн татах ажлаар төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тухайлбал "ТМЛ" хуванцар дахин боловсруулах үйлдвэр, Кока кола ХХК хамтран аймгийн хэмжээнд үүсдэг 600 тн хуванцар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах цуглуулах, улмаар өөрийн боловсруулах үйлдвэрт хүргэж дахин боловсруулах ажлыг хийж байна. Мөн "Электрокем" ХХК нь аккумлятор дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага бөгөөд аймгийн хэмжээнд үүсэх хаягдал аккумляторыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах ажлын хүсэлт ирүүлж, 3 байршилд аккумлятор цуглуулах ажил хийгдэж байна.<br>Дархан сумын нутаг Малчин багт байрлах бараат төвлөрсөн хогийн цэгийг шинээр байгуулах газрын байршлыг тогтоох, нүүлгэн шилжүүлэх, хуучин хогийн цэгийг ландфиллын аргаар дарж булшлах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/458 захирамжаар байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлаар шинээр байгуулах газрыг судалж, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, ТЭЗҮ боловсруулах, гидрогеологи хийлгэх ажлын зардлыг 2025 оны төсөвт тусгуулахаар ажиллаж байна<br>Үр дүн: 2024 онд хог хаягдлаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Бараат хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх газрын байршлыг тогтоож, ТЭЗҮ, гидрогеологи хийлгэх боломж бүрдээд байна. | 50% | 70% |
| | **ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ** | | | | | | | | | | | |
| 98 | 7.1. Нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгийн | 7.1.1 Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг сайжруулна. | 2021-2025 | - | Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системтэй болно. | 2020 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 54.0%-тай байна. | 2021-2025 | Дархан сумын 1, 2, 6, 10 дугаар багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулна | 1."Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын заавар"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор буудлага үйлдэх байгууламж (тир) байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж, 2.3 тэр бум төгрөгийн ажлын зураг, төсөв хийгдсэн.<br>2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шарын гол сумын Хайрхан багт 18.2 сая төгрөгөөр 3, Санжинт багт 18.7 сая төгрөгөөр 3, Дархан багт 16.6 сая төгрөгөөр 2 ширхэг шөнийн хараат, H.264 нягтралтай дэвшилтэт технологи бүхий 23xIP камерыг иж бүрнээр нь, Дархан сумын 15 дугаар багт 10.0 сая төгрөгөөр 360 градусын эргэдэг, өндөр нягтрал бүхий 3, мөн сумын 4, 7 дугаар багт байрлах нүхэн гарцуудад 13.0 сая төгрөгөөр 8 ширхэг, нийт 76.6 сая төгрөгийн 19 камерыг суурилуулж ашиглалтад орууллаа.<br>3. Төрийн үйлчилгээний хяналтын нэгдсэн системийн хяналтын 22 камер гэмтлийг засварлахад аймгийн төсвөөс 17.2 сая, Шарын гол суманд 25 хяналтын камерыг засварлах, шинээр 6 камер суурилуулахад 6.8 сая төгрөгийг тус тус гаргаж зарцууллаа.<br>Ногоон бүс төслийн хүрээнд Дархан сумын 4, 5, Өргөө багийн нутаг дэвсгэрийн 80 цэгт 125 хяналтын камерыг 371.0 сая төгрөгөөр, Дархан сумын 10, 13, 14, 16 дугаар багийн нутаг дэвсгэрийн 90 цэгт 167 хяналтын камерыг 550.0 сая, Шарын | 90% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрсдэлийг бууруулна. | | | | | | | | | гол сумын нутаг дэвсгэрийн 11 цэгт 16 хяналтын камерыг 100.0 сая төгрөгөөр, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь хэсэгт "Барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник, хэрэгслийг Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбож, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих" гэж заасны дагуу Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох 4.9гГц-ийн утасгүй сүлжээний баазыг 5 байршилд 116.0 сая төгрөгөөр тус тус байгуулж ашиглалтад хүлээн авсан.<br>Үр дүн: Дархан сумын 4,5, Өргөө, 10, 13,14,16-р багт Ногоон бүс төсөл хэрэгжсэн. | | |
| 99 | | 7.1.2 Мансууруулах эм, ургамал, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавьж, зохисгүй хэрэглээнээс урьдчилан сэргийлнэ. | 2021-2025 | 45.0 | Устгал арга хэмжээ, сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | 2020 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж нийт 23 хүн холбогдон шалгагдсан, | Хар тамхины төрлийн ургамлын тархацыг шинэчлэн тогтоож, тархацийг бууруулна. | 20.0 | **Сургалт:**<br>2021 онд 6 удаагийн сургалтаар 325 хүнд, 2022 онд 7 удаагийн сургалтаар 477 хүнд, 2023 онд 4 удаагийн сургалтаар 2145 хүнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.<br>2024 онд Дархан-Уул аймгийн ГХУСАЗСЗ-өөс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, мансуурах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр томоохон аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан алба хаагчдад сургалтыг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Давж заалдах шатны Шүүх, Прокурорын газар, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын төлөөллийг оролцуулан 4 ажлын хэсгийг байгуулан УБТЗ-ын Дархан Өртөө, Татах хэсэг, Дархан хүнс ХХК, "Дулааны цахилгаан станц" ТӨХК зэрэг 15 томоохон аж ахуйн нэгжийн 785, ерөнхий боловсролын 17 сургуулийн 2030 сурагч, 7 Их дээд сургуулийн 487 оюутанд, нийт 3302 ажилтныг хамруулж танхимаар болон цахимаар сургалт зохион байгуулсан.<br>"Каннабис" буюу зэрлэг олсны ургамал аймгийн хэмжээнд тархан ургадаг 485 га талбайд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хооронд сонгомол үйлчилгээтэй Балерина супер, Грейдер, Алманзис, Зонтран төрлийн хорнуудыг ашиглаж явууллаа. Устгал 2024 нэгдсэн арга хэмжээний зардал 29.9 сая төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас гаргаж санхүүжүүлсэн.<br>Орон нутгийн DBS телевизийн Дарханы мэдээ мэдээллийн хөтөлбөрт Цагдаагийн газрын мэргэжилтнүүд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн талаар ярилцлагад орж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгсөн.<br>2024 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 17 үйлдэгдэн гарсан нь өмнөх оны мөн үеэс 7-оор буюу 70 хувиар өссөн.<br>Үр дүн: 485 га талбайд сонгомол үйлчилгээтэй хорнуудыг ашиглан хар тамхины төрлийн ургамлын тархцыг бууруулах ажлыг зохион байгуулж, 29.9 сая төгрөг зарцууллаа. | 100% | 100 % |
| 100 | | 7.1.3 Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулна. | 2021-2025 | 10.0 | Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээнд хамруулах, нөхөн сэргээх, үүрэг хүлээгчдийг чадавхжуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 2020 | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 18 арга хэмжээ, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, 75 удаагийн сургалт явуулж, 3500 гарын авлага, зөвлөмж тараасан. | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх , сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | 10.0 | Цагдаагийн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар зэрэг байгууллагууд хамтран "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Эрүүл мэндийн газартай хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчиж баривчлагдсан 247 хүнд 44 цагийн албадан сургалтыг зохион байгуулж, зөрчил гаргасан этгээдтэй ганцаарчилсан уулзалт хийж, судалгаанд авч, зөвлөмж өгч ажиллалаа.<br>Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх зорилгоор орон нутгийн DBS телевиз, нийтийн сүлжээгээр "Эрүүл гэр бүл зөв ухамсраас эхлэлтэй" уриалга гаргаж, шторкийг түгээж 430 иргэнд таалагдаж, 26 хүн сэтгэгдэл бичиж, 133 удаа хуваалцаж, 11500 иргэн үзэж сонирхлоо.<br>Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн "DBS" телевизтэй хамтран "Цагдаагийн газраас мэдээлж байна" нэвтрүүлгийг бэлтгэн түгээлээ.<br>"Хяналт-2024" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан шүүхийн шийдвэрээр баривчлагдсан 73 иргэн, удаа дараа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 6 иргэн, давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлсэн 6 өрхийг алба хаагчдад хуваарилан өгч нэг бүрчилсэн хяналт тавьж, хувийн хэргийг нээж баяжилтыг тогтмол хийн ажиллаж байна.<br>"Гэр бүл дэх хүүхэд хамгаалал, үр дүнтэй цаг", "Хүүхэд хамгааллын тухай хууль" сэдвээр 90 төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн 554 ажилтан, албан хаагчийг хамруулан сургалт зохион байгуулж, орон нутгийн 2 телевизээр сурталчиллаа.<br>"Найз байя" аяныг Цагдаагийн газар, Өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ерөнхий боловсролын 22 сургуулийн 5171 хүүхдийг хамруулан өөрийгөө болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан | 70% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | сэргийлэх, үе тэнгийн дээрэлхэлтэйг зогсоох зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа.<br>**Үр дүн: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх , сургалтад 5972 хүнийг хамруулж, 1 төрлийн уриалга шторкийг 11500 хүнд түгээлээ.** | | |
| 101 | | 7.1.4 Хууль хяналтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ. | 2021-2025 | 122.0 | Хууль, хяналтын байгууллагуудын ажлын байранд урсгал засвар үйлчилгээ хийж, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2020 | Тагнуулын газарт суудлын авто машин 1ш нийлүүлсэн. | Цагдаагийн газрын барилгын өргөтгөлийг барьж ашиглалтад оруулна. | 122.0 | 1. 2021 онд Цагдаагийн газрын спорт заалыг орон нутгийн сангийн 93.0 сая төгрөгийн хөрөнгөөр иж бүрэн засварлалаа.<br>Аймгийн архивын тасгийн хадгаламжийн санд 29.0 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр 4 ширхэг халаалтын радиатор тавьж, гадна хананд дулаалгын хөөс хийн, сан хөмрөгийн 2 өрөөний 3 цонхны резинийг сольж, хадгаламжийн санд 5 камер, хамгаалалтын дохиоллын систем 2-ыг тус тус суурилуулаа.<br>3. 2022онд Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн Цагдаагийн газрын төв байрны өргөтгөлийн ажлыг "Инерци" ХХК гүйцэтгэн Барилга, байгууламж шинээр ашиглалтад оруулан үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Дархан-Уул аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн 9.5 сая төгрөгийн санхүүжилтээр Шүүхийн шинжилгээний албанд эд эсийн шинжилгээний нарийвчлан харах гэрлэн микроскоп, 8.68 сая төгрөгийн санхүүжилтээр ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангийн баривчлах байрыг камержууллаа<br>4. Дархан-Уул аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс **шүүхийн байгууллагын шүүн таслах** ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, иргэд үйлчлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай соггуурал хэмжих багаж худалдан авахад 3.3, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулийн сургалт, сурталчилгаа явуулахад шаардагдах техник хэрэгслийн зардалд 18.8, нийт **22.1 сая Цагдаагийн албан хаагч** нарын үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах эмчилгээний зориулалттай массажны нэг ширхэг ор худалдан авахад 9.5, "Хүүхэд хамгааллын өрөө"-г засварлах, тохижуулахад 15.0, уулзалт, мэдүүлгийн 4 өрөөг засварлах 18.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийн шатахууны зардалд 3.0, бэлэн бус торгуулийн төхөөрөмжийн ашиглалтын зардалд 6.7, нийт **52.7 сая**, **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих** ангийн эргэлтийн байрыг тохижилтод **18.8** сая, **Шүүх шинжилгээний хэлтсийн** авто техникийн лабораторийн өргөтгөлд **17.2 сая**, **Прокурорын байгууллагаас** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, яриа таниулга, шалгалт, судалгаа хийх техник хэрэгсэл худалдан авахад **9.5 сая** төгрөгийг тус тус зарцууллаа.<br>5. Аймгийн төсвөөр төрийн үйлчилгээний хяналтын нэгдсэн системийн хяналтын камер гэмтлийг 17.2 сая төгрөгөөр засварлаж, аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар 26-ны өдрийн 01-А/151 дүгээр захирамжаар Цагдаагийн газар, ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангид компьютер, техник хэрэгсэл худалдан авахад тус бүр 10.0, Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байрыг засварлахад 10.0, нийт 30.0 сая төгрөгийг зарцууллаа. 2023 онд сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын орон нутаг дахь нэгж, албадад 11 удаагийн 167.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ.<br>2024 онд Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны 420.0 сая төгрөгийн барилгын өргөтгөл, их засварын ажлын тендерийг зарлаж "ДСЭМ сервис" ХХК шалгарч 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр ЦЕГ-тай гэрээ байгуулан өргөтгөлийн ажлыг эхэлсэн ба 2 давхрын өрлөг, бүс бетоныг тусгаж, дам нуруу, дээврийн төмрийг угсарч дууссан. Одоогийн байдлаар барилгын гэрэлтүүлэг, халаалт, цэвэр бохир усны шугам, холбоо, дохиоллын угсралтын ажил хийгдэж байна.<br>**Үр дүн: Өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна** | 90% | 90% |
| 102 | | 7.1.5 Аюулгүйн нөөц бүрдүүлэх, хуваарилах, зохицуулалт хийх, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулна. | 2021-2025 | 107.8 | Аюулгүйн нөөцийн өвс, тэжээл бүрдүүлэх | 2020 | Аймгийн аюулгүйн нөөцөд 120тн өвс, 25тн тэжээл бэлтгэсэн. | Аймгийн аюулгүйн нөөцөд 250тн өвс, 50тн тэжээл бүрдүүлэх | 70.8 | 2023 онд Монгол Улсын Засгийн газрын 279 дүгээр тогтоолоор аймаг 100 тн өвс, 50 тн тэжээл, сумд тус бүр 50 тн өвс, 25 тн тэжээлийн нөөц бүрдүүлэх ажиллахаас аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн 92,5 сая төгрөгөөр 100 хувь бэлтгэн байршуулсан байна. Аюулгүйн нөөц бүрдүүлэлтийг сумдаар авч үзэхэд Хонгор сум 50 тн өвс, 25 тн тэжээл 100 хувь, Орхон сумын 50 тн өвс, 5 тн тэжээл 60,0 хувь, Шарын гол сум 44 тн өвс, 20 тн тэжээл 84,0, Дархан сум 20 тн өвс, 7 тн тэжээл 34,0 хувийн биелэлттэй тус тус бүрдүүлсэн байна. Тус аймаг 4 сум, 12 баг, 31 хот айл, мал бүхий 2181 өрхөд хонин толгойд шилжүүлснээр 567.4 мянган толгой мал өвөлжиж хаваржлаа.<br>"Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 28 дугаар тогтоолын дагуу ХХААХҮЯ-ны Салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 2024.09.02-ны өдрийн 08-00- | 100% | 100 % |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 04/28 дугаартай удирдамжаар Орхон, Дархан, Шарын гол сумын ЗДТГ, Хөдөө аж ахуйн тасагт урьдчилан сэргийлэх шалгалт хийгдэж хамтран ажиллаа. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолоор аймаг 100 тн өвс, 40 тн тэжээл, сумдууд тус бүр 40 тн өвс, 25 тн тэжээл бэлтгэх даалгавартай байгаагаас Дархан, Хонгор сум 40 тн өвс, 25 тн тэжээл, Орхон сум 40 тн өвс, 6 тн тэжээл, Шарын гол сум 40 тн өвс, 20 тн тэжээл бэлтгэж аймгийн хэмжээнд өвсний нөөц бүрдүүлэлт 100%, тэжээлийн нөөц бүрдүүлэлт 86.4%-тай байна. Шалгалтаар нийт 63 зөрчил илрүүлж шалгалтын явцад 53 буюу 84.1%-ийг арилгуулав. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4 сумын Засаг дарга нарт хугацаатай албан шаардлага хүргүүлж гүйцэтгэлийн хяналтаар биелэлт 86.6%-тай байна<br>МУЗГ-ын 28 дугаар тогтоолын холбогдох 6 заалтын хэрэгжилт дунджаар 83.3%, Улсын нөөцийн тухай хуулийн 2 заалтын хэрэгжилт 40%, Ургамал хамгааллын тухай хуулийн 2 заалтын хэрэгжилт 100%-тай байна Аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцийн бүрдүүлэлт дунджаар 92.5%, Дархан-Уул, Орхон, Хонгор сумын шинжилгээнд хамрагдсан өвс нь лабораторийн сорилтын дүнгээр "Техникийн шаардлага MNS-2008" стандартын шаардлагыг хангаж байна Сумдын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтыг "Орон нутгийн болон улсын аюулгүйн нөөцөд өвс бэлтгэлтийг шалгах" 8.43 кодтой хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 2 их, 2 дунд эрсдэлтэй дүгнэгдэж гүйцэтгэлийн хяналтаар их болон дундаас бага эрсдэлд шилжиж эрсдэл 58.9%-иар буурсан байна Стандартын шаардлага хангасан өвс хүлээж авах, зориулалтын агуулахтай болох, хадгалалтад анхаарах, татаж аваагүй тэжээлийг 11 сард багтаан авах үүрэг өгсөн.<br>Үр дүн: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолоор аймаг 100 тн өвс, 40 тн тэжээл, сумдууд тус бүр 40 тн өвс, 25 тн тэжээл бэлтгэх даалгавартай байгаагаас Дархан, Хонгор сум 40 тн өвс, 25 тн тэжээл, Орхон сум 40 тн өвс, 6 тн тэжээл, Шарын гол сум 40 тн өвс, 20 тн тэжээл бэлтгэж аймгийн хэмжээнд өвсний нөөц бүрдүүлэлт 100%, тэжээлийн нөөц бүрдүүлэлт 86.4%-тай байна. | | |
| 103 | | 7.1.6 Гамшгийн үеийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадавхыг сайжруулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж хэвшүүлнэ. | 2021-2025 | 100.0 | Аж ахуйн нэгж байгууллагын чадавхыг сайжруулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийнэ. | 2020 | Гамшгийн эрсдлийн үнэлгээг 20 байгууллагад хийсэн. | 200 аж ахуй нэгж байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийнэ. | - | 2021 онд Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий 26 хуулийн этгээдийн жагсаалтыг аж ахуйн нэгж, байгууллагуудад Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч мэдээлж заавал биелүүлэх албан шаардлага 267, мэдэгдэл 361 ажиллаж байна. Одоогоор тус аймгийн хэмжээнд 4 байгууллагын гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хүлээн авч анхан шатны дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн хэмжээнд 2021 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 306 байгууллага хамрагдсанаас Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу 46 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газрын даргаар 33 төлөвлөгөөг баталгаажуулсан байна. 2022 онд ААНБ-аас ирүүлсэн 8 гамшгийн эрсдэлийн нарийвчилсан, үнэлгээний тайланд анхан шатны дүн шинжилгээ хийж, ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 352 байгууллага хамрагдсанаас Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу 31 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө хянаж гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч баталгаажуулан ажилласан байна. 2023 онд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх, тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий 33 аж ахуй нэгж байгууллагын мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын цахим хаягт байрлуулан ажилласан. ААНБ-аас ирүүлсэн 12 гамшгийн эрсдэлийн нарийвчилсан, үнэлгээний тайланд анхан шатны дүн шинжилгээ хийж, ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу 19 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө хянаж зөвлөн туслах заавар зөвлөгөө өгч баталгаажуулан ажилласан, 35 аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө хянаж гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж зөвлөн туслах заавар зөвлөгөө өгсөн. 2024 онд Аж ахуй нэгж байгууллага иргэдэд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ болон, ерөнхий үнэлгээ хийх заавар, аргачлал, тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын талаарх мэдээллийг өгч ажилласан.. ААНБ-аас ирүүлсэн 13 гамшгийн эрсдэлийн нарийвчилсан, үнэлгээний тайланд анхан шатны дүн шинжилгээ хийж, ОБЕГ-ын эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. Монгол | 90% | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоол Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж буй 71 аж ахуй нэгж байгууллагад заавар зөвлөгөө өгч 60 аж ахуй нэгж байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байна. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн нийт 60 байгууллагаас гал түймрийн эрсдэл ихтэй 22 байгууллага буюу 36,7 хувь эрсдэл ихтэй, 30 байгууллага буюу 50 хувь нь эрсдэл дунд, 8 байгууллага буюу 13.3 хувь нь эрсдэл багатай үнэлэгдсэн. Газар хөдлөлтийн эрсдэл ихтэй 32 байгууллага буюу 53.3 хувь, 13 байгууллага буюу 35 хувь нь эрсдэл дунд, 7 байгууллага буюу 11.6 хувь нь эрсдэл бага дүгнэгдсэн. Мөн хүчтэй шороон болон цасан шуурганы эрсдэл ихтэй 5 байгууллага буюу 8.33 хувь, 20 байгууллага буюу 33,3 хувь нь эрсдэл дунд, 35 байгууллага буюу 58.3 хувь нь эрсдэл багатай байна. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээнд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай хэрхэн төлөвлөх заавар зөвлөмжийг аж ахуй нэгж байгууллагын ажилтан алба хаагч нарт заавар зөвлөгөө өгсөн.Үр дүн: Нийт 209 аж ахуй нэгж байгууллагад эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна. | | |
| 104 | 7.2. Нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулна. | 7.2.1 Согтууруулах ундааны хэрэглээ, архидалтын улмаас хүн амын эрүүл мэндэд учирч байгаа хор уршгаас урьдчилан сэргийлэх | 2021-2025 | 4.2 | Архидан согтуурахтай тэмцэх сургалт сурталчилгааг зохион байгуулж, архины хамааралтай иргэнийг эмчилгээнд хамруулна. | 2020 | 2020 оны жилийн эцсийн байдлаар архи согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 3032 иргэн эрүүлжүүлэгдсэн. | Архидан согтуурахтай тэмцэх сургалт сурталчилгаа зохион байгуулж, архины хамааралтай 66 иргэнийг эмчилгээнд хамруулна. | 4.2 | **Сайн дурын болон албадан эмчилгээ:**<br>2021 онд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагтай хамтран 285 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулж 17 хүн архинаас татгалзсан.<br>2022 онд 25 иргэнийг албадан эмчилгээнд хамрагдсан бол Дархан-Уул аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2.6 сая төгрөгийн засвар үйлчилгээний төсвийг шийдвэрлэж Аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагт 6 ортой нэг өрөөг засаж тохижуулан 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлж 174 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулж 21 хүн архинаас татгалзсан.<br>2023 онд 10 иргэнийг албадан эмчилгээнд, аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагтай хамтран 220 иргэнийг сайн дурын эмчилгээнд тус тус хамруулж 15 хүн архинаас татгалзсан зэрэг үзүүлэлттэй. Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран эмчилгээнд хамрагдсан 4 хүнийг ажилд зуучлан хөдөлмөр эрхлүүлсэн.<br>2024 онд Төв аймгийн Баян сум дахь "Архины албадан эмчилгээний төв"-д 10 иргэнийг, архины архаг хэрэглээтэй болон орон гэргүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд "Жаргалтай амьдралын төв"-д 134 иргэнийг, Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийн сайн дурын эмчилгээнд 216, нийт 360 иргэн хамруулсан.<br><br>Сургалт, нөлөөллийн арга хэмжээ:<br>2021 онд 210 удаа эрүүлжүүлэгдсэн 1504 иргэнд, давхардсан тоогоор баривчлагдсан 945 иргэнд 1810 цагийн албадан сургалтыг, урьдчилан сэргийлэх сургалтыг 6 их, дээд, коллеж болон ЕБС-ийн 6751 гаруй оюутан, сурагчдад.<br>2022 онд 166 удаа давхардсан тоогоор эрүүлжүүлэгдсэн 650 иргэнд, баривчлагдсан 166 иргэнд 1810 цагийн албадан сургалтыг, урьдчилан сэргийлэх сургалтыг 10 их, дээд, коллеж болон ЕБС-ийн 7200 гаруй оюутан, сурагчдад.<br>2023 онд 298 удаа давхардсан тоогоор эрүүлжүүлэгдсэн 103 иргэнд, баривчлагдсан 465 иргэнд 4650 цагийн албадан сургалтыг, урьдчилан сэргийлэх сургалтыг 12 их, дээд, коллеж болон ЕБС-ийн 7800 гаруй оюутан, сурагчдад. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг нийт 140 аж ахуй нэгжүүдэд 18 удаагийн сургалтыг зохион байгуулсан.<br>2024 онд Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх саатуулах байр, Эрүүл мэндийн газар, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдсан иргэдэд 180 удаа, давхардсан тоогоор эрүүлжүүлэгдсэн 183, саатуулагдсан 202, баривчлагдсан 1432 иргэнд 520 цагийн албадан сургалтыг зохион байгуулаа. Сайн дурын эмчилгээнд 895 иргэн, албадан эмчилгээнд 179 иргэнийг хамруулж 53 хүн архинаас татгалзсан зэрэг үзүүлэлттэй. Эмчилгээнд хамрагдсан 4 хүнийг ажилд зуучлан хөдөлмөр эрхлүүлж байна. 8790 цагийн албан сургалтад давхардсан тоогоор 40650 иргэнд, 28 их дээд, коллеж болон ЕБС-ийн 21751 оюутан, сурагчдад сургалт хийсэн.<br><br>Сурталчилгаа: 17 зурагт хуудас, 8 богино хэмжээний шторк, зурагт хуудсыг 1542 ширхэг хэвлэж хүн ихээр цуглардаг газарт байрлуулсан. Та-Татгалз" арга | 100% | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хэмжээний хүрээнд 4*8м, 2.20*3.60м-ийн хэмжээтэй 4 ширхэг самбарыг бүтээж байрлуулсан.<br><br>Төрийн болон ТББ, иргэдийг татан оролцуулсан байдал: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд давхардсан тоогоор 37 төрийн байгууллага, 24 төрийн бус байгууллага, 397 ААНБ, 7656 иргэнийг татан оролцуулсан.<br>**Үр дүн: Архины сайн дурын болон албадан эмчилгээнд 360 иргэнийг хамрууллаа** | | |

**Тайлбар:**

/1/ "Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" –ийн зорилго, зорилт, арга хэмжээг бичнэ.
/2/ Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн жилийн зарцуулсан, зарцуулахаар төсөвлөсөн үйл ажиллагааны зардлын дүнг бичнэ.
/3/ Тухайн арга хэмжээ үр дүнд хүрсэн эсэхийг нотлохуйц шалгуур үзүүлэлтийг томьёолон бичнэ.
/4/ Арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх түвшинг харгалзах шалгуур үзүүлэлтийг томьёолон бичнэ.
/5/ Бодлогын зорилт, арга хэмжээний үе шатуудад хүрэхээр зорьж буй түвшинг харгалзах хугацааны хамт бичнэ.
/6/ Тухайн арга хэмжээний хэрэгжилтийн явцын талаар 2000 тэмдэгтэд багтаан тайлагнан бичнэ.
/7/ "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2 дахь хэсгийг үндэслэн тооцно.
/8/ Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээр ямар нэг арга хэмжээ аваагүй, авсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй, зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой судалгаа, шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр бичих ба энэ нь дараагийн шатны төлөвлөлтөнд харгалзан үзэх чухал үзүүлэлт болно. Үүнээс гадна тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой учирч буй хүндрэл бэрхшээл, хүндрэлийг засахтай холбоотой саналыг бичиж болно.

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХБТХОХ-ИЙН ДАРГА П.БАТСҮХ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭЖ, БОЛОВСРУУЛСАН

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГЧ Б.БАТСҮХ

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2024.12.16

| № | Бүлэг / Үнэлгээ | | Бүгд | Бүлэг 1 | Бүлэг 2 | Бүлэг 3 | Бүлэг 4 | Бүлэг 5 | Бүлэг 6 | Бүлэг 7 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хяналтанд авсан үйл ажиллагааны тоо | | 104 | 6 | 19 | 20 | 32 | 12 | 8 | 7 |
| 2. | Үнэлгээ, үүнээс | 100.0% | 82 | 6 | 15 | 16 | 22 | 12 | 7 | 4 |
| | | 90.0% | 8 | - | 1 | 2 | 3 | - | - | 2 |
| | | 70.0% | 11 | - | 2 | 2 | 6 | - | - | 1 |
| | | 50% | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| | | 30% | 2 | - | 1 | - | 1 | - | - | - |
| **Ерөнхий үнэлгээ** | | | **94.23% буюу 4.71 оноо** | **100% буюу 5.0 оноо** | **92.63% буюу 4.63 оноо** | **96.0% буюу 4.8 оноо** | **91.25% буюу 4.56 оноо** | **100% буюу 5.0 оноо** | **93.75% буюу 4.68 оноо** | **92.85% буюу 4.64 оноо** |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН